

АРИУН СҮНС

БИД
ШАТАМХАЙ
БАЙНА УУ ЭСВЭЛ
ГАЛД ТЭСВЭРТЭЙ
БАЙНА УУ?

РЕЙНХАРД
БОННКЕ

Хүндэт амь - аврагч нар минь

Энэхүү ном нь миний Ариун Сүнсний евангелизмын үйлчлэлийн өвийн нэгээхэн хэсэг болой. Энэ бол миний Эзэнд насан турш үйлчлэхдээ, Сүнсний сургуулиас сурсан эрдэм минь бөгөөд үүний ачаар хэдэн арван сая үнэт амь аврагдахыг бид харсан билээ.

Бурхан ялгаатай бидэнд Ариун Сүнсээ ялгаварлалгүйгээр, сүр жавхлантайяа цутган байна! Тэрбээр Өөрт нь нээлттэй сав бүрт Өөрийгөө цутгаж байх шиг. “Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ бүх махбод дээр цутгана.” Бид Библи тэй маргашгүй. Бид Библийн баталгаат бүтцэд бүрэн найдна. Библи бол хөдлөшгүй баталгааг тээсэн мэдээ мөн. Библи өөрөө өөрийгөө баталгаажуулдаг. “Бурханы амьд, оршин буй үгээр...” (1Петр 1:23) хэмээн элч Петр өгүүлсэн бөгөөд энэ үг нь амьд үнэн тул оршоор байх болно.

Энэ “өв” - ном нь танд барих миний өчүүхэн бэлэг билээ. Нэг бус, харин ахин дахин уншаад, зүрхэнд туссан хэсгээ тэмдэглэж аваарай. Зүрх, сүнсэндээ эрдэнэ мэт нандигнаарай. Энэ нь таныг Есүсийн төлөө амьдрахад чинь үр жимстэй дөт замаар дагуулна.

Монгол улсыг Бурхан ерөөг! Би та бүхний төлөө залбирна.

Есүс Христийн нэрээр,



Сайн мэдээ дэлгэрүүлэгч Рейнхард Боннке

CfaN CHRIST
FOR ALL NATIONS
CfaN.org



АРИУН СҮНС

**БИД
ШАТАМХАЙ
БАЙНА УУ ЭСВЭЛ
ГАЛД ТЭСВЭРТЭЙ
БАЙНА УУ?**



Номоо уншихаасаа өмнө гартаа тодруулагч бариад,
унших явцдаа зүрхэнд туссан илчлэлээ
зурж тэмдэглэнэ үү.

Өө, бас нэгэн хүсэлт байна.
Та энэ номоор ерөөгдсөн бол,
заавал бусдад дамжуулж, танилцуулж, дуулгаарай.

A handwritten signature in blue ink, reading "Richard P. Smith". The signature is written in a cursive style and is underlined with a single horizontal stroke.

АРИУН СҮНС

**БИД
ШАТАМХАЙ
БАЙНА УУ ЭСВЭЛ
ГАЛД ТЭСВЭРТЭЙ
БАЙНА УУ?**

РЕЙНХАРД
БОННКЕ

CFAN CHRIST
FOR ALL NATIONS

Австрали • Бразил • Канад • Герман • Хонг Конг • Сингапур
Өмнөд Африк • Английн Нэгдсэн Вант Улс • АНУ

The Holy Spirit - Are we Flammable or Fireproof? (Mongolian)

© 2019 by Reinhard Bonnke

Published by Christ for all Nations

PO Box 590588

Orlando, FL 32859-0588, USA

CfaN.org

Originally published in English as

The Holy Spirit - Are we Flammable or Fireproof?

Published by Christ for all Nations

ISBN: 978-1-933446-52-3 (paperback)

ISBN-13: 978-1-933446-53-0 (e-book)

This book is a free gift from the author and it is NOT FOR SALE Follow Evangelist Reinhard Bonnke on Facebook

Ариун Сүнс: Бид шахамхай байна уу эсвэл галд тэсвэртэй байна уу?

© 2019 Рейнхард Боннке

Christ for all Nations хэвлэв

PO Box 590588

Orlando, FL 32859-0588, USA

CfaN.org

Англи хэлээр

“Holy Spirit - Are we Flammable or Fireproof?” нэрээр

Christ for all Nations хэвлэв.

ISBN: 978-1-933446-52-3 (цаасан ном)

ISBN-13: 978-1-933446-53-0 (цахим ном)

Энэ НОМЫГ ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОЖ байгаа бөгөөд зохиогчийн зүгээс танд өгч буй бэлэг болно.

Сайн мэдээ дэлгэрүүлэгч Reinhard Bonnke -г Фэйсбүүкээс дагаарай.

ГАЛТ ХӨСӨГ ТЭРЭГ!

*Сайн мэдээ дэлгэрүүлэх ажил нь
галт дөрөөн дээрээс дүрэлзэх
Сайн мэдээний номлогчийг суулгасан,
шатаж буй хөтчөөр залуулсан галт хөсөг тэрэг мөн!
Таны үйлчлэлийг Ариун Сүнс
хөсөг тэргээ болгох болтугай!*

ЗОРИУЛАЛТ

Энэхүү номоо 53 жил ханилаж, гэрлэлт,
гэр бүл, даян дэлхийн үйлчлэлд минь итгэмжтэйгээр
хамтран зүтгэсэн, хайртай гэргий Эннидээ зориулав.

Өнгөрсөн долоо хоногт би түүндээ: “Чамайгаа харахаар нар
мандаад явчих шиг л болох юм” гэж хэлж байж билээ.

Бид хоёр амьдралаа Дуулал 113:3 - аар эхлүүлсэн юм.

“Нар мандахаас жаргах хүртэл
ЭЗЭНий нэр магтагдах болтугай.”

РЕЙНХАРД БОННКЕ

АГУУЛГА

Өмнөх үг	13
Танилцуулга	15
Сайн мэдээний шуурган гал	19
ХЭСЭГ 1: Ариун Сүнсний онцгой баримт	21
Гайхамшгийн Бурхан	22
Гал дотор баптисм хийлгэсэн	26
Та нар хүчийг олно	29
Үүрд байх тусламж	32
Түүнийг бүү хязгаарла	35
Бүхнийг Есүст	38
ХЭСЭГ 2: Баптисмыг Сүнс бөгөөд Бурханы Хүү Есүс хүртээдэг	41
Тослогдсон Нэгэн	42
Хүүгийн гал	47
Тэнгэрлэг анхааруулга	50
Төлөгдсөн	53
ХЭСЭГ 3: Хүчирхэг хуй салхи – Пентекост	59
Амлалт биелэв	60
Эш үзүүлсэн сайн мэдээ	66
Пентекостын сайн мэдээ	69
Галт хослол	73
Харь үндэстэнүүдийн гэрэл	77
ХЭСЭГ 4: Галд дүрэгдсэн – Ариун Сүнсний баптисм	81
Сүүлчийн бороо	82
Ариун Сүнсний динамизм	86
Халил	90
Хөдлөшгүй баримт	93
ХЭСЭГ 5: Галын зэмсэг – Ариун Сүнсний бэлэг бөгөөд хүч	97
Үнэт бөгөөд үнэлэшгүй	98
Худалдан аваагүй, бэлэг болгож авсан	101
Илүү том бэлэг	105

Бэлэгээ бадраа	109
Дээрээс ирэх хүч	113
ХЭСЭГ 6: Дүрэлзэж буй хүмүүс – Ариун Сүнс ба итгэгч хүмүүс	117
Эх хувь	118
Давхар хувиас илүү	122
Язгууртан тахилч	126
Алдрын бөгөөд хүчийн шинэ хэмжигдэхүүн	130
Чадахаас илүү	133
Хэзээ ч ганцаараа биш	137
ХЭСЭГ 7: Галан ой – Ариун Сүнс ба чуулган	141
Шинэ Эхлэл	142
Өөрчлөгдөшгүй өөрчлөлт	146
Бэлэгтэй чуулган	149
Ариун Сүнсээр хүчирхэгжсэн	153
Түүний хамт байгч оршихуй	156
ХЭСЭГ 8: Галласан – Ариун Сүнсний бэрхшээл	161
Энэ бол таны цаг үе	162
Гичийн үр мэт итгэл	167
Хүч чадлаар юмүү мэдрэмжээр бус	171
Ер бусаар ажилладаг хүч	175
Ертөнц хүлээж байна	178
Итгэлийг сонго!	181
Энэ бол явах цаг	185
ХЭСЭГ 9: ГАЛТ АМЬДРАЛД ОРОХ - АРИУН СҮНС ДОТОРХ БАПТИСМЫГ ХЭРХЭН ХҮЛЭЭЖ АВАХ ТУХАЙ	187
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:	
Ариун Сүнс доторх баптисм гэж юу болох	189
ХОЁРДУГААР ХЭСЭГ:	
Ариун Сүнс доторх баптисм – Хэрхэн хүлээж авах вэ?	207

ӨМНӨХ ҮГ

Би нэг удаа Ариун Сүнсний хүчинд итгэдэггүй Христэд итгэдэг хүмүүсийн цуглаанд номлохоор уригдсан юм. Гэтэл цуглааны дундуур гэнэт Ариун Сүнс асгаж, хүмүүс Сүнсээр дүүрэн магтаж, баярлалдан хөөрөв. Хүмүүсийг хартал, тэр дунд Ариун Сүнсэнд огт автаагүй гурав, дөрвөн хүн үзэгдэв. Тэд тэр ер бусын үйл явдалд оролцолгүй, томоо гэгчийн нүдээр эргэн тойрноо ажиж суулаа. Тэгтэл зүрхэнд маань “Тэд бол асбестэн итгэгч нар” гэсэн бодол харвав. Өөрөөр хэлбэл тэд Ариун Сүнсний галт цутгалан дунд ч шатдаггүй, галд тэсвэртэй хүмүүс ажээ. Би л хувьдаа Бурханд шатамхай хүн. Би Ариун Сүнсний галаар шатаж, эцсийн амьсгалаа татгалаа бамбар мэт дүрэлзэхийг хүснэ. Энэ явдал надад номын маань нэрийг өгсөн юм. Тиймээс би өнөөдөр танаас ч бас асуумаар байна: “Та шатамхай хүн үү эсвэл галд тэсвэртэй хүн үү?”

ТАНИЛЦУУЛГА

Үйлс ном нь ямар ч романтиа зүйрлэшгүй сонирхолтой ном билээ. Библид тод, тод гол болоод туслах дүрүүд гардаг. Тэнд онц сонирхолтой үйл явдал, адал явдал, ялалт хийгээд эмгэнэлт түүх гардаг. Үйл явдал нь Иерусалимаас Дамаск хүртэл, Антиохоос Ром хүртэл, шоронгийн торноос усан онгоцны сүйрэл хүртэл өрнөнө. Бид Ариун Сүнсний салхинд цохиулж, эгэл жирийн ардууд атлаа гартаа гайхамшгийг атгасан, эгэлгүй, чин зоригт элч нар тухайн үеийнхээ засаг төрийн тэргүүдийг бэмбэгнүүлснийг хардаг. Нөгөө талаас бас бид мөнөөх аугаа элч нар чинь тавьтаргүйтэж, ёс зүйгүй авирлахыг ч үздэг.

Есүсийг тэнгэр өөд өргөгдөхөөс өмнө дагалдагч нар Түүнд итгэхгүй байсныг үзээд (Марк 16:8-аар ишлэл) би үнэхээр гайхаж билээ. Тэдний итгэлгүй байдлыг Марк 16:11-ээс ч харж болно. Тэгсэн хоёр ишлэлийн дараа буюу 13-аар ишлэл дээр тэд бас л “итгээгүй” гэжээ. Болоогүй ээ, 14-ээр ишлэл дээр ч тэд итгээгүй байна. Тэд бол архайж дархайхаас цаашгүй хэдэн үл итгэгч байв! Гэтэл дараагийн буюу 15-аар ишлэл дээр Есүс тэдгээр итгэлгүй, хулчгар “итгэгч нар” “Бүх ертөнцөөр явж, сайнмэдээг хамаг бүтээлд тунхаглагтун” гэж тушаасан нь намайг ёстой л ангайлгасан юм. Хэрэв би тэнд байсан бол, Есүсийн араас сэм дөхөж очоод чихэнд нь: “Эзэнтэн минь, Таны ийм Аугаа захирамж даалгаад байгаа энэ хэдэн дагалдагч чинь ямар ч итгэлгүй хүмүүс гэдгийг Та эрх биш мэдэж байгаа биз дээ? Тэд үүнийг чинь хэзээ ч хийж чадахгүй” гэж шивэгнэх байсан байх. Харин тэр үед Есүс над руу эргээд, долоовор хуруугаараа уруулаа дараад, аяар дуугаар: “Боннке, Надад нэгэн нууц байгааг чи мэдэхгүй” хэмээх байсан байх.

Тэр нууц нь юу байв? 14-20-аар ишлэлийн хооронд нэг л юм болжээ. 20-аар ишлэл дээр “Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн хамт ажиллаж, дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байлаа. Амен.]” гэжээ. Тэгвэл 14-20-аар ишлэлийн хооронд чухам юу болов? Он цагийн дарааллаар нь үзбэл, Үйлс 2-аар бүлгийн үйл явдал өрнөжээ. Дагалдагч нар айдсаасаа чөлөөлөгдөж,

Есүсийг тэнгэр өөд өргөгдсөний дараа Түүний явахаасаа өмнө өгсөн “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно” (Үйлс 1:8) гэдэг захирамжийг биелүүлэх хүчтэй болжээ. Тэгвэл яг үүнтэй адил бид бүгдээрээ мөхөс байдлаа тайлж, төгсөшгүй хүчийг өмсөж чадна.

Христэд итгэдэг гэрч хүний цөм нь хүч ажээ. Хүч нь Сайн мэдээний гоёл чимэглэл биш юм. Хүч нь дугуйны хонх биш, харин бүхэл машин юм. Зарим дагалдагч нарт хүч заяахгүй гэсэн санаа Библи дээр нэг ч байхгүй. Би шулуухан л хэлье - Христэд итгэх итгэл нь ер бусын зүйл байх ёстой. Эс бөгөөс юу ч биш болно. Бидэнд ер бусын үйлчлэлтэй, ер бусын Чуулганыг байгуулагч, ер бусын Сайн мэдээтэй, ер бусын Библи тэй тэр ер бусын Есүс байсан бөгөөд одоо ч байгаа. Гайхамшгийг нь аваад хаячих юм бол, та Христэд итгэх итгэлийн амийг нь тасалчихлаа л гэсэн үг. Чуулган хүчгүй дэлхий рүү Бурханы хүчийг цутгах сүлжээ болох ёстой байтал, оронд нь бид ёс суртахууны цугларалт юмуу олон нийтийн клуб болоод байна. Та бид хоёр дэлхийд Бурханы хүчийг дамжуулах удирдаач нар мөн!

Ариун Сүнс болоод Христийн авран сэргээгч, хайрын Сайн мэдээ нь хэзээ ч салшгүй, нэгэн амь болон зангилагджээ. Та Бурханы хүчийг хармаар байгаа бол, нөгөө баахан арга ухаан, дарамт, сэтгэл зүйн санаа оноогоо хаяад, зүгээр л Үгийг номло! Би Бурханы эрдэнэсийн авдраас ганц, хоёр юм шилж аваад, бусдыг нь үлдээдэггүй. Би аврал, уучлал, эдгэрэл, амар тайван, найдвар, чөлөөлөлт зэрэг хүнд хэрэгтэй бүхнийг агуулах Сайн мэдээг бүрэн эхээр нь номлодог.

Би танд зориулж Ариун Сүнсний талаарх энэхүү хүчирхэг сургаалаа бичихдээ, Ариун Сүнсний хүчний талаар сурч мэдэх ёстой, эрч хүчтэй гол санааг “Галт зарчим” хэмээн тэмдэглэлээ. Би таныг Ариун Сүнсний талаарх эрт урьдын үзэл бодлоо ар өвөргүй эргүүлж тойруулан цэгнэж, дотор чинь оршин буй Сүнсний гайхамшигт хүчинд цоо шинээр итгээсэй гэж ятгаж байна. Таны дотор үхлээс амилуулагч, бургилсан их хүч бий. Бурхан үүнийг итгэгч хүн бүрт боломжтой болгосон. Бид нүгэл, ёрын муугийн өмнө шалтаглан, бөхийх үндэсгүй. Эцсийн эцэст “Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13).

Энэ ном бол миний амьдрал, үйлчлэлийн хамаг нууцын товчоо юм. Тиймээс эдгээр зарчмыг хэрэгжүүлэх аваас, та ч бас ижил үр дүнд хүрэхийг би батлан хэлж чадна.

Манай Сайн мэдээний аянаар хүмүүс бөөн бөөнөөрөө Ариун Сүнс доторх баптисмыг хүлээн авч, Бурханы хайр, хүч аугаа ихээр үзэгдэхийг бид тогтмол гэрчлэн хардаг байлаа. Тиймээс тэр бүх үйл явдлаас ойлгож ухаарснаа би та бүхэнд тайлбарлаж өгмөөр байна. Миний туйлын эрх мэдэл нь мэдээж Библи юм. Сүнсний юмсыг өөрийн болгоход туршлага надад тусалсан боловч, Петрийн хэлснээр Бурхан л “бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон” (2Петр 1:3) билээ. Туршлагыг Бичээс л батална. Тиймээс би ч бас Сүнсний талаарх ойлголтоо хуваалцахдаа, гагцхүү Үгээр дамжиж л эдгээр дүгнэлтэд хүрснээ давхар батлан харуулаад явахыг хичээнэ ээ.

САЙН МЭДЭЭНИЙ ШУУРГАН ГАЛ

Би сайнмэдээнээс ичихгүй. Энэ бол итгэгч болгоныг,
юуны түүрүүнд иудей түүнчлэн грек хүнийг ч аврах
Бурханы хүч мөн. (Ром 1:16)

ХАМГААЛАЛТАА БУУЛГА

Сайн мэдээ бол галлахад, үхсэн хүнийг амилуулдаг цорын ганц буу юм.

БАРИМТ

Библи бол Бурханы Хаанчлалын үндсэн хууль болой. Үүнийг газар дээрх ямар ч парламентын олонх, аль ч улсын Дээд шүүх өөрчилж чадахгүй. Ардчилсан сонгууль юмуу зөвшилцөл Библийн үнэнийг шийдэхгүй. “Аяа ЭЗЭН, үг тань тэнгэрт Мөнхөд бат тогтжээ” (Дуулал 119:89). “Би бол Үнэн” (Иохан 14:6).

ШУУРХАЙ МЭДЭЭ

Номлосон тохиолдолд л Сайн мэдээ амилдаг! Сайн мэдээ нь үйл явдал болон амилна.

ГАЛ ТАВЬ

Бид Сайн мэдээг төмөр тороор хашиснаараа хамгаалахгүй. Сайн мэдээг дайсны өөдөөс тавьж байж л хамгийн сайн хамгаална. Сайн мэдээ дайсныг хэрхэн сөнөөхөө мэднэ.

БУЛ ХАД

Бурханы Үг нь Христэч санал бодлын цуглуулга болсон жижигхээн хайрга чулуу биш, харин бул хад юм.

ЭЛЧИН САЙДУУД

Сайн мэдээ нь хүний шийдвэрийг сайжруулах засал биш юм. Сайн мэдээний номлогч хичнээн даруу байсан ч, хэрэг дээрээ тэрбээр Бурханы Хаанчлалын эрх мэдлээр яригч, титэмтэй албан тушаалтан юм. “Бид Христийн элчин сайдууд” (2Коринт 5:20).

ГАЙ ГАМШГИЙН МЭДЭЭ БИШ

Сайн мэдээ нь ялын тогтоол биш. Сайн мэдээ нь гай гамшигийн бус, харин Баярт мэдээ юм. Христ бол Амилал бөгөөд Амь болой.

ХЭЗЭЭД ШИНЭ

Сайн мэдээ нь Аугаа их Александр хааны түүх шиг улирч одсон түүх юмуу өнгөрсний зандаршуулсан ул мөр биш юм. Хуучирсан цахилгаан юмуу хуучирсан салхи гэж байдаггүйтэй адил хуучирсан Сайн мэдээ үгүй.

ҮЕИЙН ҮЕД ТОГТОНО

Бурханы Үг нь амьдрал шиг л үеийн үед тогтоно. Энэ нь хадгалалт хамгаалалт шаардлагатай эртний олдвор биш. Бурхан Өөрөө чуулганыг хадгалж хамгаалдаг. “... бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог” (Үйлс 17:28).

САЙН МЭДЭЭ БОЛ ГАР БӨМБӨГ

Итгэл, гэрчлэл хоёр нийлэхээрээ дэлбэрэлт л болдог. Паул Сайн мэдээг “Бурханы хүч” (Ром 1:16) гэсэн.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Сайн мэдээ бол үндэстнийг аврагч юм. Сайн мэдээ нь бүх амийг цэнэглэх ер бусын чадалтай, улс үндэстэнд зориулсан цахилгаан эх үүсвэр юм!

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 1:

АРИУН СҮНСНИЙ ОНЦГОЙ
БАРИМТ

ГАЙХАМШГИЙН БУРХАН

“Түүнийг завинд суухад, шавь нар нь Түүнийг дагалаа. Гэнэт нуурт хүчтэй шуурга босож, завь давалгаанд автахад Есүс харин унтаж байлаа. Тэд ирж, Түүнийг сэрээгээд —Эзэн авраач, бид сүйрлээ гэхэд нь Есүс тэдэнд —Юунд айцгаана вэ, өчүүхэн итгэлтнүүд ээ? гээд Тэр босож, салхи болоод нуурыг зандарчээ. Гэтэл нам гүм боллоо. Хүмүүс гайхаж —Энэ ер нь ямар янзын хүн болоод салхи, нуур хүртэл Түүнд дуулгавартай байгаа юм бол оо? гэлцэв.”

Матай 8:23-27

МЕГЕТОС - ЗОГСООШГҮЙ УРСГАЛ

Ариун Сүнсний баптисмаар дамжуулан бид бүгдээрээ үхлээс амилуулагч хүчийг хэрэглэх эрхтэй болжээ. Хүчгүй чуулган - нүдний булай. Та Бурханы төлөө ажиллаж байхад, Ариун Сүнс хэзээд ажиллаж байдаг. Та Бурханы төлөө ажиллахгүй бол, танд шаардлагагүй учраас хүч өгөгдөхгүй. Харин хэрэв та Сүнс доторх баптисмыг хүлээн авбал, тэр хүч зогсоошгүй болно.

ПАУЛ ЕФЕСИЙН ТӨЛӨӨ “ЗҮРХНИЙ ЧИНЬ МЭЛМИЙГ ГИЙГҮҮЛЭГДЭЖ ... итгэдэг БИДЭНД ХАНДСАН Түүний хүч чадлын яндашгүй аугааг мэдэх болтугай. Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулсан” (Ефес 1:18-20) хэмээн залбирчээ. Бидний мэдэлд ямар аугаа эх үүсвэр ирснийг Паул тайлбарлахдаа мегетос гэдэг үг хэрэглэсэн байна. Цөмийн бөмбөгийг “мегатонаар” хэмждэг. Гэтэл Паул цаашаа ахиад, “хайпер мегетос” буюу супер аугаа байдлын талаар өгүүлрүүн. Бид Христэч үйлчлэлийнхээ үр нөлөөг ийм хэмжээгээр л хэмжих ёстой бөгөөд Бурханы зарц болгон ийм л эх үүсвэрийг ашиглах боломжтой болжээ.

БОЛОМЖГҮЙ ЗҮЙЛ БОЛОМЖТОЙ БОЛНО

Тэнгэрлэг мөн чанар нь ер бусаар тогтохгүй гайхамшиг юм. Бурханы хүч, хайр, сайн сайхан нь бүх зүйлийг давдаг. Бурханы оршихуй байгаа газар гэрэл, амь, онц чанар ирж - хотгор бүр өргөгдөж, гүдгэр бүр намсаж, тахир нь шулуутгагдаж, энхэл донхол нь тэгширдэг (Исаиа 40:4). Бурханы үгсийн санд боломжгүй гэдэг үг байхгүй.

БУРХАН БАЙХАД, БОЛОМЖГҮЙ НЬ БОЛОМЖТОЙ БОЛДОГ. Энэ бол Түүний чанарын тэмдэг. Бурханыг явж өнгөрөхөд, бүтээл

амь орсон. Иов ертөнцийн тухайд нойтон өвсөн дээгүүр тэрэг явж өнгөрөхтэй адил “Түүний замуудын өчүүхэн нь энэ юм” (Иов 26:14) хэмээн өгүүлсэн. Есүсийн тухайд ч ялгаагүй. Түүнийг Еврейчүүдийн тосгоноор дайрч өнгөрснийг тэр даруй мэдэж болох байв. Тэнд өвчтэй хүн үлдээгүй! Есүс байгаа газарт усны толион дээгүүр явах, өвчтэйг эдгээх, өчүүхэн хөвгүүний өдрийн хоолоор 5,000 гаруй хүнийг хооллох ямар ч асуудалгүй байв. Ийм юмс зүгээр л болно. Дайснууд нь ч Түүний хөлд сөгдөнө. “Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүсийн сайн сайхны төлөө БҮХ ЮМ хамтдаа ажилладаг гэдгийг бид мэднэ” (Ром 8:28).

АРИУН СҮНСНИЙ ГАЙХАМШИГ

Бурхан зүгээр нэг ер бусын Бурхан биш юм. Гайхамшиг нь өөрөө Бурханы мөн чанар учраас, Сүнсний хувьд ч ялгаагүй билээ. Сүнсний бүх юм гайхамшигтай, Түүний үйлдэл бүхэн гайхамшигтай. Сүнтэй байна гэдэг нь гайхамшигийг хүсэн хүлээх, Сүнсэнд итгэнэ гэдэг нь гайхамшигт итгэх, Сүнсээр явна гэдэг нь гайхамшиг дотор хөдөлж, ажиллана гэсэн үг юм. Та гайхамшиг, тэмдгүүдийн төлөө бүтээгдсэн буюу!

ЕСҮСИЙН БИДЭНД АМЛАСАН ЦОРЫН ГАНЦ СҮНС НЬ ГАЙХАМШГИЙН Сүнс буюу Ариун Сүнс юм. Гайхамшиггүй Ариун Сүнс гэж байхгүй. Хүн өөрийгөө Ариун Сүнтэй хэмээн мэдэгдэх атлаа Ариун Сүнсийг онцгойруулдаг үйл ажлыг нь няцабал, Түүнийг гашуудуулна. Тэрбээр дэлхийг бүтээхдээ, ер бусын гоц физик гайхамшгаар эхлүүлсэн. Ариун Сүнс мөн чанараа өөрчлөхгүй. Ариун Сүнс хэн байсан - тэр л хэвээрээ байна. Тэр бол газрын тайзан дээр ажиллаж буй Бурхан юм. “Би бол Би” (Гэтлэл 3:14). Дэлхийг ер бусаар бүтээсэн Ариун Сүнсэнд ер бусаараа үргэлжлүүлэн ажиллах нь огт асуудал биш.

ХҮСЭЛ ХҮЛЭЭЛТЭЭС ДАВУУ

*Хүний нүгэлт, мөхөс, төрөлх хандлага Сүнсний юмст эргэлзэж,
тайлбарлах гэдэг ч, Христийн дотор сүнс маань дахин төрдөг.
Эдүгээ бид ер бусын дотор амьдарч, гайхамшигт итгэдэг болсон.
Төрөлх нөхцөл байдал юмуу бодит нөхцөл байдлынхаа үгд
автаж, гайхамшигаас бүү салаарай.*

БУРХАН БАЙГАЛИЙН ДЭГИЙГ БҮТЭЭСЭН БӨГӨӨД байгалийн хуулийн дагуу ажилладаг. Гэхдээ Бурхан байгалийн хуульд баригдаж, байгалийн юмуу хүмүүний мөхөс байдлаар хязгаарлагдахгүй. “Эдүгээ, дотор маань ажилладаг хүчний дагуу гүйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд...” (Ефес 3:20). Үүнд итгэж болно. Эцсийн эцэст “Бурхан бол худал хэлдэг хүн биш, гэмшин харамсдаг хүмүүн ч бус. Тэрээр айлдчихаад, Түүнийгээ хийхгүй гэж үү? Эсвэл Тэр ярьчихаад, Түүнийгээ сайн болгохгүй гэж үү?” (Тооллого 23:19)

ГАЛ ДОТОР БАПТИСМ ХИЙЛГЭСЭН

“Би та нарт гэмшлийн чинь төлөө усаар баптисм хүртээдэг. Харин Надаас илүү хүчирхэг Нэгэн миний араас ирж байна. Би Түүний шаахайг авч явах ч үнэ хүндгүй. Тэр та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ.”

Матай 3:11

БҮРЭН БУЛХСАН

Сүнсний баптисм нь таныг бүхлээр чинь буюу сүнс, сэтгэл, биеийг чинь Ариун Сүнс дотор бүрэн булхдаг бүтэн булхалт юм. Энэ нь хагас дутуу юмуу билэгдлийн чанартай юмуу цаг зуурын зүйл биш юм. Таны оршихуйн хэсэг нэг бүр энэхүү үнэт галт шингэн дотор бүрэн дүрэгдэж, бүрэн булхжээ. Энэ нь таны амин мөн чанарыг хийгээд хүрээлэн буй орчныг өөрчлөгч, үргэлжилсэн үйл явц билээ.

ЗАРИМ ХҮН ХҮЙТЭН АТЛАА АМТТАЙ - МӨХӨӨЛДӨС ШИГ Л ХРИСТЭД ИТГЭХ АМЬДРАЛЫГ ХҮСДЭГ. Тэд чуулганаа музей болгохыг хүсдэг. Гэхдээ чуулган бол хөлдөөгч хайрцаг биш юм. Чуулган бол Аавын өргөө юм. Ариун Сүнс биднийг Аавын өргөөний төлөө дулаацуулдаг.

ЭШ ҮЗҮҮЛЭГЧИЙН СҮНСЭЭР ЕРӨӨГДСӨН

Абрахам, Моше, Иошуа, Дебора, Елиа, Елиша - эдгээр нэрс биднийг бишрүүлэн гайхируулдаг боловч, тэд бол та бид хоёр шиг л халуун зурхтэй хүмүүс байсан юм шүү (Иаков 5:17). Тэдний дээр байсан тэр л Сүнс бидний дотор буй. Бид хоёрдугаар зэргийн Сүнсийг юмуу үйл явдлыг хүлээн аваагүй, хоёрдугаар зэргийн үр дүнг ч хүсэн хүлээх ёсгүй.

СҮНС ДОТРОХ БАПТИСМ НЬ ИТГЭГЧ ХҮМҮҮСИЙГ ЭШ ҮЗҮҮЛЭГЧ НАРЫН СҮНСЭЭР ЕРӨӨДӨГ. Эш үзүүлэгч нар ер бусын байдлаар Бурхантай учирдаг байсан бөгөөд энэ үйл явдлыг эш үзүүлэгч нарын сүнс гэж ярьдаг байжээ. Иоел 2:28 дээр яг тэр эш үзүүлэгч нарын сүнс махан биес дээр цутгагдана хэмээн амласан байдаг. Зүгээр нэг ганц хоёр хувь хүн хааяа нэг эш үзүүлэх бус, харин янз янзын хүмүүс эш үзүүлгээх болно.

ХҮРЭХЭЭС НААШ ЦАХИЛГААНЫ УТАС Ч ГЭМГҮЙ

Бурханы хаанчлал хэдийнээ ирсэн бөгөөд энэ хаанчлалын түлхүүрийг бид атгаж буй. Бид эгэл жирийн, нүдэнд өртөмгүй, хорхойд хоргүй харагдаж болох. Гэхдээ үүнд хууртав. Бид чинь Ариун Сүнсний хүчээр бялхсан, Бурханы авран сэргээх төлөвлөгөөнд амин чухал үүрэгтэй хүмүүс шүү. Бидний хэл яриа хүмүүсийн хувь тавиланд нөлөөлж, үйл явдлын урсгалыг өөрчлөх хүчтэй. Гарт маань Гилеадын эдгээгч тос атгаатай явна.

АНХ ЦАХИЛГААНЫГ НЭЭХЭД дийлэнх хүмүүс үүнийг зугаатай үзэгдэл төдий үзжээ. Үйлдвэрлэлийг амилуулж, хотуудыг гэрэлтүүлэх хүчин чадалтай цахилгааны хүчийг хэрэглэх завшаан хоёр зуун жилийн өмнө маш цөөхөн хүнд л олддог байж. Тэгвэл хүмүүс хэлээр ярьсан нь Ариун Сүнсний хүчний хүчин чадлын тэмдэг байв. Сүнсний илрэлээс Бурханы хийж чадах зүйлд итгэх итгэл маань гардаг. Бид өөрсдөө л зөвшөөрдөг юм бол, Бурханы Сүнс хааяа нэг үзэгдэлгүй, харин бидний бүхэл үйлчлэлд нэвтрэн орно. Итгэмээргүй, хэт даруухан харагдаж байна уу? Христэд итгэх итгэл даруухан харагдаж болно оо. Гэхдээ хүрэхээс нааш цахилгааны утас ч гэмгүй л харагддаг юм.

ТА НАР ХҮЧИЙГ ОЛНО

“Тэгээд, цуглагсад Түүнээс —Эзэн, энэ цагт Та Израильд хаанчлалыг сэргээх үү? гэж асуусанд Тэр тэдэнд —Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш. Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно гэв.”

Үйлс 1:6-8

ЭРЧ ХҮЭЭР ДҮҮРЭН

Есүс “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олно...” (Үйлс 1:8) хэмээн айлджээ. Энэ эрч хүчгүйгээр бид хорхойд хоргүй, нийгэмжсэн, боловсон шашин л болно. Нууцад гэгээрэх явдал нь Шинэ гэрээний эрч хүч биш юм. Аниргүй байдал нь Христэд итгэх итгэлд бус, буддизм л хэрэгтэй байх. Бүү хойшоо суу!

АРИУН СҮНСНИЙ ХҮЧ НЬ ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛИЙН АМЬДРАЛД БАЙХ Л ЁСТОЙ ЗҮЙЛ ЮМ. Сүнсээр дүүрэн байх нь Шинэ гэрээний болоод түүнээс хойшхи сая сая хүний амьдралд эрч хүчтэй, идэвхитэй нөлөөллийг буюу “хүчийг” (дунамис) харуулж байжээ. Ариун Сүнс хүмүүс дээр чимээ аниргүй, үл анзаарагдам, сэм ирсэн талаар Бичээс бараг ярьдаггүй. Түүний айлчлал ер нь бол анзаарахгүй өнгөрөхийн аргагүй байдаг. Сүнсний илрэл нь гал, салхи, дуу чимээ, гайхамшиг, гадаад тэмдэг, хүч, харагдахуйц үр нөлөөг дагуулдаг.

ЯЛУУЛАХЫН ТӨЛӨӨХ ХҮЧ

Ариун Сүнс тайвшруулагч юмуу сэргээш шиг супер эм биш юм. Тэрбээр биднийг зүгээр нэг оволзуулах гэж ирдэггүй ч, Түүний оршихуй сэтгэл зүрхийг үнэхээр оволзуулдаг нь үнэн. Амьдрал хэцүү. Тиймээс Бурхан хүнд хэцүү нөхцөлд байгаа хүмүүстээ хүчээ илгээдэг. Бурхан бол биднийг ялгуусан, бүрэн дүүрэн амьдарч, дэлхийд гэрч болоход маань хүчирхэгжүүлдэг амийн эх ундарга болой.

... ТА НАР ОЙРЫН ӨДРҮҮДЭД АРИУН СҮНСЭЭР БАПТИСМ ХҮРТЭХ БОЛНО... Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олно (Үйлс 1:5,8). Энэ үйл явдал өнөөдөр болох уу? Ямар ч байсан

миний л амьдралд болсон. Хүний амьдралд үүнээс сайхан тохиол байдгийг би л лав мэдэхгүй. Энэ чинь Бурханаар дүүрнэ гэсэн үг. Түүнээс биш учиргүй баярлаж, толгой эргэж, хөөс сахруулан Бурханаар “мансуурна” гэсэн үг биш. Энэ нь бодит чадвар, зан чанарын хүч хат, биеийн эдгэрэл гэсэн үг. Энэ нь тэнгэрлэг хамгаалалт, цэц ухаан, оюун ухааны өсөлт, таалал зэрэг энэ амьдралд хэрэгтэй бүхий л сайн сайхан зүйл юм.

МАРАФОНД ГҮЙХ ХҮЧ

Хэдийгээр үнэ цэнэтэй боловч, тосолгоог Олимпоос алтан медаль авдаг шиг олохгүй. Сүнсийг яг л аврал шиг итгэлээр хүлээн авна. Бид эрийнхээ сайнд Сүнсийг хүлээн авдаггүй. Бид Христийн хүчирхэг гэрч нар болохын тулд Сүнсийг хүлээн авдаг.

АРИУН СҮНСНИЙ ХҮЧ НЬ ШАГНАЛ БИШ ЮМ. Энэ хүч нь марафоноо дуусгасны үр дүнд гардаж авдаг цом биш. Бурханы төлөө марафон гүйлтэд гүйх гэж байгаа бол, эхнээсээ л хүч хэрэгтэй. Бид гүйх замдаа бүдэрдэг, бүтэлгүй хүмүүс байж болох. Гэхдээ энэ нь бидэнд Ариун Сүнс үнэхээр хэрэгтэй болохыг дахин баталж буй хэрэг юм. Биднийг төгс болсон учраас, Бурхан Ариун Сүнсээ өгдөг юм биш. Бид Ариун Сүнсгүйгээр амьдарч чадахгүй учраас л Тэр бидэнд ирсэн юм. Зүгээр л зүрхэндээ: “Ариун Сүнс минь, Та надад хэрэгтэй байна!” гэж ахин дахин хэл. Тэрбээр тэр даруй хариу өгөн, дэргэд чинь байх болно!

ҮҮРД БАЙХ ТУСЛАМЖ

“Би Эцэгээс гуйхад Тэр та нарт өөр Туслагчийг өгнө.
Тэр нь та нартай үүрд хамт байна.”

Иохан 14:16

БҮХНИЙГ ЧАДАГЧ АРИУН СҮНС БИДНЭЭР ДАМЖИН АЖИЛЛАНА

Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд хамаг ариун хүмүүсийн төлөө бүхий л цөхрөлтгүй оролдлого, гуйлтаараа сэргээг бай (Ефес 6:18).

АРИУН СҮНС НЬ ГУРВАЛЫН НЭГЭН БИЛЭЭ. Тэрбээр бүхнийг чадагч, бүхнийг мэдэгч, хаа сайгүй оршигч. Түүнд бидний тус хэрэггүй ч, Тэрбээр бидэнд хайртайдаа биднээр дамжуулан, бидэнтэй хамт, бидний төлөө ажиллахыг сонгодог. Залбирал нь Бурханд тусалж буй явдал бус, харин бидэнд тусалж буй явдал юм. Залбирал нь биднийг Бурхантай түншлэн, Түүнд захирагдаж, Түүнийг амьдралынхаа Эзэн, Чөлөөлөгч, Аврагч болгоход маань тусалдаг. Бидэнд ариун бөгөөд нигүүлсэнгүй, сайн Бурханы төлөөлөгч байх завшааныг олгосон, юутай хосгүй нигүүлслийг бид хүлээн аваа вэ! Бид зовлонд нэрвэгдсэн дэлхийд авралыг санал болгодог.

БУРХАН ТАНЫ ТӨЛӨӨ АЖИЛЛАХЫГ ХҮСЧ БАЙНА

Олон хүн Бурханы төлөө ажилладаг. Гэтэл Бурхан тэдний төлөө ажиллахыг хүсдэг. Бурхан биднийг Өөрийнх нь төлөө махаа идэн ажиллаасай гэж хүсдэггүй. Үйлчлэл нь амин чухлаас гадна зайлиггүй хэрэгтэй. Тийм боловч Бурхан биднийг амарч, гэр бүл, найз нөхөдтэйгээ зугаацах цаг гаргаж, Өөрийнх нь үнэ төлбөргүй хайрласан сайн сайхныг эдлээсэй гэж хүсдэг.

БИ НЭГ УДАА НЭГЭН ХҮНИЙ БУЛШНЫ ЧУЛУУН ДЭЭР “Ажлаас өөрийг мэдээгүй хүн” гэж бичсэн байхыг харж билээ. Тэгээд “Энэ чинь хүн биш, луус байна” гэж бодогдсон юм. Бурхан биднийг

араатан шиг амьдарч, робот шиг ажиллаж, ачааллаасай гэж хүсдэггүй. Бурхан хүсэхийн төдийд л адуун сүргийг бүтээж чадна шүү дээ. Бурхан та бид хоёрыг зүгээр нэг харц боол юмуу ачааны тэрэг шиг үздэггүй, харин хөвгүүдээ гэж боддог.

ТҮҮНИЙГ БҮҮ ХЯЗГААРЛА

“Цөлд Түүнтэй тэд хичнээн их тэрсэлж,
Зэлүүд талд Түүнийг хичнээн их гашуудуулсан бэ!

Дахин дахин Бурханыг сорьж,

Израилийн Ариун Нэгэнийг тэд өвтгөсөн.

Түүний мутрыг, Өөрсдийг нь өстнөөс аварсан
өдрийг нь ч тэд санаагүй. Тэр тэмдгүүдээ Египетэд,
Гайхамшгуудаа Зоаны хээр талд хэрхэн харуулж...”

Дуулал 78:40-43

ХЭН Ч ОРЛОХГҮЙ

Ариун Сүнсэнд орлогч байхгүй. Тэр бол номлогчийн амь, номлолын хүч, хүмүүсийн сэтгэлийг Чуулган руу ховх сорогч тэнгэрийн соронз. Бид Түүнийг Чуулгандаа эзлэх ёстой байранд нь залж, босгон байгуулах ажлыг нь хийлгэвэл, Чуулганыг тамын хаалга барьж хорьж дийлэхгүй бөгөөд Бурханы Сүнс Өөрөө Бурханыг суртчилаад явчихна. Бид өсөлтийг харна.

АРИУН СҮНСНИЙ АЖИЛ БАГАСАХ ТУСАМ, ЧУУЛГАНЫ ҮЙЛ ажиллагааг авч явахад улам л их бялуу, кофе шаардлагатай болно. Би кофе, бялууг муулаагүй л дээ. Гэхдээ Ариун Сүнснийг юу ч орлодоггүй юм. Түүний оршихуй болоод ажил өөрөө өгүүлнэ.

ДАЯН ДЭЛХИЙ ЕСҮСИЙН ТӨЛӨӨ

Ариун Сүнс Сайн мэдээний ажлыг амьдруулдаг. Ариун Сүнсгүйгээр Аугаа захирамж хэзээ ч бүтэшгүй зүүд болно. Гэхдээ Ариун Сүнсний лугшилт, оролцоо байвал, бүх бүтээлд Сайн мэдээг номлох нь хүсэл төдий сэтгэл бус, харин бүтэх боломжтой алсын хараа болно.

ӨНГӨРСӨН ЗУУНЫ ЭХЭЭР АРИУН СҮНСНИЙ илрэл яг л Үйлс 2 дээр гардаг шиг уран сайхан, өрнүүн байв. Америкаас Европ хүрч, тэндээсээ дэлхийг бүслүүрджээ. Тэгэхээр, сүүлийн 100 жилд Бурханаар ассан 20 хүн 800 сая амийг авралд хүргэж чадсан юм бол, өдгөө тэр 800 сая хүн хэдэн хүнийг авралд хүргэж чадах бол? Бурхан тэнгэрээр ч хязгаарлагдахгүй!

“БИ ТАНЫ НҮДНЭЭС ЕСҮСИЙГ ХАРЖ БАЙНА.”

Ариун Сүнс таны дотор суурьшсан бөгөөд амьдралд чинь хүчтэй ажиллахыг хүсч байна. Тэрбээр таны оршихуйн эд эс бүртэй, сэтгэлийн чинь эд эс бүртэй холбогдохыг хүсч байна. Түүнд хэл, бие, оюун санаа, хүсэл, тэр байтугай нүдээ өгбөл, хүмүүс танаас Түүнийг олж харна.

ХЭДЭН ЖИЛИЙН ӨМНӨ МАНАЙ МАГТААЛЫН ҮЙЛЧЛЭГЧ БИД ХОЁР шинэ даралтат хөгжим худалдаж авахаар явсан юм. Үдийн алдад бид хоёр Өмнөд Африкийн Иоханнесбургийн маш том хөгжмийн дэлгүүрт явж оров. Худалдагч нь бид хоёрыг анзаарсан ч үгүй. Бид хоёр ч бараг бүх даралтат хөгжмийг нь цохиж үзлээ. Гэтэл гэнэт худалдагч нь гараад ирэв. Тэрбээр ихэд цочирдож, нүд ам нь орой дээрээ гарсан царайгаар: “Эрхэм ээ, би таны нүднээс Есүсийг харж байна!” гэх нь тэр. Юу? Ариун Сүнс тэр дэлгүүрт явж оржээ. Тэгээд бид нөгөө даралтад хөгжим мөгжмөө таг мартаад, оронд нь сэргэлтийн цуглаан хийж билээ. Гэхдээ би машин руугаа буцаад явж байхдаса: “Эзэн минь, ёстой ойлгохгүй юм. Яахаараа шал танихгүй хүн над дээр хүрч ирээд “Би таны нүднээс Есүсийг харж байна” гэдэг билээ? хэмээн тувт асуусаар байлаа. Тэгтэл гэнэт Ариун Сүнс надад: “Есүс чиний зүрхэнд амьдардаг. Тэгээд заримдаа ТЭР ЦОНХООР ХАРАХ ДУРТАЙ” гэж хэлэх нь тэр. Би ч нэг инээж, нэг уйлав. Ямар гайхамшигтай үнэн бэ! Би Ариун Сүнсний үгийг ойлгов. Олон жилийн дараа би тэр худалдагчийн гэргийтэй таартал, тэр эмэгтэй надад нөхрийгөө насан турш Есүсийг үнэнчээр дагасан тухай хэлж билээ. Бурхан алдаршиг.

БҮХНИЙГ ЕСҮСТ

“Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе. Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд Төгсгөгч болох Есүс өөд харцгаая. Тэрээр өмнө нь тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм. Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн Түүнийг санагтун.”

Еврей 12:1-3

ХУВИЙН БУС, ОЛОН НИЙТИЙН

Бид Сайн мэдээнээс ичээд байгаа юм биш биз? Паул ичээгүй. Тэрбээр тангараг өргөснөө харуулахаар үсээ хуссан (Үйлс 21:24). Хүмүүс халзан элчийг заавал анзаарах байв. Гэхдээ ТЭР ИЧЭЭГҮЙ! Тэрбээр Бурханы төлөө ямар нэг юм хийнэ гэж тангарагласан! Тэгвэл бид яагаад галан баптисм хүртсэн итгэгч нар шиг байхгүй байна?

120 ХҮН ДЭЭД ӨРӨӨНӨӨС ГАРЧ ИРЭХДЭЭ, тэс өөр хүмүүс болоод байв! Тэд тамгалагдсан, өөрчлөгдсөн хүмүүс болсон нь илт байв. Тэгвэл манай чуулганы хүмүүс Бүтэн сайны цуглаанаа тараад гарахдаа, ямархуу харагдаж байгаа бол? Сайн мэдээний аянаар Ариун Сүнс цэнгэлдэх хүрээлэн дээр цутгаж, хүмүүс бүгдээрээ Ариун Сүнсээр согтоод гарсан гэж бодъё? Ариун Сүнс доторх баптисм нь ХУВИЙН ХЭРЭГ бус, харин ОЛОН НИЙТИЙН ХЭРЭГ юм. Бурхан алдаршиг!

ТУЛТАЛ ДАВШ

Дэлхийг шүтэгч нар Бурханыг хайрлах хайраас бусад бүх юмст хөл алддаг. Бид юу хүсч байна? Бид өөрийнхөө ая тухтай соёл, боловсон амьдралыг хүсч байна уу эсвэл Тэнгэрлэг мөн чанарын гал, бялхлыг хүсч байна уу? Хэрэв та юу юунаас илүү Ариун Сүнсийг л хүсч байгаа бол, тултал дави.

БИД ПЕНТЕКОСТЫН ХҮЧИРХЭГ ХҮЙ САЛХИТАЙ ЗЭРЭГЦЭХ БУРХАНЫ ЗОРИЛГЫН ТЭНГИСТ арчигдах, сүр жавхлантай үйл явдлаас айж байна уу? Иргэншил гэж бидний нэрлэдэг цардуул бидний хувцсыг хатаагаад, төмөр хуяг дуулга болгочихсон учраас, бид “Христийг өмсөж” чадахгүй байна уу? Түүний нулимс хаана байна?

Түүний зүрх сэтгэл - бидний загалмайгаа үүрэх явдал хаана байна? Бидний амиа өчүүхэн ч бодолгүй, Бурханд бүрэн зориулагдах явдал хаана байна? Бурханыг бүхлээр нь хүсч байгаа бол, тултал давш. Бүү хойшоо суу.

ХААНААС ЭХЛЭХ ВЭ?

Нэгэн залуу Сайн мэдээг номлохоор дуудагдсан боловч, пастор нь түүнийг индэрт гаргахгүй байгаа талаар надад ярьж билээ. Намайг түүнд: “Би чамд индрээ өгье!” гэж хэлтэл, тэр над руу бүлтийгээд: “Юу? Та намайг индэртээ гаргах юм уу?” хэмээн асуув. Тэгэхээр нь би түүнд: “Үгүй. Гэхдээ би чамд индэр гаргаж өгье. Гудамжны булан тохой бүр индэр шүү дээ. Би тэндээс л эхэлсэн, чи ч бас тэндээс л эхэл” гэж хэлсэн юм. Бичээс “Жижиг эхлэлийг бүү дорд үз. Учир нь ажлын эхлэлийг хараад баярладаг юм” (Зехариа 4:10) гэдэг.

ҮЙЛЧЛЭЛ ШАТ ДАРААТАЙ ӨСДӨГ. ӨСӨЛТ ААЖМААР өрнөдөг. Та Үг дотор, итгэл дотор, Ариун Сүнс дотор болоод үр жимсээр өсч төлөвшинө. Эсэргүүцэл ирэхэд бүү бууж өг. Есүс биднийг байлдан дагуулагчаас ч давуу бүтээсэн. Бидэнд тэнгэрэлч нар өгсөж, урууддаг, онгорхой тэнгэр байна. Бидний залбирал тэнгэрт саадгүй хүрч, цэлмэг тэнгэрээс Ариун Сүнс бидэн дээр зогсоо зайгүй цутгаж байна.

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 2:

БАПТИСМЫГ СҮНС БӨГӨӨД
БУРХАНЫ ХҮҮ ЕСҮС
ХҮРТЭЭДЭГ



ТОСЛОГДСОН НЭГЭН

“Есүс баптисм хүртээд, голын уснаас даруй гарах үед,
гэнэт тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа мэт бууж,
Түүн дээр ирэхийг тэр харлаа. Тэнгэрээс —Үзэгтүн,
хайрт Хүү минь энэ билээ. Таалал минь Түүнд оршдог
гэх дуун гарлаа.”

Матай 3:16, 17

ГАЛ ДОТОРХ БАПТИСМ

Есүс Иохан баптистыг асч буй, гэрэлт дэнлүү гэсэн боловч, Иохан Иордан голын хүйтэн усаар баптисм хийдэг байв. Гэхдээ Есүс дэнлүү биш юм. Тэр Өөрөө гэрэл, Эзэн бөгөөд эдгэрэл, хүчийг авчирдаг Бурханы тахилын ширээнээс улалзан шатах гал болох өөр Иорданд буюу сүнслэг Иордан дотор баптисм хийдэг.

БУРХАН ИОХАН БАПТИСТАД ЭНЭ ТУХАЙ ХЭЛСЭН УЧРААС, ТЭРБЭЭР СҮНС ДОТОРХ БАПТИСМЫН ТАЛААР МЭДДЭГ БАЙВ. Үнэндээ Иохан Христийг чухам үүгээр нь л танина гэж хэлсэн юм. Энэ нь хэний ч, хэзээ ч хийж байгаагүй зүйл байх болно. Үй түмэн шашин байх ч, Христ тэдгээрээс ангида. Тэр Ариун Сүнс дотор бөгөөд гал дотор баптисм хийнэ (Матай 3:11).

ЕСҮС АРИУН СҮНС ДОТОР БАПТИСМ ХИЙЛГЭСЭН

Есүс хэдийгээр Ариун Сүнсээр олдсон боловч, үйлчлэлд гарахдаа Ариун Сүнсний баптизмыг хүлээн авах хэрэгтэй байв. Бурханы Сүнс Түүн дээр галан дөлөөр бус, харин тагтаа мэт буусан нь Есүсийн дотор шатаагаад байх зүйл байхгүйгээс тэр байжээ.

ХРИСТЭД ИТГЭДЭГ ХҮМҮҮСИЙН ХАМГИЙН АУГАА ҮЛГЭР ЗАГВАР НЬ ЕСҮС БӨГӨӨД ТЭРБЭЭР АРИУН СҮНС ДОТОРХ БАПТИСМЫГ ХҮЛЭЭН АВЧЭЭ. Матай, Марк, Лукийн Сайн мэдээ бүгдээрээ нэг л ижил үйл явдлыг тэмдэглэдэг. Сайн мэдээний дөрөв дэхь ном болох Иохан энэ талаар арай дэлгэрэнгүй өгүүлдэг. Есүсийн өмнө ирсэн Иохан Баптист “Бурханы Сүнс тагтаа мэт бууж, Түүн дээр ирэхийг тэр харлаа” (Матай 1:32) гэсэн. Үүнийг нь Есүс “Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм” (Лук 4:18) гэж тайлбарласан бол, Үйлс

10:38 дээр Петр “Бурхан... Назарын Есүсийг Ариун Сүнс ба хүч чадлаар тосолсон” гэжээ. Иохан Баптист хөөрмөөр зүйл хэлсэн: “Харин усаар баптисм хүртээлгэхээр намайг илгээсэн Тэр “Хэний дээр Сүнс тагтаа мэт буун ирж тогтохыг чи харна, Тэр бол Сүнсээр баптисм хүртээгч мөн” гэж надад айлдсан юм” (Иохан 1:33).

Христ хүний төгс туршлага гэж юу байдгийг харуулахын тулд Бурханаас хүний туршлагыг хүлээн авчээ. Тэрбээр үй олон хүний эхнийх нь байсан. Тэрбээр Ариун Сүнсээр баптисм хийлгэсэн газар дээрх анхны хүн байв. Иохан 3:34 дээр “Бурханаас илгээгдсэн Тэр, Бурханы үгийг айлддаг. Учир нь Бурхан Сүнсийг хэмжээлшгүйгээр өгдөг” гэдэг. Иохан 1:16 дээр “Түүний дүүрнээс нь бид бүгдээрээ нигүүлсэл дээрээ нигүүлслийг хүлээн авсан” гэдэг. Энэ бол гайхамшигтай үнэн - Христийн хүлээн авсан зүйл нь бидний төлөө байсан юм. Тэрбээр бидний төлөө дүүрч, Түүний хязгааргүй дүүрэн байдлаас бид дүүрэн болдог.

ЕСҮСИЙН ХЭЛСЭН БҮХЭН БИДНИЙ ТӨЛӨӨ БАЙВ

Тэр бидний төлөө төрсөн, бидний төлөө амьдарсан. Тэрбээр бидний төлөө усанд бөгөөд Сүнс дотор баптисм хийлгэсэн гэсэн. Тэрбээр бидний төлөө үйлчилсэн, үхсэн, амилсан, алдар өөд өргөгдсөн бөгөөд эргэж ирнэ.

АРИУН СҮНС ЕСҮСИЙН АМЬДРАЛЫГ БИДНИЙ ТУРШЛАГА РУУ ХӨРВҮҮЛДЭГ. Тэрбээр хүний дүрийг сонгохдоо, Ариун Сүнсээр гачигдах хүн төрөлхтний хэрэгцээг хүлээн авчээ. Тэрбээр Өөрийгөө бидэнтэй нэгдүүлээд, “аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэх нь бидэнд зохицож байна” (Матай 3:15) гэсэн. Есүс Бурханы Хүү байсан боловч, хүн төрөлхтөн бидний зогсож байгаа газарт зогссон юм. Энэ нь Тэрбээр Сүнсээр тослогдсон, шинэ туршлага руу хөдлөх өдөр ирсэн гэсэн үг. Тэр Бурханд итгэсэн юмуу эсвэл шинээр төрөөгүй. Бурханы Хүүд ийм юм хэзээ ч хэрэгтэй байгаагүй. Тэрбээр Өөрийнхөө үлгэр жишээгээр Сүнс доторх баптисмыг дахин төрөхтэй юмуу өөр ямар нэгэн сүнслэг үйл явдалтай хутгаж болохгүйг харуулсан билээ. Тэрбээр үйлчлэлийнхээ төлөө л Ариун

Сүнсний ангид, онцгой үйл явдлыг хүлээн авсан билээ. Бид ч Түүний жишгийг дагаж, тийнхүү хүлээн авах ёстой.

ТОСОЛГООТОЙ МӨР

Ариун Сүнсний шингэн галд булхсан эрэгтэй, эмэгтэй хүний аварга том мөрүүд байдаг. Тэдний алхам бүр нь зам дээрх хилэнцэт хорхой, могойг хуйхлах галд дүрэгдэж, чөлөөлт, ерөөлийн жим гаргасан байдаг.

“БАПТИСМ” ГЭДЭГ ҮГ НЬ ӨНӨӨДӨР ЧУУЛГАНТАЙ ХАМААТАЙ ҮГ БОЛОВЧ эрт үед булхлыг хэлдэг байжээ. Даавуу урладаг хүн даавуугаа өнгөнд оруулахдаа, булхдаг буюу баптизм хийдэг байсан бөгөөд даавуу нь тухайн өнгөнийхөө мөн чанарыг шингээдэг байв. Есүс Ариун Сүнсний гол дотор зогсож байхдаа, биднийг дуудаж, харин бид дагахад Тэрбээр гарса мөрөн дээр минь тавиад, бидэнд Ариун Сүнсний шингэн гал дотор баптизм хийдэг. Тэгээд бид гал дотор орж, гал бидний дотор ордог. Бид алдрын голоос гарч ирэхдээ бүрэн ханаж, бүрэн нэвчсэн байна. Бидний аль нэг тал юмуу үйл ажиллагаа бус, харин хувь чанар маань бүхлээрээ булхсан байна. Таныг голоос гарч ирэхэд, танаас амьд галын дуслууд дусаж байна гээд л төсөөл. Таны галан дуслуудын мөрийг хараад, хаа байсныг чинь хавь ойрын чөтгөрүүд бүгдээрээ мэдэх болно. Тосолгоотой мөрүүд!

ҮҮНИЙ ХЭСЭГ НЬ БАЙГААРАЙ

Есүс амьдарлынхаа эхэн үед хэнд ч галан баптизм хийгээгүй. Тэрбээр Аав дээрээ очсон хойноо үүнийгээ хийнэ гэж амласан бөгөөд Үйлс 2-аар бүлэг дээр тэмдэглэсэн Пентекост өдрөөс эхлэн үүнийгээ хийсэн билээ. Хөтөлбөрт өөрчлөлт ороогүй. Есүс одоо ч Ариун Сүнс дотор баптизм хийсэн хэвээрээ байна.

*Тэрбээр энэ үүргээсээ буугаагүй, Түүний дүр ч өөрчлөгдөөгүй.
Тэрбээр амлалтаа бүх хүнд өгчихөөд яаж үүнээсээ буцах билээ?
(Үйлс 2:39)*

ЭЛЧ НАРЫН ҮЙЛСИЙН ШИНЭ БҮЛЭГ бичигдэв. Өнөөдөр Ариун Сүнс доторх баптисм зуу зуу, сая сая шинэ итгэгчийг хүчирхэг Сайн мэдээний үйлсэд өдөөж байна. Тиймээс үүний хэсэг нь байгаарай!

ХҮҮГИЙН ГАЛ

“Иудейчүүдийн Алгасал баяр ойртож байсан бөгөөд Есүс Иерусалим уруу явав. Тэрээр үхэр, хонь, тагтаа худалдаалагчид ба мөнгө солигчид сүм дотор сууж байгааг хараад, дээсээр шилбүүр хийж хонь үхэр бүгдийг нь сүмээс тууж гарган, мөнгө солигчдын зооснуудыг тараан хаяж, ширээг нь хөмрүүлээд, тагтаа худалдаж байсан хүмүүст —Энэ юмнуудаа зайлуул. Эцэгийн минь гэрийг наймааны газар бүү болго гэлээ. Шавь нар нь “Таны өргөөний төлөөх зүтгэл Намайг залгих болно” гэж бичигдсэн байдгийг санацгаав.”

Иохан 2:13-17

ЕСҮС ДОТОРХ БУРХАНЫ ГАЛ

Заримынх нь хувьд энэ нь хүндэтгэлийн газар байв. Заримынх нь хувьд энэ нь дураараа бизнес хийх газар байв. Харин хүүгийн хувьд энэ нь Түүний Аавын өргөө - ариун дагшин газар, аврал, эдгэрэл, үндэстнийг чөлөөлөх залбирлын газар байлаа. Тиймээс л Тэрбээр амь биеэ хайрлалгүй мөнгө солигч, хулгайч, завхруулагч нарыг ташуурдан, Фарисайчуудын өөдөөс хилэглэжээ. Гэхдээ Бурхан Аавд нь өргөх хүндэтгэл дээсэн дээр дэнжигнэж, улс үндэстний чөлөөлөлт тэнцэн ядан байхад, Тэрбээр хийх зохилтой зүйлээ хийж, үхлийн өөдөөс инээжээ. Явах ёстой бол загалмай руу ч явна. Юутай аймшиггүй галтай зүрх вэ?

БУРХАНЫ ГАЛЫГ ХҮН “ГАЛТАЙ ЗҮРХ” ГЭЖ ХӨРВҮҮЛЖ ОЙЛГОЖ БОЛОХ. Есүс зөвхөн галтай үг яриагүй. Есүс Иерусалимыг эцсийн удаа зорихдоо, дагалдагч нарынхаа өмнө алхалж байсан гэдэг. Түүнийг яарч байхыг дагалдагч нар нь харсан. “Тэд Иерусалимд очихоор замд явж байв. Есүс өмнө нь явж байлаа. Тэд гайхаж байсан бөгөөд дагалдан явагсад айж байв” (Марк 10:32). Яагаад? Энэ бол Түүний явдлаас нь хүртэл мэдрэгдэх галтай зүрх байв.

Зорьсон газраа ирээд Есүс сүмийн ялзралыг үзжээ. Тэгтэл дагалдагч нар Есүсийн галтай зүрхийг дахин харсан. Галтай зүрх нь Есүсийг аймаар бас гайхмаар Нэгэн болгожээ. Дагалдагч нар Дуулал 69:9 дээрх үгийг санав: “Таны өргөөний төлөөх зүтгэл Намайг залгиж, Таныг буруутгасан хүмүүсийн буруутгал Над дээр буув.” Гэхдээ энэ нь харгис хүйтэн хилэн бус, харин хайраар бадарсан хилэн байлаа. Есүс зүгээр л нэг галзуурсан фанат байгаагүй. Тэрбээр Аавынхаа өргөөнд дэндүү хайртай байжээ. Тэрбээр сүмийг хүмүүсийн ирж, эрх чөлөө, аз жаргалтайгаар Бурханыг хүндэтгэдэг газар байгаасай л гэж хүсчээ. Гэтэл арилжааны үзэл санаа нь энэ бүхнийг завхруулсан байв. Тиймээс Есүсийн зүрх галт уул шиг савсжээ. Ариун Сүнсний гал л Түүнийг сүмийг цэвэрлэхэд хүргэсэн бөгөөд Түүний үйлдлээс айсан олон хүн тэндээс арилан одсон байна.

Гэвч сохор, тахир татуу хүмүүс нь үлдэж, Тэрбээр тэднийг эдгээжээ (Матай 21:14-16). Есүс үүнийг л хийхийг хүссэн бөгөөд тиймдээ ч улангасан хилэгнэсэн билээ. Тэрбээр баяр хөөрийн төлөө л уурлажээ. Тэгээд ч амжилтад хүрч - эцэстээ хүүхдүүд “Хозанна!” хэмээн дуулсан билээ. Энэ нь Бурханд баярласан баяр хөөрийг зэмлэж, Эзэний талбайд дуугаа аядахыг шаардсан Бичээс дээрх цорын ганц тохиолдол - тэмдэглэл билээ. Үүнийг Фарисайчууд л шаардсан бөгөөд учир нь тэдний наймаа Эзэний магтаалын хөлд үрэгджээ. Зоосны жингэнэх аялгуу унтрав! Энэ бүхэн нь Эзэний ер бусын магтаалд зам засахаар урлагдсан, галгигч галын л нэгээхэн зураглал байв.

ТЭНГЭРЛЭГ АНХААРУУЛГА

“Баярын их өдөр болох сүүлчийн өдөр Есүс зогсоод хашхиран —Цангасан хүн байвал Над уруу ирж, уугтун. Бичвэр хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно гэв.”

Иохан 7:37,38

ХУУЧИН ГЭРЭЭНЭЭС ШИНЭ ГЭРЭЭ РҮҮ

Ариун Сүнсний санал болгож байгаа зүйлсийг ямар ч буян, шашин хангаж чадахгүй. Бурханы Сүнс л хамгийн том өлсгөлөн, цангааг хангадаг. Тэрбээр таны сэтгэлд өөр хэний ч, юуны ч авчирч чадахгүй сэргээш, сэргэлтийг авчирна. Та эцэж цуцаж, хоосорч байгаа бол, Есүс таныг Өөр дээр нь очоод, амралт авч, Ариун Сүнсний гүний усыг уухыг ятгажээ (Иохан 7:37, 38).

УРЬД ХОЖИД СОНСООГҮЙ ХАМГИЙН СОНСГОЛОНТОЙ ЧИМЭЭ. Ийм нэгэн чимээ Иерусалимын сүмийн талбай дээр цугласан мянга мянган хүний чихэнд хадах гэж байв. Үндэсний их баяр наадмын ёслолын төгсгөлийн зан үйл болох гэж байлаа. Нүд бүхэн усаар бөгөөд дарсаар дүүргэсэн алтан савыг алдалгүй ширтэж байв. Эзэнд ундаан тахилыг өргөхөд бэлэн болжээ. Тахилч гялтганах савыг нарны цацраг өөд өргөөд, хөшив. Хүмүүс тахилын ширээн дээрх хүрэл саванд ариун ус цалгин буухыг сонсохоор, нам болцгоолоо. Тэгтэл гэнэт нэгэн дуу! Мянган жил сонсогдоогүй, шар үс босгомоор дуу хоолой. Тэр бол Бурханы Хүү Есүс Христийн дуу байв. Тэрбээр эхэнд дуугарч, тэнгэр газрыг буй болгосон Бурханы Үг байв. Тэгтэл одоо Иерусалимд зогсоод, Бурханы таалмыг мэдэгдэн, Хааны бөгөөд Тэнгэрийн тушаалыг айлдруун: “Цангасан хүн байвал Над уруу ирж, уугтун. Бичвэр хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно.” Ариун Сүнсний үе манджээ.

БАЯРЛАН ХАШХИР

Бичвэр хэлсэнчлэн “Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно. Та нар Түүнийг хараагүй ч Түүнийг хайрладаг. Эдүгээ та нар Түүнийг харахгүй байгаа ч Түүнд итгэдэг. Та нар хэлэхийн аргагүй, алдраар дүүрэн баяр хөөрөөр ихэд баярладаг” (Иохан 7:38, 1Петр 1:8).

БИЧЭЭС АРИУН СҮНСНИЙ ТАЛААР ЯРИХДАА, “голууд” гэдэг үгийг ахин дахин хэрэглэдэг бөгөөд энэ нь итгэгчдийн хувьд төгс дүрслэл юм. Голууд нь Ариун Сүнсний билэгдэл болно. Энэ тухай “Чи... ширгэшгүй устай урсгал мэт байх болно” хэмээн Исаиа 58:11 дээр хэлсэн. “Голуудыг” үзэхийн тулд Ариун Сүнсний гайхамшигт оршихуй шаардлагатай. Олон хүний хувьд сэтгэл хөдлөлөө гаргах нь хэвийн бус, зохимжгүй, улаймаар явдал байдаг. Гэхдээ Бурханы Хаанчлалын хүн дэлхийн соёлыг хэрэгсдэггүй. Манай Хаанчлал дотор хүмүүс хөөрөн хашхирдаг. Бид: “Христ амласнаа биелүүлж, Ариун Сүнс дотор болоод гал дотор хүмүүстээ хийсэн баптисмын үйл явдал нь ямар байх ёстой вэ? Өөртөө ханасан, баригдмал, зэврүүн үйл явдал байж таарах уу?” гэж л асуух хэрэгтэй. Бурхан тарвасны биш, галын сүлдтэй юм шүү.

ТӨЛӨГДСӨН

“Та нар Сүнсийг хэрхэн хүлээн авсан юм бэ? Хуулийн үйлсээр үү? Эсвэл сонссондоо итгэснээр үү? Зөвхөн үүнийг л та нараас мэдэхийг би хүсэж байна. Та нар тийм мунхаг гэж үү? Сүнсээр эхэлж, одоо та нар махбодоор төгс болгогдож байна гэж үү?”

Галат 3:2, 3

ҮРГЭЭХ ЭСВЭЛ ТАТАХ

Үүнийг тэмдэглэнэ үү. Бидний мөхөс байдал Бурханыг холдуулах биш, харин ч татдаг. Бидэнд найдвар байхгүй байв ч, Бурханы Сүнс нь чухамлан мөхөс хүмүүсийн дорой байдлыг нөхөхөөр өгөгдсөн бэлэг болой. Тэр эцэж ядарсанд тэнхээ өгч, Чадал барагдсанд нь хүч нэмдэг (Исаиа 40:29).

“ГАЙХАМШИГТ ХАЙР ЮУТАЙ ИХ ХАЙР, ЭГШИГ ЯРУУ ИХ ХАЙР, АМЬДРАЛД ТӨӨРСӨН МӨХӨС НАДАД, АВРАЛ ӨГӨХӨӨР ИРЛЭЭ.” Голгот дээр хүн төрөлхтөнд аврал авчирсан дуу чимээ гарсан бол, Пентекост дээр өөр нэгэн чимээ буюу хүчирхэг хуй салхины дуу чимээ гарсан юм. Энэ нь хүн төрөлхтнийг Өөрийн болгох гэсэн Бурханы Сүнсний чин зүрхний, хайрын чимээ байсан юм. Ариун Сүнс нүгэлт хүн төрөлхтний мөхөс чанарыг бүрэн мэдэж байсан ч, одоо ч таны төлөө энд байна. Бидний зөвт байдал бус, харин нүгэл Есүсийг загалмай руу илгээсэн. Бидний төгс байдал бус, харин мөхөс байдал Ариун Сүнсийг бидэн рүү илгээсэн.

БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭ

Олон итгэгч хүн өөрийгөө Ариун Сүнсийг хүлээж авах үнэ цэнэтэй юмуу хангалттай сайн хүн биш гэж боддог. Тийм ээ, бид Ариун Сүнсний хувьд хангалттай сайн биш гэдэг нь үнэн. Гэхдээ бид сайн байгаад байх ч албагүй! Үнэндээ, бид сайн болж чадна гэдэгтээ ч найдах аргагүй. Тэр бол дэндүү ариун. Гэхдээ тиймээс л Тэр бидэнд хэрэгтэй бөгөөд тиймээс л Тэр ирдэг.

ЭНЭ БОЛ ЕСҮСИЙН ЦУС. ГАГЦХҮҮ ТҮҮНИЙ ЦУС Л БИДНИЙГ зохистой болгодог бөгөөд тэр үед л бид Ариун Сүнсний хүч, бялхлыг хүлээн авдаг (Үйлс 1:8). Христ биднийг мундаг Христэд

итгэдэг хүмүүс учраас бус, чухам биш учраас л Сүнсээ илгээдэг! Бурханы зүрх сэтгэл бүтээлүүдийнхээ авралын төлөө дүрэлзэж байдаг. Тэрбээр дэлхийн тэрбум хүмүүсийг тамын галыг ноцоох түлээ болгох гэж юмуу эсвэл Христгүй, цэвдэг өнө мөнхлөлд унагах гэж бүтээгээгүй. Тэр биднийг тэнгэрийн төлөө бүтээсэн. Бурхан Ариун Сүнсээ буюу Параклет - туслагчаа илгээдэг бөгөөд харин бид Түүний зарц буюу төлөөлөгч нар юм. Тэр Өөрөө бүгдийг хийж чадна. Гэхдээ Тэр биднээс хамтын ажиллагаа хүсдэг.

ТЭГВЭЛ БИДНИЙ АРИУН БАЙДЛЫН ХУВЬД ЯАХ ВЭ?

Бидний ариун байдал нь тэмдэг, гайхамшигийн төлөөх хүч биш юм. Ариун Сүнс бол хүч. Бид мөхөс бөгөөд магадгүй унаж няцдаг байж болох ч, энэ нь биднийг Ариун Сүнсийг хүлээж авах бүр л шаардлагатай болгодог. Биднийг төгс байсан учраас, Ариун Сүнс бидэнд өгөгддөг юм биш. Биднийг төгс бус учраас л, Тэр бидэнд өгөгддөг. ШИЙДВЭРЛЭХ ХҮЧИН ЗҮЙЛ НЬ - БИДЭНД АРИУН СҮНС ХЭРЭГТЭЙ. ТЭГВЭЛ ТАНД ХЭРЭГТЭЙ ЮУ?

ХЭРЭВ ЧУУЛГАН ТӨГС АРИУНТНУУДААР ДҮҮРЭН ДҮҮРТЛЭЭ ТӨӨРӨГСДӨД ХҮРЭХ ЁСГҮЙ ЮМ БОЛ, тэдэнд хэзээ ч хүрэхгүй байх. Төөрөгсдийг аврахын тулд хүлээх ёсгүй. Хүмүүсийг Есүс дээр авчрах нь тэнгэр дүүрэн, там хоосон байхын баталгаа болно. Бурхан хүмүүсийг аврахын төлөө хамгийн том хүчин зүтгэлээ, хамгийн том золиосоо гаргахдаа, биднийг төгс төгөлдөр болтол эсвэл биднийг явдаг "амьд хууль" болтол хүлээгээгүй. Бид Ариун байдлыг хайх ёстой бөгөөд Библи ч биднийг энэ тал дээр урамшуулдаг ч, сэтгэлийн аврал нь биднийг төгс болтол хүлээж боломгүй. Сүнсний бэлэгийг Аугаа захирамжийнхаа цаад гол хөдөлгүүр сэдэл, нөлөөний хүч байлгах нь хэзээд Бурханы төлөвлөгөө байсан билээ. Сүнсний бэлэг байхгүй бол зам байхгүй.

ХУУЧИН АККУМЛЯТОР

Та Сүнсээр тас хөлдсөн байж болно эсвэл итгэлээсээ хол тэнэж одсон байж болно. Гэхдээ та нэгэнт Ариун Сүнсээр хүчирхэгжсэн л бол, яг л хуучин аккумулятор шиг дахин цэнэглэгдэх боломж бий. Та гагцхүү Есүсийн цусаар цэвэрлэгдэх ёстой бөгөөд цэвэрлэгдвээс, цоо шинэ болно.

МИНИЙ НЭГ НАЙЗ ГАРАЖАА ЦЭВЭРЛЭЖ БАЙГААД овоолгоотой хог дунд нэг гялбасан төмөр байхыг үзжээ. Үзтэл тэр нь машины хуучин аккумулятор байв. Аккумуляторынх нь нэг шонд нь утас нь хүрээгүй байв. Тэр аккумулятор бас л жаахан цэнэгтэй байсан тул хэрэглэх боломжтой байж юуны магад хэмээн гаргаж иржээ. Заримынх нь хувьд энэ жишээ сургаалт үлгэр шиг санагдаж магадгүй - та өөрийгөө цэнэггүй, тас буугаад өгчихсөн хэмээн бодож байж болох. Ажиллахгүй ч байж болох. Тэгвэл хогноос нь цэвэрлэ. Тэр цагт Ариун Сүнс тийм ч амархан унтардаггүй болохыг мэднэ. Елиша олон жил эш үзүүлэн, хүчирхэгээр үйлчлээд өөд болсон ч, ясанд нь тосолгоо үлджээ. Нэгэн хүн үхээд, санаандгүйгээр Елишагийн булшин дотор хаягдал, амь орсон байдаг (2Хаад 13:21). Тиймээс танд ч бас найдвар бий.

АРИУН СҮНС БА ГОЛГОТ

Ариун Сүнс Христийн загалмай дээр байгуулсан ялалтуудыг итгэгч хүний дотор, Чуулганы дотор, дэлхийд бодитой болгох зорилготой. Ариун Сүнсний хүч дотор хөдлөхийн тулд Христийн загалмайг ажил, аврал, үгээ болго.

АРИУН СҮНС ӨӨРИЙНХӨӨ АЖИЛД НЭВЧЭЭТЭЙ БҮЙ. ТЭРБЭЭР Есүсийн загалмай дээр гүйцэтгэсэн зүйлийг хүмүүсийн зүрхэнд гүйцэтгэдэг. Та Түүнийг тэр газраас нь холдуулж, Голготын

бус бизнест оролцуулж болох. Гагцхүү авралын авран сэргээлтийн хөрсөн дээр л жинхэнэ сүнслэг хүч байдаг юм. Загалмайгүй гайхамшиг нь Ариун Сүнсний гайхамшиг биш болой.

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 3:

ХҮЧИРХЭГ ХУЙ САЛХИ -
ПЕНТЕКОСТ

АМЛАЛТ БИЕЛЭВ

“Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газар цугласан байлаа. Хүчит хуй салхи мэт чимээ тэнгэрээс гэнэт гарч, тэдний сууж байсан байр бүхэлдээ үүнд автжээ. Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв.”

Үйлс 2:1-4

АРИУН СҮНС ИРЭВ

Ариун Сүнс ирэхдээ, дэлхийн эрэмбийг өөрчилж, жинг Чуулганд ашигтайгаар дарсан юм. Гэхдээ нэг чухал ялгаа бий - гагцхүү Бурханы Хаанчлал л энэхүү аугаа хүчирхэг хүчинд хүрэх боломжтой. Завхарсан үндэстнүүд, ёрын муугийн тэнхлэгүүд бус, гагцхүү бид л хүрэх боломжтой!

ЕСҮС АРИУН СҮНСЭЭ ДЭЛХИЙ РҮҮ ИЛГЭЭЖ, ЭНЭ НЬ буцаахын аргагүй нүсэр үйл явдал болох үед Ариун Сүнсний эрин үе эхэлсэн юм. Энэ нь Адамын үеэс хойш танин мэдэгдсэн бүхнийг хол хаясан, шинэ боломжуудын эрэмбийг бүтээсэн юм. Эдүгээ амьдралын шинэ хэлбэр - амиллын амь боломжтой болсон. Амиллын амь нь яг л цацраг туяа мэт. Гэхдээ цөмийн хорт туяа мэт бус, харин амиллын цацраг туяа мэт. Есүсийг үхлээс амилуулсан тэр л Сүнс биднийг сүнслэг дэвшил, хүчийн амь руу босгоно (Ром 8:11).

АРИУН СҮНС ИРСЭН НЬ

Ариун Сүнс аврал авчрахын тулд Эзэн Христ дотор суурьшсан ч, авралыг номлохын тулд Хурганы нандин цусаар цэвэрлэгдсэн үндэстэн үндэстний, аймаг аймгийн эрчүүд, эмэгтэйчүүдийн дотор буюу Чуулганы дотор суурьшсан юм.

АРИУН СҮНС ИЕРУСАЛИМ ДАХЬ АЙЛЧЛАЛАА 120 хүний дуу хоолойгоор зарласан бөгөөд Өөрийгөө дагалдагч нарынхаа биеэр ороожээ. Бид бол Түүний сүм, Түүний газар дээр оршин суух газар билээ. Тэр эгшнээс дагалдагч нарын амьдрал орвонгоороо эргэв. Тэд Бурханы алдрыг урам зориг, эдгэрэл, гайхамшиг, эш үзүүлийн тэмдгээр бөгөөд гайхамшгаар гэрэлтүүлэхэд, хүмүүс тэднийг Есүстэй хамт байсныг нь харжээ (Үйлс 2). Учир нь тэдэн дээр

Есүсийн Ариун Сүнс байв. Ариун Сүнс Чуулган дотор суурьшсан бөгөөд тэр цагаас хойш буцаагүй юм. Өнөөдөр тэр л Ариун Сүнс бидний дотор байж, биднээр дамжин ажиллаж байна.

БҮГДИЙН ТӨЛӨӨ

Ариун Сүнс цөөн хэдэн ялагчтай сугалаагаар ирдэггүй юм. Энэ бол “азын” тоглоом биш. Ялагч юмуу ялагдагч гэж байхгүй. Бурхан дууддаг хүмүүсээ боловсруулдаг. Бурханд хүмүүсээ бүрэн бүслэх хангалттайгаас ч хангалттай хүч бий. Хэн ч хаягдахгүй, хэн ч шавхруу хүртэхгүй. Хэдийнээ хүлээн авагдсан байж өөрийгөө бүү хас.

БИЧЭЭС ЯМАР Ч ЭРГЭЛЗЭЭГҮЙ, МАШ ТОДОРХОЙ БАЙДАГ. Ариун Сүнс доторх баптисм нь “Бурханы амины хэдэд” зориулсан эд биш. Бурханд “амины хүүхдүүд” байхгүй. Үнэндээ бид бүгдээрээ Түүний амины хүүхдүүд юм. Пентекост өдөр 120 эрэгтэй, эмэгтэй хүн Иерусалимын дээд өрөөнд байсан бөгөөд Үйлс 2:3,4 дээр “Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:3,4) гэдэг. Тэнд ямар ч СУГАЛАА юмуу тохиолдол байгаагүй! 120 хүн зуун хориулаа хүлээн авсан бөгөөд “бүгдээрээ” дүүрсэн юм. Тэд нас, хүйс, угсаа, амьдралын зиндаагаараа шилэгдээгүй. Та ч Ариун Сүнсний баптисмд тэнцэнэ! Энэ нь Бурханы цусаар угаагдсан бүх хүүхдэд буюу та бид хоёрт зориулагдсан юм. Бурханы хүч хязгааргүй, Түүний түлш дуусахгүй. Тэрбээр өлсөж цангасан хүмүүстээ хангалттайгаас ч илүү хүч өгч чадна.

ТОЛГОЙ ДЭЭРХ ДӨЛ

Дээд өрөөнд 120 хүн байжээ. “Хүн болгон дээр нэг, нэг дөл” буусан учраас, тэнгэрт хэн нэг нь тэдгээр толгойнуудыг тоолсон

байж таараа. Танд толгой байгаа бол, танд зориулсан дөл Бурханд бий. Та яг одоо Түүний тоонд багтаж байна. “Та нар хүчийг хүлээн авна...” (Үйлс 1:8). Таны толгой Ариун Сүнсний галт дөлийн газардах газар болно гээд төсөөл дөө. Тэрбээр газардаж, суурьшаад тэгээд хэзээ ч явдаггүй.

ПЕНТЕКОСТ ӨДӨР АРИУН СҮНС ДОТОРХ БАПТИСМЫГ 120 ДАГАЛДАГЧ БҮГДЭЭРЭЭ ХҮЛЭЭН АВСАН. Хэн ч орхигдоогүй. Ариун Сүнс нь дан ганц Есүстэй ойр амьдарсан 12 дагалдагчид зориулагдаагүй юм. Ариун Сүнсийг хүлээн авсан хүмүүсийн дунд нэр дурьдагдаагүй маш олон хүн байсан. Тэд алдартай байгаагүй байж болох ч, итгэмжтэй байсан юм. Тэд Дээд өрөөнд ирээд, амлалтыг хүлээсэн. Ариун Сүнс бүгдийнх нь дээр ирж, бүгдийнх нь дээр галан дөлүүд буусан - 120 итгэмжтэй хүн дээр 120 галан дөл. Хэрэв та тэнд байсан бол, даалгавраа биелүүлэх хүчийн дөл хүлээн авах байж.

СТИМУЛЯТОР

Ариун Сүнс биднийг тэнгэрлэг мөн чанартай зэрэгцүүлээд, Бурханы Хаанчлалын төлөвлөлтийн дагуу Түүний төлөвлөгөө, зорилготой зэрэгцэн алхах чадвартай болгодог. Ром 8:14 дээр “Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм” гэдэг.

СТИМУЛЯТОР ГЭДЭГ НЬ ХЭВИЙН БУС ЗҮРХНИЙ ХЭМНЭЛИЙГ ХЯНАХАД ТУСЛАХ зориулалттай, цээж юмуу хэвлий дотор байршуулдаг жижиг төхөөрөмж юм. Итгэгч хүн бүр дээрх Ариун Сүнсний дөл нь стимулятортай төстэй юм. Энэ нь хэвийн бус хэмнэлийг засч, биднийг Бурханы зүрхтэй хослон зохицуулдаг юм. Түүний зорилго уу, бидний зорилго уу? Түүний хүсэл үү, бидний хүсэл үү? Миний нэрийг тээдэг, миний толгой дээрх дөл нь намайг Бурханы зүрхний хэмнэлтэй зэрэгцэж алхахад хүргэдэг.

АРИУН СҮНСНИЙ ХУВИЛАЛ

Бурхан Аав биднийг авруулахаар Хүүгээ илгээсэн шигээ мөн биднийг дүүргэж, хүчирхэгжүүлэх гэж Сүнсээ илгээсэн юм. Ариун Сүнс биднийг сайн байсан учраас бус, харин бидэнд Туслах бөгөөд Тайтгаруулагч хэрэгтэй байсан учраас, Аавын хайр, Хүүгийн золиосын ачаар ирсэн юм.

ПЕНТЕКОСТ ӨДӨР ТЭД САЙН МЭДЭЭГ “ТЭНГЭРЭЭС БУУЖ ИРСЭН СҮНСЭЭР” (1Петр 1:12) номлож эхэлжээ. Есүс тэнгэрээс ирсэн шиг л Ариун Сүнс энэ дэлхийд эерэг буулт, оролт болж ирсэн юм. “Үг нь махан бие болсон” (Иохан 1:14) буюу тэр нь Бетлехемийн хаалгаар орж ирсэн Есүс байв. Есүс хүний хэлбэрээр хувцаслан ирсэн шиг, Ариун Сүнс дагалдагч нарын дотор суурьшин нутагласан билээ. Дэлхий Есүсийг хүлээн аваагүй боловч, Есүст хайртай зуу зуун хүн болоод тэднээс 120 хүн дэлхий дээрх Сүнсээр дүүрэн хүмүүс буюу эрчүүд, эмэгтэйчүүд, элч, дагалдагч болсон билээ. Тэд хамтдаа зогсоогүй, өвдөглөөгүй, залбираагүй, харин зүгээр л хамтдаа суугаад, Есүсийн “Иерусалимыг үл орхиж, Эцэгийн амласныг хүлээ” (Үйлс 1:4) гэсэн тушаалын дагуу л хүлээж байжээ. Христ тэнгэр өөд өргөгдөөд, Ааваасаа “нөгөө бэлэгээ” буюу Ариун Сүнсээ илгээхийг гуйсан байв.

НЭГ МЭТ ХАМТДАА

Пентекост өдөр Бурхан, хүн хоёр нэг карисматик хэлээр нэгэн хүн мэт хамтдаа баярлан тэмдэглэжээ. “Хэлээр ярих” (Үйлс 2) гэдэг нь Сүйт бүсгүй Тэнгэрлэг Сүйт хархүүгийнхээ тэвэрт очиж байгаа явдал билээ (Колоссай 2:9-10).

БУРХАН, ХҮН ХОЁРЫН ХАМГИЙН ТОМ ХУВААГДАЛ НЬ БАБЕЛИЙН ҮЕД ТҮЙЛДАА ТҮЛЖ, Бурхан бууж ирээд, хүн төрөлхтний хэлийг самууруулсан юм (Эхлэл 11:1-9). Гэвч Бурхан Бабелийн үед хийсэн зүйлээ Пентекост өдөр эргүүлж, хүмүүсийг олон янзын хэлээр нэгтгэсэн билээ. Бурхан биднийг бүхий л амьдралын алхам, угсаа, соёл дундаас цусаараа худалдан авч (Илчлэл 5:9,10), хүний алдар, бүтээлч байдлын төлөө бус, харин Өөрийнхөө алдрын төлөө Хаанчлалаа байгуулахаар биднийг нэгтгэсэн болой. Хүн төрөлхтөн, Бурхан хоёр Ариун Сүнсээр нэгэн ерөөлт хэл дотор нэгдэн нийлсэн сүр дуулиант явдлыг тэмдэглэн баярласан болой.

ЭШ ҮЗҮҮЛСЭН САЙН МЭДЭЭ

“Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байж. Энэхүү чимээнээр үй олон цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ. Гайхаж алмайрсан тэд —Энэ ярьж байгаа чинь бүгд галилчууд биш үү? Гэтэл бид төрөлх хэлээр маань хүн бүр ярихыг сонсох нь юу вэ? Партчууд, медчүүд, еламчууд мөн Месопотами, Иудей, Каппадок, Понт, Ази, Фруг, Памфул, Египет ба Курений хавийн Ливийн хэсэгт суугчид болон Ромоос ирэгсэд болох иудейчүүд бас шинэ итгэлтнүүд, крэтчүүд, арабууд бид нар Бурханы аугаа үйлсийн тухай тэдний яриаг өөр өөрийн хэл дээр сонсоцгоолоо гэв. Тэд бүгд гайхшран алмайрсаар өөр хоорондоо —Энэ юу гэсэн үг вэ? гэгцгээв.”

Үйлс 2:5-12

ГАЛ БА МАХАН БИЕ

Сүнс холбогдохыг хүсдэг. Пентекост өдөр Дээд өрөөнд байсан хүмүүсийн толгой дээрх галан хэл тэдний аман доторх махан биеийн хэлтэй холбогдож, үр дүнд нь итгэгч хүмүүсийг өөрчилж, дэлхийг өөрчилсөн сүр жавхланта, хүчирхэг эш үзүүлэл, үндэстэн дамнасан Сайн мэдээний тэсрэлт болов.

ЭЛЧ ИАКОВ БИДЭНД ХҮНИЙ ХЭЛИЙН ТАЛААР МАШ ХҮЧИРХЭГ УХААРАЛ ХАЙРЛАХДАА, бид нэг л амаараа Бурханыг ерөөгөөд, бусдыг хараадаг (Иаков 3) гэсэн. Гэхдээ Пентекост өдөр жирийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс Бурханд захирагдах үед тэдний хэл нь хүч ба авралын зэмсэг болжээ. Толгой дээрх галан хэлүүд нь тэдний аман доторх махан хэлтэй нь холбогджээ. Тэнгэрлэг нь газрынхтай холбогдож, ер бусын нь жирийн зүйлтэй холбогдов. “Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:4).

АВАРДАГ ҮНЭН

Пентекост өдрөөс хойш Ариун Сүнс хүмүүсийн хэлийг ХӨНДӨХӨД, Бурхан хүний дуу хоолойгоор ярих болов. Энэ нь зүгээр нэг онгод байсангүй. Анхны итгэгч нар Ариун Сүнсээр дүүрсэн. Бурханы ТӨЛӨӨ ярьдаг хүмүүс чинь БурханААР ТЭСРЭН ярьжээ. Энэ нь “ҮГИЙН” үүд байв (Колоссай 4:3). Жинхэнэ номлол нь АВАРДАГ НОМЛОЛ юм. Ариун Сүнс хүмүүсийн сэтгэлийг Диаволаас аврах хүчээрээ номнолыг хүчирхэгжүүлдэг. “Түүний Үг зүрхэнд минь улалзах гал мэт байв” (Иеремиа 20:9).

ПЕНТЕКОСТ ӨДӨР “Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч,

мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:3-4) гэдэг. Ариун Сүнс дагалдагч нарын залбирал, магтаал, номнолыг эрч хүчээр өөрчилсөн. Дагалдагч нарын гайхамшиг, гал, хүчээр дүүрэн магтаал нь угсаа гарлын хил хязгаарыг хага яржээ (Үйлс 2:5-12). Маанийн янзтай, хүйтэн магтаалтай сүсэгтнүүд анх удаагаа Ариун Сүнсний өгсөн хүндэтгэл, магтаалын давалгааг мэдэрсэн юм. Петр ер бусын зориг, үнэмшлээр номлож, тэр өдөр 3,000 хүн аврагдан, Чуулганд нэмэгдэв.

БУРХАНЫ УГСААТНЫ СОНИРХОЛ

Бурханы зүрх хэзээд бүх хүний төлөө - бүх үндэстэн ястны төлөө байв. Тэр, хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүснэ (2Петр 3:9). Ариун Сүнс үндэстэн үндэстний, овог овгийн, угсаа угсааны, соёл соёлын хүмүүсийг хүсдэг бөгөөд үүнийхээ төлөө ч таныг хүчирхэгжүүлдэг. Хаа ч байсан, Бурханы төлөө ажилла. Гэхдээ даян дэлхийн ургацын төлөө залбир. Соёлын бөгөөд газар зүйн хязгаарыг давахаас бүү ай.

ПЕНТЕКОСТ ӨДӨР АРИУН СҮНС БУУЖ ИРЭХЭД, Еврей дагалдагч нар Еврейгээр бус, харин алс холын улсуудын хүмүүсийн хэлээр ярьсан нь (Үйлс 2:8-12) Бурханы Сүнсний угсаатны сонирхлыг харуулж, Түүний бүх хүнийг гэх хайр, найдварт эргэлзэх хамаг эргэлзээг арилгав. “Сүүлийн өдрүүдэд Бурхан хүн бүр дээр Сүнсээ цутгана” (Иоел 2:28-32) хэмээн Иоелээр хэлсэн Бурханы амлалт Пентекост өдөр биелсэн. Бурхан Сүнсээ бүх хүмүүс дээр асаахыг хүсдэг. Сайн мэдээ ч үүнийг хэлдэг. “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн тул Хүүд итгэдэг бүхэн мөхөхгүй харин мөнх амьтай байх болно” (Иохан 3:16). Бурхан дэлхийн төлөө Хүүгээ өгсөн бол, Ариун Сүнсээ ч өгнө гэдэг нь утга төгөлдөр юм. Тэр бидний авралын төлөө Хүүгээ өгөөд, биднийг хүчирхэгжүүлэхийн төлөө Сүнсээ өгчээ.

ПЕНТЕКОСТЫН САЙН МЭДЭЭ

Харин Петр арван нэгийн хамт босоод, дуугаа өндөрсгөн, тэдэнд тунхаглаж —Иудейн эрчүүд ээ, Иерусалимын бүх оршин суугчид аа! Үүнийг та нар мэдтүгэй, үгийг минь сонордтугай... Израиль эрчүүд ээ, эдгээр үгсийг сонсоцгоо. Та нарын мэдсэнчлэн, Бурхан та нарын дунд Түүгээр үйлдсэн хүчирхэг үйлс, гайхамшиг болон тэмдгүүдээрээ Бурханаас та нарт илэрхийлсэн Хүн нь Назарын Есүс бөгөөд тогтоосон шийдвэр ба урьдаас Бурханы мэдсэний дагуу тушаагдсан Түүнийг та нар хуульгүйчүүдийн гараар хадаж алсан. Тэрээр үхэлд автсаар байх боломжгүй тул Бурхан үхлийн шаналлыг устгаж, Түүнийг амилуулав. Петр тэдэнд —Гэмшигтүн, хүн бүр Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Ингэснээр та нарын нүгэл уучлагдаж бас та нар Ариун Сүнсний бэлгийг авах болно.

Үйлс 2;14, 22-24, 38

АРИУН СҮНСНИЙ ЭР ЗОРИГ

Ариун Сүнс тан дээр ирэхэд, та гагцхүү тэмдэг үйлдэх хүч хүлээж авдаггүй. Тэр таныг бие, сэтгэл зүй, сэтгэл мэдрэмжийн хувьд хүчтэй болгодог. Сүнсний баптисм нь эр зориг хайрлаж, адгийн хулчгар ч хамгийн баатарлаг, зоригт хүн болж чадна.

ДАГАЛДАГЧ НАРЫН ГАГЦХҮҮ ЕСҮСИЙГ ХАРЖ, ТҮҮНИЙ ДУУ ХООЛОЙГ СОНССОН явдал нь тэднийг хожмын эрэлхэг зоригт хүмүүс болгоогүй юм - тэдний зарим нь эргэлзэж ч явсан (Матай 28:17, Марк 16:13-14, Лук 24:41). Тэд Иүдейчүүдээс айгаад үүдээ түгжсэн (Иохан 20:19). Тэд “Есүс амьд!” гэж гудамжинд хашхирах ч зориггүй, айсандаа нууцаар уулзаж байсан юм шүү. Эхэндээ тэд холын Галилд очоод, урьдын загасчлах ажилдаа ч эргэж орсон (Иохан 21:3). Гэтэл Пентекост өдөр тэд Ариун Сүнсний баптисм, эр зоригийг хүлээж авахад, энэ бүх байдал өөрчлөгджээ. Тэд Иүдейчүүдээс айхын оронд цугласан олон тэдний өмнө бэмбэгнэж: “Эрчүүд ээ, ахан дүүс минь, бид одоо яах ёстой вэ?” (Үйлс 2:37) гэж хашхирсан. Энэ нь Есүсийн “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иүдей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно” (Үйлс 1:8) гэдэг үгийн биелэл байв.

АРИУН СҮНСНИЙ ЗОРИЛГО

Аав ямар зорилгоор Ариун Сүнсээ илгээв? Газар дээрх бүтээл бүрт Сайн мэдээг номлох боломжтой болгохын тулд гэдэг нь эргэлзээгүй.

ПАУЛ ҮҮНИЙГ ҮНДЭСТНҮҮДИЙГ САЙН МЭДЭЭНИЙ ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛД АВЧРАХ (Ром 1:5) явдал хэмээн дүрсэлдэг. “Алдагдсан зүйлээ хайж, аврахын” (Лук 19:10) төлөө

дүрэлзсэн сэтгэл нь Христийг залгисан юм. Есүс зүгээр нэг гайхамшиг үйлдэгч байгаагүй юм шүү. Тэрбээр нэн тэргүүнд Аврагч байв. Энэ ажил л Түүнийг загалмайд хүргэсэн. Энэ нь Түүний газар дээрх амьдралын туйлын зорилго байв. Олныг хоолох гэх мэт олон нийтийн төлөөх буюны ажил бус, харин хүн төрөлхтнийг аврах үйлс. Тэр үүнийг л бодсон. “Том том ажлын” талаарх алив яриа бүхэн нь Түүний алдагдсаныг аврах “аугаа ажилтай” эгнэх ёстой. Аврал нь Бурханы урьд хожид үйлдсэн хамгийн аугаа хөдөлмөр, гайхамшиг билээ.

АРИУН СҮНС - БИБЛИЙГ ХӨРВҮҮЛЭГЧ

Ариун Сүнс Бичээсийг гэрэлтүүлж, Бурханы Үгийг ойлгох ойлголт, Бичээс дэхь нууцыг илчилдэг. Үг дээр гэрэл тусгадаг Библийн зохиогчгүйгээр, бид зүгээр л таамаглахаас өөр гарцгүй болно.

БИБЛИЙН ХӨРВҮҮЛГИЙН АЛТАН ДҮРМИЙГ ПАУЛ ӨӨРӨӨ 1Коринт 2:12-13 дээр хуваалцсан буй: “Бурхан бидэнд бэлэглэсэн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханы Сүнсийг хүлээн авсан юм. Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургаснаар, сүнслэг зүйлсийг сүнслэгт нь тайлбарлан ярьдаг.” “Сүнслэг зүйлс” хэмээн орчуулсан үг нь 1Коринт 12:1 дээр “сүнслэг бэлэг” хэмээн буулгасан фнеуматика гэдэг үг юм. Библийг таамгаар ойлгож болохгүй. Тиймээс Библийн хөрвүүлэгч Ариун Сүнсийг ашигла.

ХОРОО БАЙГУУЛААГҮЙ

Ариун Сүнсээр дүүрэн ганц хүн нь нэгэн хүний хэлснээр “минутыг хэмнэх атлаа цагийг алдуулдаг” 100 хорооноос дээр юм. Бурхан дэлхийд дэндүү хайртай гэж хэлэхдээ, хороо байгуулалгүй, харин Хүүгээ илгээсэн бөгөөд харин Хүү нь Ариун Сүнсээ илгээжээ

(Иохан 3:16, Лук 24:49). Христэд итгэдэг хүмүүсийг дэлхийн гэрэл гэсэн. Гэхдээ бидэнд биднийг асаах Ариун Сүнс хэрэгтэй. Та Ариун Сүнтэй залгаатай байна уу?

ПЕНТЕКОСТ ӨДӨР ПЕТР БОСООД, өөрийнхөө ичгүүр, айдсыг гэвж хаяад, өөрийнхөө мэддэг цорын ганц теологийг буюу Есүсийн тухай, Есүсийн загалмайн тухай ярьжээ. Тэгтэл ямар ч хороо, төсөв, санхүүгийн хуралгүйгээр үндэстэн үндэстний 3,000 хүн аврагдав. Энэ бол Ариун Сүнсний хүч. Тэрбээр Сайн мэдээг амьдруулж, олон түмнийг ятгадаг. Хэрэв бид Ариун Сүнсэнд илүү анхаарбал, хороондоо бага цаг зарцуулж, илүү их үр дүн үзнэ.

ГАЛТ ХОСЛОЛ

“Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг татахгүй л бол хэн ч Над уруу ирж чадахгүй. Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. ... Амь өгдөг нь Сүнс, мах бол ашиггүй юм. Миний та нарт хэлсэн үгс бол сүнс ба амь билээ.”

Иохан 6:44, 63

САЙН МЭДЭЭ БА АРИУН СҮНС - ГАЛТ ХОСЛОЛ

Юу ч болж байсан Сайн мэдээний үнэнийг номло. Үүн шиг чухал даалгавар, үүнээс дээр захирамж гэж байхгүй ч, Ариун Сүнсний хүчгүйгээр энэ бүхэн нь хоосон үг, баримт, түүх, тойм л болно. Онхолдсон галт тэргэн доторх сонин зорчигчдыг аварч чадахгүй шүү дээ.

ҮНЭН ГАЙХАМШИГТАЙ БОЛОВЧ ДАНГААРАА ҮХМЭЛ. Яг л амбаарт байгаа нүүрс шиг. Бидэнд Ортодокс Библийн сургаалаас илүү зүйл хэрэгтэй. Нүүрс галтай нийлж байж л элч гаргадаг шиг, Ариун Сүнсний гал байж байж л үнэнийг бадраана (Лук 24:32). Есүс “Амь өгдөг нь Сүнс, мах бол ашиггүй юм. Миний та нарт хэлсэн үгс бол сүнс ба амь билээ” (Иохан 6:63) гэсэн. Ариун Сүнсээр баптисм хийлгэсэн Есүсийн үг номлогдохдоо, хоосон үг төдий байлгүй, харин амь, үнэмшил тээсээр, 2,000 жилийн дараа ч даян дэлхийн хэдэн тэрбум хүний амьдралыг өөрчилсөөр байна.

САЙН МЭДЭЭНИЙ НУУЦ

Ариун Сүнсний хүч нь яг л усан цахилгаан станцаас гардаг эрчим хүч мэт юм. Тийм боловч бид Ариун Сүнсийг залбирал, хөлс, зовлон, цаг, хүчин зүтгэл, сайн үйлс зэргээр асаахгүй. Аав Сүнсээ бидэнд бидний хүчин зүтгэлээрээ олж авдаг шагнал, хөлс мэтийн зүйл болгож өгөөгүй, харин бэлэг болгож өгсөн.

ӨНӨӨДӨР БОЛ АРИУН СҮНСИЙГ ТАНИН МЭДЭХ ОРГИЛ ЦАГ. Тэр бол Сайн мэдээний нууц хүч. Сүнсийг хүлээн авахын тулд зөрчилдөж, хөлсөө урсгалгүй, зүгээр л Түүнийг урих хэрэгтэй. Бид Ариун Сүнсний хүчийг үйлдвэрлэдэггүй эсвэл Ариун Сүнсийг үр нөлөөтэй болгодоггүй. Тэр бол Бурханы бэлэг (Лук 11:13). Сайн үйлс

шаардлагагүй. Хэрэв бид Ариун Сүнснийг хүлээн авахад зохистой боллоо мундаг юм бол, бидэнд Ариун Сүнс шаардлагагүй шүү дээ.

БЭЭЛИЙ ДОТОРХ ГАР

Ариун Сүнсний хүчгүйгээр Сайн мэдээ үр нөлөөгүй бөгөөд хоосон болно. Энэ нь бурханлаг хэлбэртэй боловч, авран, өөрчлөх хүчгүй байна.

САЙН МЭДЭЭ НЬ ХҮНИЙ БҮТЭЭЛ ЮМУУ ДААЛГАВАР БИШ. Сайн мэдээний Зохиогч нь Бурхан бөгөөд үүнийгээ дэлхийд тараагаарай хэмээн хүн төрөлхтөнд захирамжилсан билээ. Ариун Сүнс нь номлогдсон Сайн мэдээний бээлий доторх гар шиг юм. Сайн мэдээ нь Тэнгэрлэг тосолгоо дор номлогдох ёстой бөгөөд ингэж байж л зорьсон үр дүндээ хүрнэ. Энэ нь Аугаа захирамжийн биеллийг баталгаажуулах хүч юм.

ГАЛЫН ДАМЖУУЛАЛТ

Сайн мэдээ нь Бурханы дуу хоолой л гэсэн үг юм. Сайн мэдээ нь Ариун Сүнсээр дүүрэн хүнээр юмуу Галт Чуулганаар номлогдох үед хүмүүс сонсдог. Сайн мэдээ нь Бурханаас эхтэй галын дамжуулалт юм. Сайн мэдээгүйгээр, галгүйгээр хичнээн мундаг зохион байгуулсан ч, сонсогч хүмүүс хүйтэн бөгөөд үхмэл үлдэх болно. Сүржин даржин байдал нь хүч чадал биш юм. Сүнс л Үгийг амьд болгодог (Иохан 6:63).

ЭНЭ БОЛ ОЛИМПКИЙН БАМБАР БИШ. Энэ нь өнө мөнхлөлөөс цаг хугацаа руу, нэг үеэс нөгөө үед дамжсан Ариун Сүнсний галт бамбар юм. Галт бутнаас Мосегийн харсан тэр гал дагалдагч нар

дээр бүүжээ (Гэтлэл 3:1, 2). Энэ гал Соломоны тахилын ширээн дээр асч (2Шастир 7:1), Пентекост өдөр дагалдагч нарын толгой дээр буусан (Үйлс 2:3). Бурханы Өөрийнх нь галан хэлүүд шиг гал өдгөө зүгээр нэг үзвэр юмуу илрэл шиг бус, харин хүн бүрийн толгой дээр бууж, Бурхан - хүн хоёрын дунд бодитой бий болжээ. Тэр бол дүрэлзэх галын Бурхан. Бид сүнсээр таг харанхуй хүйтэн дэлхийд аж төрж байна. Хөлдөхөөс хамгаалах шилдэг арга нь Ариун Сүнсээр шатах юм. Бурхан таныг асаагуур болгох гэж таны зүрхэн дэхь тахилын ширээн дээр гал асаадаг юм.

ХАРЬ ҮНДЭСТЭНҮҮДИЙН ГЭРЭЛ

“Тэр “Иаковын овгуудыг босгон, Израилийн нөөцлөгдөн үлдэгсдийг сэргээхийн тулд Чи зарц минь байх нь өчүүхэн хэрэг. Авралыг минь газрын хязгаарт хүргэхийн тулд Би Чамайг үндэстнүүдийн гэрэл болгоно” гэв.”

Исаиа 49:6

ҮНДЭСТНҮҮДИЙН ЭДГЭРЭЛ

Амьд Бурханы Сүнсээр Үгийг номлохуй дор үндэстнүүдийн эдгэрэл оршино. Гэхдээ биднээс эхэлнэ. Бид яваад, Үгд итгэж, Сүнсний хүчээр нөлөөлөгдөж, өөрсдөө чөлөөлөгдөх ёстой. Бид халуу шатахдаа, яг л сайн Самари хүн шиг дэлхийн шороотой зам дээрх Бурханы эдгэрлийн төлөөлөгч нар болж, Диаволын хохирогч нарыг эдгээнэ.

“ТИЙМЭЭС ИТГЭЛ НЬ СОНСОХООС, СОНСОХ НЬ ХРИСТИЙН ҮГЭЭР ИРДЭГ” (Ром 10:17). Ариун Сүнс танд Бичээсийг гийгүүлж өгөхдөө, итгэлийг тань асааж, таныг Үг дээр тулгуурлан үйлдэхийг уриалдаг. Ариун Сүнс Библийн Үгийг галт сум мэт ашиглан, ухаан санааг минь галдах үед миний өөрийн итгэл эхэлсэн юм. Жишээлбэл Илчлэл 22:2 дээр амийн мод нь “үндэстнүүдийн эдгэрлийг” авчирдаг гэдэг. Бурханы Үг миний амийн мод болсон бөгөөд тэр ном миний хувьд анагаагч эм минь болсон юм. Бурхан алдаршиг!

ЭЗЛЭГЧ НАРЫГ БАЙЛДАН ДАГУУЛАХ

Есүс “Би газар дээр гал авчрахаар ирсэн” (Лук 12:49) гэдэг. Түүний дагалдагч нарт итгэлийн гал авалцжээ. Тэгээд “Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн хамт ажиллаж, дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байлаа” (Марк 16:20). Тэд харанхуй, хүйтэн сүсэгтэй дэлхий дээр гал болж, байлдан дагуулагч нарыг байлдан дагуулж Ромын эзэнт гүрний бүргэдийн төмөр сүлдийг хайлуулсан билээ.

ЭЗЭН ХААД НӨГӨӨ ГЭМТ ХЭРЭГТЭН МЭТ ЦОВДОЛСОН ЕСҮСИЙНХЭЭ ӨМНӨ ӨВДӨГ СӨГДЖЭЭ. Бурханы хүчээс өөр юу ч ийм гайхамшиг бүтээхгүй. Үүний нууц нь Бурханы алдрын

төлөө галан баптисм хүлээн авсан, дүрэлзсэн, даруу хүмүүс байв. Тэдэнд гал байжээ. Энэ гал нь өнөөгийн лааны гал шиг л байв уу? Ийм өчүүхэн гал элчийн залгамжлал байж чадах уу? Бид элч нарын залгамжлагч нар мөн л юм бол, тэдэнтэй нөмрөг зүүхээс өөрөөр адил төстэй байх ёстой бус уу? Бидэнд жинхэнэ элчийн нөмрөг хэрэгтэй. Өнөөдөр олон хүн төрөлт, гэрлэлт, оршуулгад оролцох гэж л сүмд очдог. Гэхдээ үхмэл, хуурай юмс маш амархан гал авалцдаг. Петр “Учир нь уг амлалт та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад байх бүгдийнх” (Үйлс 2:39) гэсэн билээ.

ҮНДЭСТНҮҮДИЙН БУРХАН

Та өөрийнхөө юмуу өөрийнхөө хүрээний төлөө л дуудагдаагүй. Та дэлхийн төлөө дуудагдсан. Үндэстнүүд бол ургацын талбай юм. Таны алсын хараа, галыг уур амьсгал бүү унтрааг. Нүдээ нээгээд, өөрийнхөө хүрээнээс, хувийнхаа зөрчлөөс давж хар. Дэлхийн ургац боловсроод, хураахад бэлэн болжээ (Лук 10:2).

ХРИСТ ҮХЛЭЭС БОСОХ ҮЕД ДАГАЛДАГЧ НАР ИҮДЕЙ ҮЗЛЭЭ НИЛЭЭД УДААН ХАДГАЛСАН. Тэд шинэ итгэлээ зөвхөн Израильд л хамаатай гэж боджээ. Тэд тэр бүү хэл Эзэнийг дээш өргөгдөхөөс цаг гаруйн өмнө “Эзэн минь, та энэ үед Израилийн хаанчлалыг сэргээн байгуулах уу?” гэж асуусан байдаг. Тэгтэл Эзэн тэдэнд: “Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш. Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно” (Үйлс 1:6-8) гэжээ. Есүс дагалдагч нараа зөвхөн Иудейд бус, харин дэлхийд хүрээсэй гэж хүсчээ. Тэд Иерусалимаас эхэлсэн, гэхдээ эцсийн зогсоол нь үндэстнүүд байв.

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 4:

ГАЛД ДҮРЭГДСЭН - АРИУН
СҮНСНИЙ БАПТИСМ



СҮҮЛЧИЙН БОРОО

“Би Эцэг дотроо, та нар Миний дотор, Би та нарын
дотор байхыг та нар тэр өдөр мэдэх болно.”

Иохан 14:20

БУРУУ!

Ариун Сүнс доторх баптисм нь чухал бус, тохиолдлын, нийтлэг зүйл биш юм. Энэ нь зүгээр нэг шашны дохио – биднийг ерөөх гэсэн далласан гар биш юм. Энэ буруу. Энэ нь Есүс Христийн онцгой амлалт бөгөөд Есүс л үүнийг бидэнд өгсөн билээ. Энэ нь бидний төлөө Эзэний хийсэн зүйлийн бат бөх нотолгоо бөгөөд гайхамшигтай үйл явдал юм. ЕСҮС бол “Сүнс дотор Баптисм хийдэг Нэгэн” (Матай 3:11). Энэ бол Түүний хамгийн ерөөлт ажлын нэг юм.

АРИУН СҮНСНИЙ БАПТИСМ НЬ ЯМАР НЭГЭН БИЛЭГДЛИЙН ЮМУУ ёслолын зүйл биш - чуулганы хүндэтгэлд юмуу мөргөлд хэрэглэгддэг шашны хэлц үг биш юм. Энэ бол Чуулганыг газрын даалгавраа биелүүлэхэд нь хүчирхэгжүүлэхийн төлөө илгээгдсэн Ариун Сүнсний хүч юм. Ариун Сүнсний хүч үгүй бол, хүн хичнээн их хүчин зүтгэлээ гээд ширхэг ч амь аврагдахгүй. Ариун Сүнс байхгүй бол, Чуулгантай байна уу, Чуулгангүй байна уу ямар ч урт настай өөрчлөлт гарахгүй. Ариун Сүнсний баптисмгүйгээр Чуулган дэлхийг бүрхсэн харанхуйд болоод дайсны арга чаргад гүйцэгдэнэ (Иохан 16:13).

ТӨВӨГТЭЙ УЛАМЖЛАЛЫГ ТАСАР ТАТАХ

Бид “Ариун Сүнс ээ, тавтай морил” гэж дуулж болох ч, Ариун Сүнс бидний урилгаар гүйж ирээд байдаг Нэгэн биш. Ариун Сүнс ганц, хоёр цаг морилдог зочин биш. Тэр бол тэнгэрийн Эзэн бөгөөд биднийг Өөрийнхөө оршихуйд урьдаг Нэгэн. Итгэл, Үг байгаа газарт Ариун Сүнс гэртээ мэт тухалдаг.

ЭЛЧ НАР СҮНСНИЙ ТӨЛӨӨ ЗАЛБИРААГҮЙ Ч Тэр ирээд газрыг эзэлсэн. Тэдний нийтээрээ мэдэрч байсан аливаа уур амьсгал сарниж, тэр газар “исгэрэх хүчит салхинд” (Үйлс 2:2) эзлэгджээ. Сүнс бол тэнгэрийн уур амьсгал бөгөөд Сүнстэй хамт тэнгэр

өөрөө бүүж ирдэг юм. Тэр бол Фнеума - бидний төвөгтэй уламжлал, саадыг үлээж, бүгдэд сэргэлтийг авчирдаг тэнгэрийн салхи.

ТЭНГЭР ГАЗРЫН ГҮҮР

Ариун Сүнс дотор баптисм хийлгэнэ гэдэг нь сүүлчийн борооны уртуу эгэгийн үргэлжлэл дотор оршихтой л ижил (Иоел 2:23, 28, 29) ган гачгийг эцэслэж, үр жимс авчрах - амьдрал хайрлагч ерөөлийн голуудаар тэнгэр газрыг холбох явдал юм.

СҮНС ДОТОРХ БАПТИСМ НЬ ХҮН БҮРИЙН ХУВЬД ТЭНГЭР ГАЗРЫГ ХОЛБОХ ГҮҮР ЮМ. Мика 5:7 дээр Эзэнийг “өвсөн дээрх бороо мэт байх болно” гэдэг. Та магадгүй салхи шуургатай өдөр хөдөө талд шуурга шуурч, аадар асгахыг холоос ажиглаж байсан байх. Тэнгэр хөхрөнтөн, хар үүлээр дүүрч, борооны ус тэнгэр газрын хооронд хана мэт тэлнэ. Энэ бороо нь үүлт тэнгэрийг газартай, Тэнгэрийн улсыг хөрст дэлхийтэй холбодог. Тэдгээр үүлс (Тэнгэрүүд), тэнгэрээс асгаж, газарт үерлэх бороо нь нэг ижил зүйл болой. Тэнгэр, газар нь нэгдмэл нэг юм. Харин бидний Сүнсээр дүүрсэн явдал нь “сүүлийн бороо” билээ.

ЕР БУСЫН ХОЛБООС

Бид Сүнс дотор баптисм хийлгэхдээ, тэнгэрийн бодит байдал руу аваачигдаж байгаа юм. Ариун Сүнс нь Ариун Нэгэн бөгөөд Тэрбээр Бурханыг ер бусаар бөгөөд Тэнгэрлэгээр харуулдаг шигээ бодитоор ч харуулж чадна. Ариун Сүнсний баптисм нь биднийг тэнгэртэй урьд хэзээ ч холбогдож байгаагүй арга замаар холбодог.

АРИУН СҮНС БУРХАНЫ ҮЙЛАЖИЛЛАГААГ БИДЭН РҮҮ БУУЛГАДАГ

НЭГЭН БАЙСААР ИРСЭН ЮМ. Тэрбээр тэнгэр газрыг холбогч юм. Биднийг Ариун Сүнс дотор баптисм хийлгэхэд, Сайн мэдээ газрын хүүхдүүдэд эргэн ирсэн билээ. Бид Бурханы сүүлийн борооны шуурганы үүлэнд ордог. Бид Дээд ерөөнөөс гарахдаа, явсан газар бүрийдээ Ариун Сүнсний баптисмын тэмдэг, гэрчлэлийг тээсээр явна. Бурхан бидэнтэй шинэ арга байдлаар хамт орших бөгөөд энэ тэмдгийг нүүхэд хэцүү байна. Замд маань таарсан бүхэн бидний гэрлийг харна. Гэхдээ бид ганцаараа биш. Учир нь бидний араас ирж яваа хүмүүс бүгд адил тэнгэртэй ер бусаар холбогдсон байна.

ТЭНГЭР ХЭЗЭЭ Ч ХААГДАХГҮЙ

Таны хувьд Тэнгэрийн хаалга хэзээ ч хаагдахгүй. Таны залбиралд ч, залбирлын хариуд ч саад учрахгүй. Та нигүүлслийн сэнтийд нэвтрэх бүрэн эрхтэй. “Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олж, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд зоримгоор очицгоо” (Еврей 4:16). Цаашид саад байхгүй.

ДАВИД, ИСАИА ХОЁРЫН АЛЬ АЛЬ НЬ “ЭЗЭН МИНЬ, ТЭНГЭРИЙГ ЯРААД БУУГААД ИРЭЭЧ” (Дуулал 144:5, Исаиа 64:1) хэмээн залбирсан байдаг. Гэтэл Есүс ирэхдээ, үүнийг хийсэн юм. Шинэ гэрээний итгэгч нар дахиж тэгж залбирах хэрэггүй болсон. Христ тэнгэрийг яраад, бидэн дээр бууж ирсэн. Тэгээд дараа нь тэнгэртээ буцаж ирээд, бидэнд тэнгэрийн хаалгыг бүр мөсөн ярж өгчээ. Тэнгэр мөнхөд ярагдсан бөгөөд утас зүүтэй Сатан ч, өөр нэгэн ч тэнгэрийг дахин оёж хааж чадаагүй юм. Тэгээд тэр ярагдсан тэнгэрээр Ариун Сүнс буюу сүүлийн бороо бууж эхэлсэн билээ. Тэнгэрүүд нь цаашид гуулин шиг байхаа больсон. Там Бурханы хаанчлалд хориг тавьж, зөвшөөрөл өгч чадахгүй. Бурханы иргэнийг эрхшээх хүч тамд байхгүй. Дайсны хяналтаас давсан цоо шинэ, амьд арга зам тогтжээ.

АРИУН СҮНСНИЙ ДИНАМИЗМ

“Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч,
салхийг хаанаас ирж хааш оддогийг мэддэггүй.
Сүнснээс төрсөн хүн бүр ийм л байдаг гэж айлдав.”

Иохан 3:8

ШИЛЭН САВ ДОТОРХ АГААР САЛХИ БИШ

Хүчирхэг хуй салхин зөвхөн Пентекост өдөр Дээд өрөөнд л үлээгээгүй юм. Ариун Сүнс Пентекостоос хойш зогсоо зайгүй ажиллаж, Чуулганд сэргэлт, хүчийг авчирсаар байна. Бурханы Сүнс хэдийнээ тулааны талбарт гарсан бөгөөд түүнээс хойш хэзээ ч тулаанаасаа гарсангүй! Ариун Сүнс үе үе үзэгддэггүй, харин бүр мөсөн үлдэхээр ирсэн билээ.

ҮРГЭЛЖИЛСЭЭР БҮЙ ПЕНТЕКОСТ! Энэ юу вэ? Энэ үйл явдал Есүсийг өргөгдөж, алдрынхаа үүдээр орох үед эхэлсэн юм. Гэтэл яг тэр үед яг тэр үүдээр АРИУН СҮНС Есүстэй зөрөөд БУУЖ иржээ (Үйлс 7:56). Хүчирхэг пургиа - хүчирхэг хуй салхи үлээж эхлэн, шашны өгөршсөн уламжлалын нэвширсэн үнэрийг үлээн туусан билээ. Дээд өрөөнд байгаа дагалдагч нарт агаар цэвэршүүлэгч хэрэггүй байв. Ариун Сүнсний баптисм өрөөг Амиллын урин чанараараа нэвчээжээ.

Ариун Сүнс хэзээд хөдөлж, хэзээд үйлддэг. Шинэ гэрээнд Сүнснийг фнеума гэх бөгөөд энэ нь салхи юмуу амьсгал - хөдөлж байгаа амьсгал гэсэн утгатай үг юм. Фнеума нь зогсонго агаар БИШ. Үлээдэггүй салхи гэж бий юу? Салхи байхын тулд хөдлөх ёстой. Би “зогсонги шуурга” юмуу “намдуу тайван хуй” гэж хэзээ ч сонсоогүй. Шилэн саван доторх агаар нь салхи биш юм. Хэрэв Ариун Сүнс салхи юм бол, цаг үргэлж хөдлөх ёстой. Эс бөгөөс тэр Ариун Сүнс биш болно. Ариун Сүнснийг хөдлөөч гэж гуйх нь галыг халуун байлгах гэж оролдохтой л ижил болно. Бичээс хөдөлгөөнгүй Ариун Сүнсний талаар нэг ч ярьдаггүй. Ариун Сүнс нь Тэнгэрлэг үйлс юм. Тэр бол газар дээрх Тэнгэрлэг Оператор юм.

ТЭНГЭРИЙН ДАВАМГАЙ САЛХИ

Цаг уурч давамгай салхины чиглэлийн талаар мэдээллэдэг. Салхины зүг чиг байнга өөрчлөгддөг. Гэхдээ салхинд “баруунаас зүүн тийш” гэх мэт тогтсон, ерөнхий чиглэл гэж бий. Агаарын

урсгал ч тэр чиглэлийг даган урсана. Үүнтэй адил тэнгэрийн давамгай салхи бий. Ариун Сүнс цаг үргэлж, өдөр шөнөгүй биднийг алдрынхаа урин чанараар үлээж байдаг.

ЗАЛБИРЛЫН МААНЬ ХАРИУД БУРХАН БИДЭНД ТУСЛАХААР ХӨДӨЛДӨГ талаар бид байнга ярьдаг. Тэр ч тийм. Гэхдээ өөр нэг зүйл бий. Тэр угаасаа цаг үргэлж хөдөлж байдаг. Бурхан цаг үргэлж бидний ЗҮГ ерөөл, хүчийнхээ давамгай урсгалыг илгээж байдаг. Бурхан Бүтэн сайны өглөө юмуу эсвэл Тав дахь өдрийн оройн залбирлын цуглаан дээр л үе үе хүчтэйхэн үлээдэг Нэгэн биш. Бурханы эрх хүч тийм байдаггүй. Түүний хүслийг Бичээс хэлдэг. Бурхан нэг өдөр нь сулбайгаад л, маргааш нь тэвхийгээд л байдаг Нэгэн биш. Бурханы хүч тийм байдаггүй. Бурханд барометр юмуу температур хэмжигч хэрэггүй. Бурхан сэргэлтийн цуглаанаар нэг шурхийж ирээд, эдгээчихээд л алга болдог Нэгэн биш. Бурхан цаг үргэлж хамт байдаг Нэгэн. Асуудал нь хэзээ ч хувирашгүй Бурханд бус, харин бидэнд бий. Бурхан бидэн шиг хаврын тэнгэр шиг зангүй. Бурханд тодорхойгүй хүчин зүйл гэж байхгүй. Тодорхойгүй хүчин зүйлийг түлхэн зайлуулах ёстой зүйл нь бидний итгэл болой.

ГЭНЭТИЙН ТҮРЛЭГ БИШ

Шинэ гэрээ Бурханы ажлыг ангилдаггүй. Бичээс хүчний гэнэтийн түрлэг юмуу сэргэлтийн үе үеийн базлалт гэх мэт Бурханы онцгой “хөдөлгөөний” талаар нэг ч яриагүй. Христэд итгэх итгэл нь эхнээсээ дуустал Ариун Сүнсний хөдөлгөөн байв. Бурханы Сүнс хэзээд хөдөлсөөр, ажлаа сэргээсээр байдаг.

БИЧЭЭС БЕТСЕДА ЦӨӨРМИЙН ТАЛААР ӨГҮҮЛДЭГ. Бетседа хэмээх цөөрмийн усыг үе үе тэнгэрийн элч эргүүлдэг байжээ (Иохан 5:1-9). Тэр үед нь цөөрөмд түрүүлж орсон хүн эдгэрдэг байж. Цөөрөм хэдийгээр шийдэл гаргаж өгсөн ч, энэ нь тасралтгүй хангамж бус, харин маш хязгаарлагдмал хүрэлцээ байв. Тэр цөөрмийн дэргэд 38 жил хэвтсэн нэгэн эр Есүстэй уулзах хүртлээ

эдгэрч чадаагүй ажээ. Тэрбээр ус эргэх үед орж амждаггүй байв. Тэгвэл Есүсийн хайр, өршөөл, хүч нь Бетседагийн цөөрөм шиг биш, харин хэзээ ч унтралгүй, үргэлжилдэг. Тэдгээр нь бидний хүчин зүтгэлээс ангид юм. Есүс ердөө л биднээс үүнийг нь хүлээн авахыг хүсч буй эсэхийг л асуудаг.

БУРХАНЫ ТӨЛӨӨ ХӨДЛӨХ

Хөдөлдөг Ариун Сүнсэнд хөдөлдөг хүмүүс хэрэгтэй. Пентекост гэдэг үгийн утга нь өөрөө жолоодогч эрчим хүчийг илэрхийлдэг. Сүнс зогсоо зайгүй хөдөлдөг. Матай 28:10 дээр Ариун Сүнсний салхины хэтийн зорилгын талаар маш тодорхой хэлжээ: “ЯВААД, АХАН ДҮҮСТ МААНЬ ХЭЛ!”

ҮРГЭЛЖИЛСЭЭР БҮЙ ПЕНТЕКОСТ НЬ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ПЕНТЕКОСТ БАЙХ УЧИРТАЙ бөгөөд ЯВААД, ЯРИХ нь чухам бидний ажил юм. Биднийг цугламагц, Ариун Сүнс биднийг ерөөхөөр, эдгээхээр, аврахаар ирээд байна. Ариун Сүнсээр дэлгэрсэн Сайн мэдээ нь манай гудмуудын бохир заваан уур амьсгал дундуур үлээх, урьхан үнэртэй хуй салхи юм. Бид гагцхүү Ариун Сүнсстэй түншилж, Түүний салхийг үлээлгэх л хэрэгтэй!

ХАЛИЛ

“Өөрийн минь толгойг Тосоор бас тосолжээ.
Аяга минь дүүрч бялхнам.”

Дуулал 23:5

АГУУЛАХ БУС, ЧИГЛҮҮЛЭХ

Христийн дотор бид эрчим хүчээ сэргээж чадна. Түүнд эрчим хүчний доголдол гэж байхгүй. Бурханы хүчийг ашиглаж дуусна гэж байхгүй. Усан үзмийн мод мөчрүүдээ тэтгэдэг шиг, Ариун Сүнс эгшин бүрт биднийг цэнэглэсээр байна.

ҮЙЛС 2 ДЭЭР ПЕНТЕКОСТ ӨДӨР ДАГАЛДАГЧ НАР Ариун Сүнсээр дүүрээд, цаашдаа хэрхсэнийг нь номоосоо үргэлжлүүлэн уншиж болно. Тэд “алхам тутам” дүүрсээр байжээ. Нөгөө магтаалын дууны үг шиг л: “Есүсийг харахад... Алхам тутам намайг дээрээс хамгаалж, алхам тутам дээрээс амьдруулдаг.” Есүс бол усан үзмийн мод, харин бид мөчир нь гэсэн үг. Тэр биднийг өдөр тутам шинээр сэргээдэг. Есүс энэ үргэлжлэлийг голоор дүрслэн өгүүлдэг (Иохан 7:37, 38). Бид сүнслэг хүчээр дутаж, сүнслэг хүчийг хэрэглэхдээ, шинэчлэгдсээр байна.

ЗОГСОШГҮЙ УРСГАЛ

“Бурхан бидэнд Сүнсээ хэмжээтэй бус, харин хэмжээлишгүйгээр өгдөг” (Иохан 3:34). “Үүнээс хэтрүүлэлгүй өгье” гэсэн хэмжээ хязгаартай бус, харин “шахагдсан, чигжсэн мөн бялхсан сайн хэмжээгээр” (Лук 6:38) хэмээн хэмжээлишгүйгээр өгдөг. Бурхан ямар ч зүйлийг тооцоолж өгдөггүй. Жишээлбэл Тэр амь өгдөг - гэхдээ хэмжээлишгүйгээр - учир нь ЭНЭ НЬ ТҮҮНИЙ АМЬ БӨГӨӨД МӨНХИЙН АМЬ (Иохан 3:36) болой.

ЕЛИАГИЙН ДАВХАР ХУВЬ НЬ ЕЛИАД БАЙСАН ЗҮЙЛСИЙН ХЭСЭГХЭН НЬ БИШ ЮМ. Бурхан хэзээ ч нэгэнд нь талыг, нөгөөд нь бусдаас нь хоёр дахин ихийг өгдөггүй. Ариун Сүнс Өөрөөсөө, Өөрийнхөө бүрэн дүүрэн байдлаас өгдөг болохоос биш, ганц хоёр

литрээр тооцоолж өгдөггүй. Библи цутгалан, голууд амласнаас биш, дусал амлаагүй. Хүчирхэг голууд нь шоржигнож, дусаж, бөнжигнөж, саатаж урсдаггүйтэй адил Ариун Сүнс ч шал пал хийдэггүй. Христ “голууд” гэдэг илэрхийлмээр зогсоошгүй урсгалыг л тодорхойлсон билээ (Иохан 7:37, 38).

ХӨДЛӨШГҮЙ БАРИМТ

“Итгэдэг хүмүүс дараах тэмдэгтэй байна: ‘Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярих болно. Тэд могойг барина. Бас үхүүлэх ямар ч юм тэд уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтөнд тэд гар тавивал эдгэнэ.’ ”

Марк 16:17, 18

ГАЛАН БАГАНА

Пентекост өдөр Ариун Сүнс тэнд байгаа 120 дагалдагч нэг бүр дээр галан хэлүүд шиг харэгдсэн. Энэ нь тэнгэрлэг оршихуй, хүчний тэмдэг байв. Тэнгэрлэг гал нь Тэнгэрлэг захирамж, хамгаалалтын төлөө өгөгдсөн буюу.

ГАЛ НЬ БУРХАНЫ ТЭМДЭГ - ТҮҮНИЙ ЛОГО ЮМ. БИЧЭЭС ДЭЭР БУРХАНЫ галын талаар 100 гаруй удаа хэлсэн бий. “Бидний Бурхан залгих гал” (Еврей 12:29). Хамгийн том хоёр сүнслэг үйл явдал нь Тэнгэрлэг галаар нээгдсэн байдаг. Гэтлэлийн босгон дээр Израиль үндэстний эхлэл галаар тавигдсан. Мөн Чуулганы эхлэл галан хэлээр эхэлсэн. Гэтлэл дээр Израиль, Египетийн хооронд галан хөшиг тэлсэн нь Израильтай Түмэн цэргийн Эзэн хамт байгааг батлах далбаа болжээ. Тэгвэл Бурхан өнөөдөр бидэнтэй хамт байгаагаа яг л адил баталдаг. Пентекостын хэл нь Бурхан бидэнтэй хамт байгаагийн дохио байв. Есүс: “Би газар дээр гал хаяхаар ирсэн билээ. Энэ гал хэдийнээ ассан байхыг Би ямар их хүснэ вэ!” (Лук 12:49) гэсэн. Бурхан хоригдлуудад аврал авчрахын төлөө таныг галт сумаа болгон, дайсны хуаран руу харвадаг.

ТЭМДЭГ - ЖИШГИЙН БЭЛЭГ

Ариун Сүнс нь Чуулганы амьдрал дахь мөнхийн бөгөөд бүрэн хувьсгал мөн. Бүх хүн дээр буудаг Сүнс нь урьд хожид байж болох, хамгийн аугаа өөрчлөлт байв. Жишиг нь тэмдэг - бэлэг байв. Энэ нь илчлэл байв. Үүгээр тэд хүч ирснийг, Ариун Сүнс тэдэнтэй хамт байгааг мэдсэн бөгөөд Сүнсийг дахиж хэзээ ч гуйгаагүй юм. Элч нар Ариун Сүнсний тэр л тэмдгийг хүлээн зөвшөөрсөн: “Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:4). Ариун Сүнснээс өөр хүч байхгүй. Энэ тэмдэг - гайхамшиг нь ямар ч гайхамшиг боломжтойг баталсан юм.

ЦАГ ХУГАЦААНЫ ТҮРШИД ЭРЧҮҮД Ч ЭМЭГТЭЙЧҮҮД Ч итгэлээ бадраах тэмдгийг хэзээд шаардсаар ирсэн билээ. Ноагийн үерийн дараа Бурхан дахин хэзээ ч даян дэлхийг хамсан их үер буулгахгүй гэдгийнхээ тэмдэг болгон солонго өгчээ (Эхлэл 9:12-17). Бурхан үр хүүхэдгүй Абрахамыг олон үндэстний эцэг болгохоо батлан, тэмдэг өгсөн (Эхлэл 15). Хэлээр залбирах нь тэмдэг мөн - гэхдээ хоосон тэмдэг биш. Энэ нь итгэгч хүний дотор Ариун Сүнс оршин буйн ер бусын, хүчирхэг баталгаа болдог. Энэ нь бидний итгэлийг дахин баталгаажуулахын сацуу бас харилцааг илтгэдэг: Энэ нь бидэнд залбирч, дуулж, эш үзүүлж, үйлчлэхэд маань тусалдаг. Үүнээс гадна хэл нь хүн төрөлхтний хэрэг явдлыг шийдвэрлэх Бурханы шинэ арга замыг тэмдэглэх жишиг юм: “Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ Бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж, Залуус чинь үзэгдэл үзэн, Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно” (Үйлс 2:17).

БАТАЛГАА

Хэлээр ярих нь таны амьдрал дахь Ариун Сүнсний оршихуй, хүчийн тэмдэг болно. Энэ нь Сүнсний эрч хүчийг тодорхой болгож, сүнслэг үзэгдлийг хувийн, жирийн үйл явдал болгох үйл явц юм. Пентекост нь Бурхан, хүн хоёр нэгдэн нийлээд, нэгэн карисматик хэлээр ярин, баясах үйл явдал юм.

“ХЭЛ” НЬ АРИУН СҮНС БИДНИЙ ДОТОР БӨГӨӨД БИДЭНТЭЙ ХАМТ БАЙГААГИЙН баталгаа мөн. Үгүй аваас, бид хэзээ ч баталгаатай байж чадахгүй. (Би хангалттай залбирсан уу? Би хангалттай ариун уу? Би хангалттай гэрчилсэн үү?) Гэхдээ Бурхан биднийг Сүнснийхээ төлөө хэлбэржүүлсэн юм. Сүнс доторх баптисм нь сүнслэг бөгөөд биеийн тэмдэгтэй, сүнслэг бөгөөд биеийн үйл явдал билээ (1Коринт 6:19).

БОЛОМЖИЙН ТЭМДЭГ!

Сэтгэл аврагдахаас гадна хэлээр залбирах нь хамгийн гайхамшигт үзэгдэл мөн. Мөнх бус хүний дахин төрж, амилуулагдаж, зөвт болгогдсон сүнс Аавтайгаа тэнгэрийн хэлээр ярих шиг гайхамшиг гэж юу байхав? Хэлээр ярих нь боломжгүй зүйл гэж байхгүйг л илтгэж буй явдал юм.

ПЕНТЕКОСТ ӨДӨР 120 ХҮН ХЭЛЭЭР ЯРИХАД, тэднийг сонссон цугласан олон сандарчээ. Би амьдралдаа ганц цуглаан дээр 1 сая хүн тэр л галан баптисмыг хүлээн аваад, Эзэнд хандан Сүнсний шинэ хэлээр залбирахыг харсан. Яг л усны хүчирхэг нүүргээн шиг санагдаж билээ. Бурхан “Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ Бүх махбод дээр цутгана” (Үйлс 2:17) гэж айлдсан. Тэгвэл тэр өдөр нь одоо юм.

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 5:

ГАЛЫН ЗЭМСЭГ - АРИУН
СҮНСНИЙ БЭЛЭГ БӨГӨӨД
ХҮЧ

ҮНЭТ БӨГӨӨД ҮНЭЛЭШГҮЙ

“Есүсийг Бетанд, уяман өвчтэй Симоны гэрт байхад, их үнэтэй тос бүхий гөлтгөнөн сав барьсан эмэгтэй Түүн дээр ирээд, Түүнийг хооллохоор тухлахад толгойд нь тосоо цутгав. Шавь нар нь хараад зэвүүцэж —Юунд ийм үрэлгэн байна вэ? Энэ тосыг өндөр үнээр зарж, ядууст өгч болох байлаа шүү дээ гэцгээв. Харин Есүс үүнийг мэдээд, тэдэнд —Та нар юунд энэ эмэгтэйд төвөг удна вэ? Тэр Надад сайныг үйлдэв.”

Матай 26:6-10

ХООСОН ХЯСАА ТӨДИЙ ЮУ?

АРИУН СҮНС ину гоёл чимэглэл бус, харин бидний итгэдэг зүйлийн цөм юм. Ариун Сүнс ину бидэнд тулгарах бүхний хэсэг бүрт оршиж, зохицуулдаг газар дээрх Бурхан. Энэ нь Христитгэл бол ер бусын итгэл гэсэн үг. Ер бусын биш Сайн мэдээ нь зүгээр л хоосон хясаа юм.

ОЛОН ХҮН АРИУН СҮНСИЙГ ТООСОН Ч ТООГООГҮЙ Ч ХРИСТЭД ИТГЭДЭГ ХҮНТЭЙ БАЙЖ Л БАЙДАГ, ХЭРЭГЛЭЖ Ч БОЛДОГ, ХЭРЭГЛЭЭГҮЙ Ч БОЛДОГ СОНГОЛТ МЭТЭЭР ҮЗДЭГ. Гэхдээ тийм биш! Ариун Сүнс бол Христэч амьдралын нэмэгдэл биш юм. Ариун Сүнс бол амьдралын Зохиолч нь бөгөөд Христийн өмнөх бөгөөд дараах бүх цаг хугацааны дундуур амьдралыг жолоодон авч явж буй Нэгэн юм. Ариун Сүнс бол найрын Эзэн бөгөөд Түүнгүйгээр найр байхгүй. Түүнийг үл тоож байгаа нь бидэнд л халгаатай. Ариун Сүнс Эхлэлээс ч өмнө байсан, Төгсгөлийн дараа ч оршино. Тэр Альфа бөгөөд Омега. Бид уралдсан шиг уралдаж, замаа дуусгасан шиг дуусгамаар байгаа бол, Ариун Сүнсэнд анхаарлаа хандуулах л ёстой.

ХАЙРЫН ХАРАМГҮЙ ӨГӨӨЖ

Сүнсний тосолгоо нь таны дотор тодорхой хэмжээний Тэнгэрийн сайн сайхан оршиж байна гэдэг ойлголтоор таныг тайтгаруулж, тайвшруулахын төлөө илгээгдсэн, хоёрдугаар зэргийн үйл явдал биш юм. Энэ бол жинхэнэ гэрээ мөн: Бурханы шилдэг гэрээ. Энэ бол Тэр Өөрөө юм. Бид үүнийг хамгийн үнэт сав болох Биеэ хагалж, хүн төрөлхтөн дээр үнэт үнэрийг нь асган, цовдлуулсан Христээр дамжуулан хүлээн авсан билээ.

МАРИАГИЙН ТОСНЫ ҮНЭР ГЭР ДҮҮРЭН АНХИЛСАН. Энэ нь үлэмж том золиос бөгөөд хайрын харамгүй өгөөж байв. Энэ явдал Есүс Христээр дамжиж ирсэн Бурханы хайрыг илтгэх бөгөөд бидэнд үнэлэшгүй үнэт бэлэг болох Ариун Сүнсний тосолгоог авчирдаг. Энэ нь хямд үйл явдал бус, Бурханы шилдэг үйлс юм. Христ Голгот дээрх загалмай руу явахдаа, хамгийн нандин золиос болох биеэ өргөсөн. Тэрбээр үүгээрээ хүн төрөлхтөн дээр Ариун Сүнсний үнэлэшгүй үнэт үнэрийг бөгөөд Бурханы Тэнгэрлэг сайн сайхныг цутгасан юм.

АНХИЛУУН ҮНЭРЭЭ ЯЛГАРУУЛАХ

Цэцэг салхи, нарны гэрлийг сордог ч, дараа нь гоо үзэсгэлэн, анхилуун үнэрээрээ эргээд нарныхаа гэрлийг ялгаруулдаг. Бид энэ үйл явцсыг фотосинтез гэдэг. Тэгвэл Христэд итгэдэг амь бүрийн дотор яг фотосинтез шиг үйл явц өрнөх ёстой. “Сүнсээр дүүр” (Ефес 5:18) тэгээд та Сүнсний анхилуун үнэрийг ялгаруулахад, энэ үнэр таны сүсэгт амьдралаас төдийгүй, хайр татам зан чанараас тань ч анхилна.

АРИУН СҮНСНИЙ ҮНДСЭН АЖИЛ НЬ БИД! Тэрбээр биднийг Өөрийнхөө төлөөлөгч нар болгодог. Нэг охин: “Эзэн минь ээ, бүх муу хүмүүсийг сайн, сайн хүмүүсийг сайхан болгооч” гэж залбирсан гэдэг. Охин “сайн” гэдэг нь заавал “сайхны” нэр биш болохыг ажигласан болтой. Бурхан минь бидэнд сайн ч, сайхан ч болоход туслаарай! Тэр цагт дэлхий Таныг мэднэ.

ХУДАЛДАН АВААГҮЙ, БЭЛЭГ БОЛГОЖ АВСАН

“Элч нарын гар тавилтаар Ариун Сүнс өгөгдөж буйг ажигласан Симон тэр хоёрт мөнгө өгч — Энэ эрх мэдэлээ бас надад өгөөч. Тэгвэл би гараа тавьсан хүн бүрийг Ариун Сүнстэй болгоно шүү дээ гэв. Гэвч Петр түүнд —Бурханы бэлгийг чи мөнгөөр авч болно гэж санасан тул мөнгө чинь чамтай хамт мөхөг.”

Үйлс 8:18-20

АРИУН СҮНСИЙГ ХУВЬЧЛАН ТАНИН МЭДЭХҮЙ

Ариун Сүнс бол “юм” биш, Хувь нэгэн гэдгийг ойлгох ёстой. Сүнс нь цахилгаан эрчим хүч шиг нийтийн дундах хүч биш юм. Бурхан биднийг зүгээр нэг хүчээр юмуу бэлэгээр бус, чухам Өөрийнхөө Ариун Сүнсээр тосолсон билээ.

БИЧЭЭС ДЭЭР АРИУН СҮНСИЙГ ОЛОН ЯНЗЫН ЭЛЕМЕНТЭЭР ДҮРСЭЛДЭГ: гал, салхи, ус. Гэхдээ Ариун Сүнс нь амьгүй элемент бус, харин Хувь нэгэн гэдгийг ойлгох ёстой. Ариун Сүнс газрын татах хүч, цахилгаан гүйдэл шиг хүч биш. Ариун Сүнс бол Бурханы Ариун Гурвалын гурав дахь Хувь нэгэн билээ. Ариун Сүнсийг бэлэг, үр жимс төдийхнөөр төсөөлж ойлгож болохгүй. Ариун Сүнс Бурханы өгсөн бэлэг төдийгүй, Бурхан Өөрөө мөн.

БЭЛЭГИЙГ ХУДАЛДАЖ АВАХ УУ?

Бэлэгийг худалдаж авах уу? Тэгвэл тэр нь бэлэг бус, харин наймаа болно (Үйлс 8:18-20). Тийм боловч, үүнийг хэрэглэхэд төлөх ёстой үнэ төлөөс гэж бий. Амралт, тав тух, нэр төрөө золиослох бэлтгэлгүй хүмүүст Бурхан бэлэгээ өгсөн ч, тэд өчүүхэн ашиг гаргана.

МУЖААН ХҮНД ХАЙРЦАГ ДҮҮРЭН БАГАЖ НЬ үнэтэй бэлэг болох ч, тэрбээр хөлсөө дуслуулан хэрэглэхгүй бол, ямар ашигтай? Бэлэг биднийг бүрэн дайчилгаанд уриалан дууддаг. Ром 12:7 дээр хэлсэнчлэн “Үүнийг үйлчлэлдээ хэрэглэе.” Түүний амь бидний амьтай хамт асгарсан. Бэлэг нь өгдөг хүмүүст зориулагдсан билээ. Тиймээс авахын тулд өг! Есүс 12 дагалдагчаа илгээхдээ, тэдэнд янз бүрийн гайхамшиг үйлдэх эрх мэдэл өгөөд: “Та нар явахдаа “Тэнгэрийн хаанчлал айсуу” гэж тунхаглагтун. Өвчтөнийг

эдгээ, үхэгсдийг босго, уяман өвчтөнг цэвэрлэ, чөтгөрийг зайлуул. Үнэгүй авснаа үнэгүй өг” (Матай 10:7, 8) хэмээн даалгасан. Бэлэг нь тэдэнд үнэгүй өгөгдсөн учраас, тэд ч үнэгүй өгөх ёстойг Есүс тодорхой айлджээ. Гэхдээ дагалдагч нар явсаар, хүнд бэрх замыг туулсаар, тав тухаа золиосолсоор байхын төлөө тэгээд магадгүй бүр хавчигдахын төлөө эрч хүчээ сунгах ёстой байв. Бэлэг үнэгүй ирнэ. Гэхдээ бэлэгийг хэрэглэх амьдрал танаас төлөөс шаардана шүү.

АСУУГААД ХҮЛЭЭЖ АВ

Ариун Сүнсний тосолгоо нь арилжаанд зориулагдаагүй.

Арилжаанд зориулагдсан байсан бол, үүнийг хэн ч авч чадахгүй байв. Та зүгээр л хурч очоод, чөлөөтэй залгилахад л болно.

“Хөөрхий, цангагч бүр ээ, ус уруу ирэгтүн. Мөнгөгүй нэгэн ээ, ирж, худалдан авч, идэгтүн. Ирж, мөнгөгүй, үнэгүйгээр дарс, сүү худалдан авагтүн” (Исаиа 55:1).

АРИУН СҮНСНИЙ ХҮЧИЙГ ЭРИЙНХЭЭ САЙНД ОЛЖ АВЧ доош буулгаж, бүтээж, хүнд хүчир хөдөлмөр, шаргуу залбирлаар ажиллуулахгүй. Ариун Сүнс таны хөлсийг асгартал хүлээхгүй. Есүс: “Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. ... Гуйдаг бүр авна, эрж хайдаг нь олно, тогшдогт нээгдэнэ” (Матай 7:7, 8) гэсэн. Бурханд бэлэг л байдгаас, арилжааны таваар байхгүй. Түүнд панз хаялцах, үнэ татах, тохиролцох, дамлах, зөвшилцөх юм байхгүй. Тэрбээр нэг л зүйл хийдэг - зүгээр л өгдөг. Харин бид нэг л зүйлийг хийж чадна - хүлээн авах. Ариун Сүнс хариуд нь биднээс юу ч хүсэхгүй. Та шатаагүй нүүрс бол, Ариун Сүнсний галыг аваад, шатсан нүүрс бол. Тэр таныг шатаагаад өгнө.

ТАНД ЗОРИУЛСАН БУРХАНЫ ЧИХЭР

Бурханд бүх хүүхэддээ буюу үнэндээ бол бүх бүтээлд хангалттайгаас ч хангалттай өгөх зүйл бий. Та өөр хүнд атаархах шаардлагагүй. Түүнчлэн түрүүнд гарах гэж бусдыг хорлож, гүйтгэж, сүйтгэх хэрэггүй. Бурхан биднээс Хүүгээ харамлаагүй (Ром 8:32) бас Сүнсээ зүгээр өгсөн бол (1Коринт 2:12), өөр юугаа харамлах билээ?

ДАЙНЫ ДАРААХ ГЕРМАНД АХ ДҮҮ БИД ХЭД ЖИЛДЭЭ ГАНЦ удаа л жаахан чихэр олж иддэг байлаа. Петр ах маань чихэр хүлхэж байвал, надад хулгайлах санаа бус, харин сэргэлэнтэх арга төрнө. “Ах хэнээс чихэр авчихав?” Ганц л хүн бий - ээж! Ээж маань дэндүү шударга хүн байлаа. Тэгээд нэгэнд нь чихэр өгчихөөд, бусдад нь өгөхгүй байна гэж байхгүйг би сайн мэдэх учраас, ээж дээрээ гүйж очоод: “Ээж ээ, надад чихэр?” хэмээн цангинатал хэлнэ. Ээж маань ч чихэр гаргаж ирээд, гарт минь бариулна. Яг үүнтэй адил Бурхан өөр нэг итгэл нэгт нөхрийг чинь, Чуулганыг, үйлчлэлийг ерөөж байхыг харвал, битгий атаарх! Есүс дээр оч! Түүнд танд зориулж хадгалсан чихэр байж л байгаа! Лук 15:31 дээр Аав нь Хүүдээ: “Надад байгаа бүхэн чинийх” гэж хэлсэн. Энэ ч бас бидэнд зориулсан амлалт шүү!

ИЛҮҮ ТОМ БЭЛЭГ

“Гэвч Эзэнд хандаж эргэх бүрд нь бүтээлэг авагддаг. Эзэн бол Сүнс. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг. Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээрээ Эзэний алдрын тусгалыг тольдох мэт хараад, Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг.”

2 Коринт 3:16-18

ТЭР ӨӨРӨӨ ХАМГИЙН ТОМ БЭЛЭГ

Ариун Сүнснийг бэлэг юмуу ажилтай андуурч эндүүрч болохгүй. Ариун Сүнс бидэнд юмуу тэр бүү хэл дэлхийд үзүүлдэг нөлөөллөөсөө хавьгүй аугаа буюу. Бидний амьдралд байх Ариун Сүнсний оршихуй нь Түүний бэлэгээс хавьгүй том билээ. Ариун Сүнс биднийг зүгээр нэг хэл устай болгох гэж ирдэггүй, харин хэл ус нь Түүний оршин буйн тэмдэг болдог. Ариун Сүнсний бүх бэлэг нь Түүний бидэнтэй бөгөөд дэлхийтэй тогтоох харилцааг дэмжихийн төлөө оршдог билээ.

СҮЙТ БҮСГҮЙ СҮЙТ ХАРХҮҮТЭЙГЭЭ БӨГЖИНД НЬ БОЛЖ БИШ, ХАРИН ӨӨРТ НЬ БОЛЖ ГЭРЛЭДЭГ. Бурхан гайхуулдаггүй. Биднийг хайрлах нь Түүний цорын ганц зорилго - биднийг хайрлаж, бидний хайрыг олж, бидэнтэй эрч хүчтэй харилцаатай байх. Тэр бидэн дээр, биднээр дамжуулж, бидэнтэй хамт ажилладаг. Тэр бидний гарын хүч, сэтгэлийн минь бөхөшгүй гал. Тэр бидэнд сүнслэг бэлэг, сүнслэг үр жимс, нэгдлийг авчирдаг (1Коринт 12). Тэр бидний нүглийн толбыг арилгахын тулд эхлээд Христийн цусыг түрхээд, дараа нь биднийг шинэ төрөлт зэрэг олон, олон зүйл рүү авчирдаг. Гэхдээ Сүнсний оршихуй нь Түүний ажил үйлсээс ангид явдал бөгөөд Ариун Сүнс Өөрөө бидний хамгийн том бэлэг юм. Гайхамшиг, тэмдэг бус, харин Бурханы төлөөх хүсэл нь жинхэнэ Христэд итгэгчийг төрүүлдэг.

БИД ӨӨРИЙГӨӨ ХАНГАХГҮЙ

Бид Бурханы нигүүлсэл, хүчинд найдахаар бүтээгдсэн. Түүнээс тусгаар бид юу ч хийж чадахгүй (Иохан 15:5). Бидний хангамж Түүнээс л ирдэг (2Коринт 3:5). Бидэнд Ариун Сүнсний тайтгарал, хөтөлгөө, засвар хэрэгтэй учраас л Бурхан Сүнсээ бидэнд өгсөн юм. Биднийг Бурханы өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхэд маань - үүнийг биелүүлэхийн төлөө сүнсээр

боловсроход маань шаардлагатай байсан учраас л Бурханы бэлэг, хүч бидэнд өгөгдсөн болой.

БИД ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНИЙ СҮНСЛЭГ ХӨРӨНГӨ, ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРИЙНХЭЭ АЧААР бие даасан учраас, өөрөө бие даасан бизнес хийх гэж байгаа хүмүүс биш юм. Бид өөрөө өөрийгөө хангачихдаг жижиг “христүүд” биш. Усан үзмийн модны мөчрүүд эх биеэсээ шим тэжээлээ авдаг шиг, бид алхам тутмаа Христийн бүрэн дүүрэн байдлаар л бүрэн бүтэн болдог. Бид өөрсдөө бие даан оршдог, усан үзмийн мод биш бөгөөд Бурханы дотор л бүрэн бүтэн болдог (Колоссай 2:10).

Бид өөрийн гэсэн өчүүхэн цахилгаан станцтай болж аваад, хүмүүст сүр хүчээ гайхуулахаар даян дэлхий рүү дайрахаар дуудагдаагүй. Бид өөрийнхөө карисмагаар жагсаж, хэдэн цагийн турш ёслолын бүүдлага бүүдаж болох ч, төдөлгүй бидний цахилгаан станц шатахуунгүй болно. Бид генератор биш, харин Бурханы хүчийн зохицуулагч нар юм. Ефес 1:22, 23 дээр “Бурхан бүх юмсыг Түүний хөл дор захируулж, Түүнийг чуулганд бүх юмсын дээрх Тэргүүн болгож өгөв. Чуулган нь Түүний бие тухайлбал бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэл болой” (Ефес 1:22, 23) хэмээн тайлбарладаг. Тэр биднийг дүүргэж, биднээр дамжуулан хөдөлдөг. Бид суваг нь болохоос биш, эх үүсвэр нь биш. Есүс: “Усан үзмийн модонд холбогдохгүй бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно” (Иохан 15:4) гэсэн.

ШИНЭ ХУУЛЬ АЖИЛЛАЖ БАЙНА

Сүнс дотор хөв. Та Ариун Сүнсний усан дээр хөвөхөөр урлагдсан. Бүү эсэргүүц, бүү тэмцэлд, зүгээр л биеэ сул тавиад, хөв. Зүгээр л хөв. Ариун Сүнсний сүр жавхланта, аугаа урсгал таныг хувь тавилан руу тань авч одох болтугай.

НЭГЭН ӨДӨР БУРХАН НАДААС: “СЭЛНЭ ГЭЖ ЮУ ГЭСЭН ҮГ БОЛОХЫГ МЭДЭХ ҮҮ?” гэж асуулаа. Би сайн сэлдэг учраас,

мэднэ л гэж бодов. Гэхдээ би үнэхээр мэддэг байв уу? Ариун Сүнс надад миний өмнө тоодоггүй байсан нэгэн зүйлийг ухааруулав. Тэрбээр надад: “Чи сэлэхдээ, өөр элемент дотор байгаа учраас, тэнд шинэ хууль үйлчилнэ. Чи зүгээр л биеэ суллаад, голын усан дээр бүрэн амарч хөвөх хэрэгтэй. Тэр ус өөрөө чамайг аваад явна” гэж хэлсэн юм. Би Түүний үгийг ойлгов. Ариун Сүнс дотор сэлэхэд, Түүний ус намайг тээдэг байх нь. Сүнс намайг өргөж, хөл минь хөнгөрөн өргөгдөж, нуруунд минь таашаал, үе мөчинд минь амралт авчирдаг байх нь. Тэрбээр бүх ажлыг хийнэ. Тэгвэл үүнд гав болдог зүйл нь юу вэ? Гав болдог зүйл нь өөртөө найдаж түшиглэх юм. Өөрийнхөө эрч хүч, чадварт найд - тэгвэл та хажууд тань таныг ядах юмгүй тээгээд, аваад үрсах гол байсаар байтал, өөрөө голын сав газраар махаа идэн зүтгэх болно.

БЭЛЭГЭЭ БАДРАА

“Чамд буй жинхэнэ итгэлийг дурсан бодоход, энэ нь анх чиний эмэг эх Лой, эх Юник нарт байсан бөгөөд чамд ч бий гэдэгт итгэж байна. Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг сэргээхийг чамд сануулья.”

2Тимот 1:5, 6

СҮНСЭЭР ИДЭВХИЖСЭН

Сүнсний бэлэг нь төрөлх чадвар биш юм. Хүний төрөлх чадварыг “сүнслэг бэлэг” гэж хэлж болохгүй. Сүнслэг бэлэг нь Тэнгэрээс ажиллагаатай юм. Бурхан хэнээр ч дамжуулан ажиллаж чадна. Бурхан хэлний мэргэжилтнүүдэд л хэлийг өгдөг юм биш. Бурхан мэргэжлийн зөвлөхүүдэд л цэц ухааныг, эмч нарт л эдгээх бэлэгийг өгдөг юм биш. Бид Бурханы бэлэгийг ашиглахын тулд онцсайн байх шаардлагагүй.

БУРХАНЫ ДҮР ТӨРХӨӨР БҮТЭЭГДСЭН ХҮН АЖИЛ ХИЙХ, ТӨВЛӨРӨХ, БУРХАНЫ АВРАН СЭРГЭЭХ ЗОРИЛГОД оролцох төрөлхийн авьяас чадвартай. Гэхдээ үүнээс гадна Бурхан хүнийг дахин төрүүлэхийн тулд Ариун Сүнсээрээ дамжуулан нэмэлт бэлэг өгдөг (1Коринт 12:1-11). Эдгээр нь төрөлх авьяас бус, харин Бурханы авран сэргээх ажилд оролцох чадварыг маань дэмжиж өгдөг сүнслэг бэлэгүүд юм. Сүнсний бэлэгээр дамжуулан бид төрөлх шалтаг, хомсдол, чадваргүй байдлаа давна. Биднийг мөхөс үед Түүний хүч төгс болдог (2Коринт 12:9) бөгөөд бидэнд хүчийг өгөгч Түүгээр бид бүгдийг хийж чадна (Филиппой 4:13).

ГАЙХАМШГИЙН ТӨЛӨӨ ГАЙХАМШИГ ОРШДОГҮЙ

Сүнсний бэлэг нь онолд итгэх итгэлээр бус, харин Бурханд итгэх итгэлээр ажилладаг. Тэдгээр нь авралын доктриноос өөр ямар ч доктриноор дамжихгүй. Ариун Сүнс л цовдлогдсон Христийг алдаршуулдаг.

БУРХАН ГАЙХАМШГИЙН ТӨЛӨӨ ГАЙХАМШИГ ҮЙЛДДЭГҮЙ. Бурхан гайхуулагч биш. Тэрбээр амиа хичээсэн сагсуу амьтныг алдаршуулахын төлөө дуулиан дэгдээх ажил хийдэггүй. Ариун Сүнс

цовдлогдсон Христтэй нэг шигшээд байдаг. Тэрбээр “Христийн Сүнс” хэмээн Христтэй нэрээрээ хүртэл холбогджээ. Тэд нэг л ижил санаатай - Сайн мэдээгээр дамжуулан Дяаволыг ялах. Сүнс Сайн мэдээн дотор л бүрэн дүүрдэг. Сайн мэдээ нь дэндүү том юм. Сайн мэдээ нь дэндүү яндашгүй бөгөөд бүгдэд хүрдэг - ил, дала, газар дээрх, тэнгэр дэхь, там дахь бүгдэд хүрдэг.

ХҮНДЭТГЭЛИЙН ОДОН БИШ

Сүнсний бэлэг (1Коринт 12:7-11) нь Бүтэн сайны хүндэтгэлийн цуглаан дээр зүүж очоод: “Надад тав бий, чамд хэд байна?” гэж өрсөлддөг зүйл биш. ТЭДГЭЭР НЬ АЖЛЫН БАГАЖ бөгөөд Бурхан таныг Өөрийнхөө ажилд бэлэн болох үед гардуулдаг юм. Танд цууц хэрэгтэй байхад, Бурхан танд алх өгөхгүй. Эзэн танд өдөр тутмын тань ажилд хэрэгтэй бүх багажийг өгнө. Багажийг хэрэглэх үедээ гайхамшиг болохыг үзнэ.

ҮЙЛС 1:8 ДЭЭРХ “ХҮЧ” (ДУНАМИС) ГЭДЭГ ҮГ НЬ тэсрэх бөмбөг шиг хүчийг илэрхийлж байна. Идэвхижүүлэхгүй бол, энэ нь зүгээр л чулуу мэт хэвтсээр байна. Хүмүүс “хүчийн” төлөө залбирдаг бөгөөд тэгээд мэдээж хүлээж авдаг. Дунамисын хүчин чадал нь хүний хэрэгцээнд зохицно. Бид яг л сүнслэг бодибилдерүүд шиг хүчтэй байхын тулд хөгжсөөр байж болно. Гэртээ гэргийдээ хоол хийхэд нь туслах гэж хуруугаа ч хөдөлгөдөггүй эр тайзан дээр гараад 230 кг өргөлөө гээд ямар ашигтай? Бид ажилдаа ашиглаж чадахгүй байж, худлаа хүчээрээ гайхуулах ямар ашигтай? Идэвхижүүлэхээс нааш Сүнсний хүч ямар ч ашиггүй болно.

ҮГЭЭР ХООЛЛОХ

Есүс бидэнд: “Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд

хивэн хорхой ба зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод, хулгайлдаг аж. Харин өөрсдөдөө эд баялгийг тэнгэрт хураа. Учир нь тэнд хивэн хорхой ба зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. Эд баялаг чинь хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно” (Матай 6:19-21) хэмээн анхааруулсан. Тиймээс бид сүнсээ золионд гаргаад, оюун ухаан, сэтгэл мэдрэмжээ баяжуулж болохгүй.

ТА НАР ХАРЬТАН БАЙХДАА ХЭЛГҮЙ ШҮТЭЭНҮҮДЭД ХӨТЛӨГДӨЖ, төөрөлдсөн байснаа мэдэх билээ (Коринт 12:2). Грекүүд дэлхийн мэдлэгээрээ алдартай байсан ч, Ариун Сүнсний юмс нь өөр ажгуу. Нийгмийн ухаан, физик зэрэг дэлхийн докторын зэрэг нь биднийг Бурханы юмст мэргэн болгохгүй. Бурханы юмсыг сүнсэндээ галыг асааж байж хүлээн авдагас биш, толгойдоо хүйтэн мэдлэг хурааснаар олж авахгүй. Сүнсээр өсмөөр байвал, сүнсээ Бурханы Үгээр дүүргэж, Сүнс дотор залбирах ёстой.

АРИУН СҮНСЭЭР ЗААВАРЛУУЛАХ

Бурханы Үгд яагаад үргэлж эргэлзэнэ вэ? Тэгэх атлаа Диаволын худалд яагаад нэг ч эргэлздэггүй вэ? Өнөөдөр өөрийнхөө эргэлзээнд эргэлзэж, Бурханы Үгд итгэхийг сонго. Тэгвэл төдөлгүй Ариун Сүнснээс тэнгэрлэг зааврыг хүлээн авна.

ДИАВОЛЫН ХУДАЛД ИТГЭХ ЯАГААД ТИЙМ АМАРХАН БАЙДАГ ВЭ? Хэрэв Ева могойн үгд эргэлзэхийг сонгосон сон бол? Бидний амьдрал тэс өөрөөр эргэх байлаа (Эхлэл 3). Нэгэнт эргэлзээнээсээ илүү Бурханы Үгд итгэх шийдвэр гаргавал, та Тэнгэрлэг тусламжийг авна. Ариун Сүнсний заавар итгэлийг тань байгуулж, харин итгэл тань эргэлзээний уулыг нураадаг юм.

ДЭЭРЭЭС ИРДЭГ ХҮЧ

“Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би
бүгдийг хийж чадна.”

Филиппой 4:13

ЦУЦАШГҮЙ ХҮЧ

Цахилгаан станцын талаар бүхнийг мэдлээ гээд харанхуй бөгөөд хүйтэн хэвээрээ үлдэж болно. Цөмийн эрчим хүчний байгууламжийн хана болгоныг иллээ ч тас хөлдөж болно. Дулааныг ажиллагаанд оруулах гол түлхүүр нь эрчим хүчний эх үүсвэрийг асаах юм. Таны дотор өдөөлтийг ялж, ариун хэвээрээ үлдэж, цэц ухаан дотор алхаж, ажилдаа онцгойрч, өвчин эмгэгийг ялах Ариун Сүнсний цуцашгүй хүч бий (2Петр 1:3). Гэхдээ үүнийг хэрэглэж сурах хэрэгтэй.

АРИУН СҮНС БИДНИЙ ДОТОР АМЬДАРЧ, ДИАВОЛЫГ БӨГӨӨД ёрын мууг ялан дийлэх хүчийг өгдөг. Бид гагцхүү Түүнээс “Туслаач!” гэж гуйх ёстой. Бод л доо: Танай гэрт цахилгаан эрчим хүч бий. Тэдгээр нь бүгд цахилгаан станцтай холбоотой. Та харанхуй шөнө гэртээ иртэл, цахилгаан дулаан байхгүй байвал, яадаг уу? Унтраалгаа дарахад л тог цахилгаан ирнэ. Тэгээд гэрэл, дулаантай болно. Сүнсний хүч дотор амьдрах нь яг л унтраалгыг дарахтай адил юм. Бусад бүх юм нь биднийг хүлээгээд л бэлэн байж байна.

БУРХАНЫ ХҮЧ ШҮҮЛТҮҮРГҮЙ ИРДЭГ

Ариун Сүнсний хүч нь хуурамч, хулхи эд биш, харин жинхэнэ Тэнгэрлэг хүч юм. Бурханы дуу хоолой Бичээс дотор замхраагүй. Бурхан Бичээс дотор маш эрх мэдэлтэй, жинхэнээсээ ярьдаг: “Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраая” (Матай 11:28). Маш товч тодорхой санал байна. Христийг хүлээгээд л авчихбал, Тэнгэрлэг амьдралаар амьдрах нь.

ГЭРИЙН ТОГ ЦАХИЛГААН НЬ ШУУД ГЕНЕРАТОРААС ИРЭХГҮЙ.

Энэ нь дэд станцуудаар шүүгдэн, бидний хэрэглээнд хавьгүй бага хүчээр ирдэг. Тэгвэл Бурханы хүч шүүгдэж ирдэггүй. Есүс ирэхдээ, Өөрийнхөө жинхэнэ дүр төрхийн зэвхий сүүдэр юмуу амьсгал төдий болж ирээгүй. Христ сүнс юмуу алс холхи найдварын цуурай болж ирээгүй, харин амьд Есүс болж ирсэн. Ариун Сүнс Сайн мэдээний хүндэтгэлтэй холбоотой бөгөөд Түүгээр дамжуулан Есүс бидний дунд орж ирж чадна. Та Сайн мэдээг хүчгүйгээр авчирж чадахгүй. Энэ нь галгүйгээр дулаан гаргахтай л ижил юм болно. Би онолдоогүй, харин Түүнтэй амьдрах амьдралын тухай ярьж байна. Энэ бүхэн бодитой бөгөөд хүчин төгөлдөр ажилладаг.

ГУНДАЖ АЛГА БОЛОХГҮЙ

Бурханы хүч гундаж, уусч алга болдог нийтийн хүч биш юм. Бурханы хүч нь Бурхан ӨӨРӨӨ юм. Сүнсний хүч нь Ариун Сүнс Өөрөө юм. Бурхан ууршиж, гундаж, гоожиж эсвэл муудаж алга болдоггүй. Цаг хугацаа Бурханд нөлөөлөхгүй - мянган жил ч нөлөөлөхгүй. Та Бурхантай холбоотой байсаар байвал, хүч дотор алхсаар байна.

БУРХАНЫ ХҮЧ ХЭЗЭЭ Ч СААРАХГҮЙ, ХЭЗЭЭД БОЛОМЖТОЙ БАЙНА. Паул Ромчуудад нэг, хоёр жилийн өмнө: “Би та нар дээр очихдоо Христийн ерөөлийн дүүрэл дор очно гэдгээ мэднэ”, “Учир нь та нарыг батжуулахын тулд сүнслэг зарим бэлгийг та нартай хуваалцахсан гэсэндээ та нарыг харахыг би ихэд хүсдэг” (Ром 15:29, 1:11) гэж хэлж байжээ. Тэрбээр Бурханы Сүнсний үргэлж оршигч, үргэлжилсэн урсгалыг мэддэг байв. Гагцхүү Христийг дуулгавартай дагахаа больж, Бурхантай тогтоосон харилцаа (машины аккумулятор шиг) зэврэх үед л Сүнсний хүч саарч, үгүй болно. Тэр үед хүмүүс үйлдлээ цэвэрлэж, дахин цааш хөдөлж эхлэх хэрэгтэй. Бурханы хүч таныг сууж байхад биш, харин хөдөлж байхад ирнэ.

ШИНЭ ТОСОЛГОО БИШ

Нэгэнт тослогдсон л бол, мөнхөд тослогдсон. Хавар, зун, намар, цөлд, модон дунд, ганцаараа, бусадтай – тосолгоо хэзээд байж л байна. Та хамгийн том атаат дайснаа халз тулаанд дуудаж, хамгийн том саадаа ялж, Бурханаас өгсөн хувь тавилангаа биелүүлж чадна – гагцхүү итгэх л хэрэгтэй.

ТОСОЛГООТОЙ ХҮН ГЭЖ ЯМАР БАЙДГИЙГ ЯРУУ ТОДООР ХАРУУЛСАН ХҮҮЧИН ГЭРЭЭНИЙ баатар Давидыг би биширдэг. Тэрбээр Бурхан өөртэй нь хамт байгааг яс махаараа мэддэг байв. Жишээлбэл, тэр Голиатыг халз тулаанд дуудахдаа, өөрийнхөө тосолгоонд өдийхэн ч эргэлзээгүй. Тэр Самуелийг дуудаж, ахин дахин тослуулаагүй. “Одоо над Голиатыг ялах тосолгоо өг!” гээгүй. Зуучлан залбирагч нараар залбируулаагүй. Тэр өөрөө ч залбираагүй. Тэр нэгэнт тослогдсон учраас мөнхөд тосолгоотой үлджээ. Үүнийг цаг хугацаа өөрчлөөгүй. Давид Филистин этгээдийн өөдөөс “Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түг түмдийн ЭЗЭНИЙ нэрээр чам уруу ирж байна” (1Самуел 17:45) хэмээн хашхирсаар гүйжээ. Тэгээд яасан? Тэр хүүхэд үлэмж биетийг алсан.

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 6:

ДҮРЭЛЗЭЖ БУЙ ХҮМҮҮС
- АРИУН СҮНС БА ИТГЭГЧ
ХҮМҮҮС

ЭХ ХУВЬ

“Бидэнд өгөгдсөн нигүүлслээр бэлгүүд маань ялгаатай.

Эш үзүүлэг нь итгэлийнхээ хэрээр үйлчлэл нь үйлчлэлээр, сургагч нь сургаалаар, ятгагч нь ятгалгаар, өгөгч нь өгөөмрөөр, удирдагч нь хичээнгүй зүтгэлээр, өршөөгч нь баяртайгаар үйлд.”

Ром 12:6-8

ШИНЭ БАЙДЛЫН СҮНС

“Үзэгтүн, Би шинэ зүйл хийх бөгөөд Тэр нь одоо соёолж гарна. Та нар үүнийг мэдэхгүй гэж үү?” (Исаиа 43:19) Бурханы Сүнс бидний дотор ажиллаж, шинэтгэж байна. Тэгвээс бид хуучин арга зам руугаа - тэр бүү хэл сайн уламжлал руугаа эргэж буцахгүй болно. Таны амьдрах насны турш Бурхан шинэ зүйл хийж, танаар дамжуулан дэлхийг өөрчлөхийг хүсдэг. Хуучинтайгаа бүү зууралд. Тан дээр Шинийн Сүнс байна.

БИ ЕР НЬ БУРХАНЫГ ОЙЛГОДОГ ГЭЖ ҮҮ? ТЭР БОЛ БҮТЭЭГЧ - САНААЧЛАГЧ Түүнээс зөвхөн их гарын бүтээл л гардаг. Тэр хоёр адилхан цасан ширхэг, жаргах нар, хүнийг бүтээхгүй. Бурханы оюун санаа дэндүү үржил шимтэй, дэндүү бүтээлч учраас Түүнээс хоёр ижил бүтээл төрнө гэж үгүй. “ШИНЭ” гэдэг үг нь Бурханы Өөрийнх нь үг. Ариун Сүнс бол шинийн Сүнс бөгөөд цаг үргэлж шинэчлэл, цэцэглэлийг авчирдаг: Шинэ төрөлт, шинэ хэл, шинэ дарс, шинэ дуу, шинэ зүрх. Тэр шинэ Сүнсийг, шинэ гэрээг, шинэ нэрийг авчирч, шинэ бүтээлийг бүтээдэг. Тэр бидэнд шинэ тушаал өгч, шинэ тэнгэр, газрыг бүтээжээ. Тийм боловч тэр л Сүнс нэг л зорилго тээдэг нь дэлхийн аврал болой. Харин бидний үүрэг нь Христтэй хамтран ажиллах юм (1Коринт 3:9).

ТОМ ЮМУУ ЖИЖИГ ДӨЛ

Танд Тэнгэрлэг ДНХ бий. Танд байгаа хүч нь Бурханаас Өөрөөс нь эхтэй. Энэ нь дууриамал, хулхи зүйл бус, харин жинхэнэ эх хувилбар юм. ... та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгчаас аугаа (1Июхан 4:4). Зоригтой бөгөөд урамтай бай!

ПЕНТЕКОСТ ӨДӨР АРИУН СҮНС ДЭЭД ӨРӨӨНД БАЙСАН
ДАГАЛДАГЧ НАР ДЭЭР БУУЖ ИРЭХЭД, “галынх мэт хуваагдсан

хэлүүд бий болон хүн нэгбүр дээр бүүв” (Үйлс 2:3) гэдэг. Юунаас ХУВААГДСАН (тасарсан)? ТОМ ГАЛААС буюу БУРХАНААС хуваагдсан (тасарсан) галан хэлүүд. Жижиг хэлүүд нь Бурханаас салж, толгой нэг бүр дээр бүүжээ. Том, жижиг дөлүүд нь бүгд БУРХАНЫГ төлөөлж байв.

ЦААШИД ЭНГИЙН БАЙХАА БОЛЬСОН

Ариун Сүнсний баптисмаас ирдэг Тэнгэрлэг гал таны зэргийг энгийнээс ер бусын зэрэг рүү өөрчилдөг. Та цаашид өөрийнхөө төлөө амьдрахгүйн тулд Тэнгэрлэг эрхийг авч, амиа бодох явдал, айдсаа хаяж, Тэнгэрлэг зорилгыг авна. Та сонгогдсон сав болно.

МОСЕ 40 ЖИЛИЙН ТУРШ ӨДӨР БҮР БУТ СӨӨГ ХАРСАН. Тэрбээр тэр ургамлыг хэзээ ч сонирхож судлаж байгаагүй. Цөлийн бут сөөг ямар ч сонирхолгүй, царай муутай юмнууд байдаг. Гэтэл Бурхан нэгийг нь аваад, тэр жирийн юмыг ер бусын болгожээ - галаар дүрэлзэх атлаа шатааггүй (Гэтлэл 3:2). Тэгснээ Бурхан тэр бутан дотроос үгээ айлдсан - шатаж буй бутан дундаас Бурханы дуу хоолой гарсан. Мосе нэг талаараа яг л тэр бут шиг байв - эгэл жирийн - за магадгүй бүр эгэл жирийнээс ч дор. Тэр зүгээр л нэг банз байв - ямар ч ирээдүйгүй, хуулиас зугтаж яваа алуурчин оргодол. Тэр зүгээр л хоньчин байсан агаад харин Египетчүүд хоньчдыг үздэггүй байв (Эхлэл 46:34). Мосе шатах боловч шатаж, үнс болохгүй байгаа бутыг үзжээ. Энэ нь түүний амьдралыг өөрчлөх эгшин байсныг Мосе гадарлаа ч үгүй. Тэрбээр сониуч зандаа хөтлөгдөн, ойртож ирээд, бишрэн ширтжээ. Тэгтэл бутнаас Тэнгэрлэг гал үсрээд, сэтгэлийг нь нэвт сүлбэчихжээ. Мөнх бус хүн болох Мосе Галт хүн болов. Бурхан "... үйлчлэгч нараа галын дөл болгодог" (Еврей 1:7). Та ч бас шатах бутыг харах гэж хүрч очихдоо, цаашид энгийн байхаа болино.

ТАНЫ ЭХ ТОСОЛГОО

Та Бурханы зорилгын төлөө өөрийнхөө цаг, улирлын төлөө давтагдашгүйгээр бүтээгдэж, тослогдож, томилогдсон. “Амьдрах өдрийн чинь уртад хүч чадал оршино” (Дэд хууль 33:25). Танд байхгүй зүйлийнхээ төлөө зовниж байхын оронд байгаа зүйл дээрээ төвлөрч, итгэл дотор алхалж, Бурхан танаар дамжуулан ажиллахыг үз.

ПЕНТЕКОСТ ӨДӨР 120 ДАГАЛДАГЧ ДАВХАР ТОСОЛГООНЫ ТӨЛӨӨ ХАШХИРААГУЙ. ДЭЭД ӨРӨӨНД ХЭН Ч ТОЛГОЙ ДЭЭРЭЭ ХОЁР ГАЛТАЙ БАЙГААГУЙГ ТЭМДЭГЛЭЭРЭЙ. Хүн бүр дээр нэг, нэг хэл л буусан (Үйлс 2:3). Гэхдээ энэ ганц дөл нь Бурханы бүхэл галыг - үүний эрх мэдэл, хүч, алдрыг төлөөлж байв. Намайг дэлхийгээр аялж явахад, “Миний төлөө залбирч өгөөч. Би таны тосолгоог авмаар байна” гэсэн хүсэлт их ирдэг. Би өөдөөс нь юу гэж асуудаг гээч? “Би танд өөрийнхөө тосолгоог өгчихбөл, хоосон харина гэж бодож байна уу? Мэдээж үгүй.” Гэхдээ гайхмаар нэг нууц бий: Хэрэв та Рейнхард Боннкегийн тосолгоог авбал, зүгээр л Рейнхард Боннкегийн хуулбар болно. Би таныг нэг хувилбарын хуулбар болоосой гэж хүсэхгүй байна. Бурхан ч үүнийг хүсэхгүй.

Хэрэв та Бурханы зан чанарын талаар ямар нэг зүйл мэдэхийг хүсч байгаа бол, мөн чанарыг нь бодоод үз. 7,5 хол давсан тэрбум хүний дунд ижилхэн хурууны хээтэй хоёр хүн байхгүй, ижил бүтэцтэй хоёр навч байхгүй шүү дээ. Яагаад? Учир нь Бурхан хувилагч биш, харин Бүтээгч. Тэр зөвхөн ЭХ ХУВИЙГ бүтээдэг. Түүнд хувилагч машин байхгүй. Таны толгой дээрх дөл бол зөвхөн таны нэрийг тээсэн, ганцхан танд л зориулсан, захиалгын эд. Өөр хэнд ч таарахгүй. Газар дээрх ямар ч хүн яг тан шиг Бурханд үйлчлэхгүй! Та онцгой - таны тосолгоо ч онцгой!

ДАВХАР ХУВИАС ИЛҮҮ

“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Учир нь Би Эцэгтээ очно. Та нар нэрээр минь юу ч гуйсан, Эцэг Хүүгээр алдаршуулагдахын тулд Би түүнийг үйлдэнэ. Та нар нэрээр минь юм гуйвал Би түүнийг чинь үйлдэнэ.”

Иохан 14:12-14

БУРХАНЫ ХУРУУ

Таны дээр хуруу байгаа боловч, энэ нь сүйрлийн хуруу биш юм. Энэ нь Бурханы Хуруу бөгөөд өвчтэйг эдгээж, үхсэнийг босгож, диаволыг хөөх Өөрийнхөө үйлчлэлийн төлөө таныг ерөөж, онцгойруулж, хүчирхэгжүүлэхийн төлөө тан руу заасан хуруу юм. Бурханы хуруу нь Ариун Сүнс юм (Үйлс 10:38). Тэр таныг харанхуйн хүч бүрээс чөлөөлж, амьдралд чинь Бурханы сайн сайхныг цутгана.

ИЗРАИЛИЙН ЕРӨӨЛҮҮД НЬ “Израиль улсын” төлөө гэрээтэй юм (Ефес 2:12). Христ Есүс гайхамшгуудыг Христийн шинэ нэгдэлтэй холбосон: “Гэвч Би Бурханы хуруугаар чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймд Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна” (Лук 11:20). Ариун Сүнснээс илүү хүч байхгүй. Энэ нь Хаанчлалын хүч бөгөөд үүнтэй өөр ямар ч хүч эгнэхгүй. Тэр үйлчлэлээ сонгосон хүмүүстээ хуваарилдаг.

ЕЛИАГИЙН НӨМРӨГ

Есүс “Үзэгтүн, энд Соломоноос аугаа нь байна” (Матай 12:42), “Абрахамаас өмнө ч Би байгаа” (Иохан 8:58) гэсэн бол, Иохан Баптистын талаар “Та нар хүлээн авахыг хүсвэл тэр нь ирэх ёстой Елиа юм” (Матай 11:14) гэжээ. Та Елиагийн нөмрөгөөс аугаа нөмрөгийг буюу Есүсийн Өөрийнх нь “Ариун Сүнсний баптисм” гэдэг нөмрөгийг хүлээн авснаа ухаарах ёстой. Энэ маш чухал.

ПЕНТЕКОСТ - КАРИСМАТИК ХҮРЭЭНД ХҮМҮҮС ЕЛИАГИЙН НӨМРӨГИЙН ТӨЛӨӨ залбирч байхыг олонтаа сонсож болно: Елиа шиг дээрээс галыг дуудан буулгах, гайхамшиг, тэмдэг, дохио

үйлдэх. Гэхдээ “Итгэгчдэд дагалдах тэмдгүүд нь: Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярих болно. Тэд могойг барина. Бас үхүүлэх ямар ч юм тэд уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтөнд тэд гар тавивал эдгэнэ” (Марк 16:17,18) хэмээн Есүс Өөрөө тодорхой айлдсан. Бид Елиагийн нөмрөгийг гуйх гэж үү? Үгүй юм аа. Есүс бидэнд Өөрийнхөө нөмрөгийг - Ариун Сүнсний баптисмыг өгдөг. Бид гагцхүү үүнд итгэж, дотор нь алхаж ороход л гайхамшиг тэмдэг дагалдана.

САНААНД Ч ОРОМГУЙ

Эзэн Бурхан “бидний дунд” төдийгүй, бидний дотор байдаг. Түүний оролцоо байхгүй гэж үгүй. Түүнийг хайж, мацаг барьж, шаардаж, “тунхаглах” хэрэггүй. Түүний оршихуй нь Христэд итгэх итгэлийн мөн чанарт амин чухал буюу.

ЭШ ҮЗҮҮЛЭГЧ НАР ЭНЭ ТУХАЙ ЗӨГНӨЖ БАЙСАН Ч ӨӨРСДӨӨ ҮЗЭЭГҮЙ. Эцсийн эш үзүүлэгч Иохан Баптист “Би та нарт гэмшлийн чинь төлөө усаар баптисм хүртээдэг. Харин Надаас илүү хүчирхэг Нэгэн миний араас ирж байна. Би Түүний шаахайг авч явах ч үнэ хүндгүй. Тэр та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ” (Матай 3:11) гэсэн. Шинэ гэрээний итгэгч нар аврал сэргэлтийн багцын нэг хэсэг болгож Тэнгэрлэг дотнослыг цоо шинэ хэр хэмжээнд эдлэх болжээ. Бурхантай хамт хүндэтгэхээс гадна Тэр бидэнтэй хамт байх бөгөөд хувь хүн бүр Түүний нигүүлслээр аврагдсан болой (Иохан 14:17). Бид үүнийг олж авах гэж зүтгэх шаардлагагүй. Түүний хайр баталгаатай. Бид дахин төрсөн бол, Бурханы Хурганы цусаар нүглээсээ цэвэрлэгдсэн бол, Түүний оршихуйн талаар юу ч хийх хэрэггүй. Тэр хэдийнээ тэнд хэзээд оршино! Энэ бол бидний итгэлийн алдар.

ТЭР БИДЭНТЭЙ ХАМТ БАЙНА

Бурхан өдөр ч, шөнө ч хамт. Биднийг ажиллаж амьдарч байхад, Тэр чуулгандаа л хүлээгээд байж байдаг бол, яаж биднийг аварч, бидний хүч байх билээ? Шүтээнд мөргөгчид бурхдынхаа сүм рүү явдаг бол, Христ бидэнтэй үргэлж байдаг. Тэр яг одоо намайг ширээнийхээ ард суугаад үүнийг бичиж байхад, надтай хамт байгаа. Бас намайг Сайн мэдээний аянаар номлож байхад, надтай хамт байдаг. Бид өөр өөр байв ч, Тэр нэг л янзаараа (Иаков 1:17). Боломж Түүнд тушаадаггүй. Түүнд зан аашийн хувирал байхгүй, Тэр бидний зан аашд автахгүй. Тэр ирээд явдаггүй, бидний хандлагаар хойшоо урагшаа савалдаггүй. Бид хэдэн янз болдог бол, Тэр мөнхөд хэвээрээ л байна.

БҮРХАН БИДНИЙ СҮНСЭЭР ХҮЧТЭЙ БАЙГАА ҮЕИЙГ ЛАШИГЛАЖ, АЖИЛЛАДАГГҮЙ. Биднийг хаа ч байсан, Бурхан хамт байдаг. Биднийг Бурханы ойр байгааг мэдэхгүй, унтаа юмуу ухаангүй үед ч хамт байдаг. Дуулал 4:8 дээр “Би амар амгалан хэвтэж, унтах болно. Аюулгүйгээр аж төрүүлэгч минь, ЭЗЭН, Зөвхөн Та билээ” гэдэг. Тэр бидэнтэй хамт байгаа учраас, бид аюулгүй байдал дотор “оршиж” чадна. Христ “Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:20) хэмээн айлдсан.

ЯЗГУУРТАН ТАХИЛЧ

“Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун
үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм.
Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт
гэрэл уруу дуудсан Түүний хүчирхэг
үйлдлийг та нар тунхаглах юм.”

1Петр 2:9

ГАЛТ ТИТЭМТЭЙ ТОЛГОЙНУУД

Та бол Хааны хөвгүүн, охин. Бурхан таныг алдар, галаараа титэмлэсэн. Та толгой дээрх эрх мэдэл, хүчээ - Ариун Сүнсний галт хэлээ далайна. “Харагтун, могой ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн” (Лук 10:19). Та хулчгар нэгэн биш. Дайсныхаа өмнө нуугдаж, дорд амьдралаар бүү амьдар.

ТА ГАЛТ НАВЧИН ТИТЭМ ЮМУУ ГАЛТ ТИТЭМ ӨМСӨХӨӨР Л ТӨРСӨН! Энэ бол зөвлөлийн шийдвэр биш. Итгэгч бүр галыг тээж, Ариун Сүнсний хүчний эрх хүчний НАВЧИН ТИТМИЙГ зүүж явах нь Бурханы хүсэл юм. Толгой дээр маань язгууртны ГАЛТ ТИТЭМ байна. ҮҮНИЙГ ТЭНГЭР ӨӨРӨӨ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ЮМ. АМЬД ЭРХ МЭДЛИЙН ТИТЭМ. Бид Сүнс дотор баптисм хийлгэсэн - ХҮЧЭЭР ТИТЭМЛЭГДСЭН.

Моше Израильчуудыг ерөөхдөө, Иосефийн талаар өгүүлсэн үг нь үзэсгэлэнт яруу найргаас ч эгшиглэнтэй байв (Дэд хууль 33:13-17). Энэ нь эш үзүүлийн амлалтыг өгүүлж байв: “Түүний нутгийг ЭЗЭН ерөөж, Тэнгэрийн үнэт зүйлс, шүүдэр ба оёоргүй гүнд хадгалагдах усаар, нарны ургуулдаг үнэт жимсээр, Сарны гаргадаг үнэт бүтээлээр, эртний уулсын хамгийн сайн зүйлсээр, Мөнхийн толгодын үнэт зүйлсээр, газрын үнэт зүйлс хийгээд түүнийг дүүргэдэг бүхнээр, Бутан дотор оршиж байсан Түүний таалмаар ивээх болтугай! Тэр ерөөл нь Иосефын толгой дээр, Ах дүүсийнхээ дунд ялгарсан нэгний Толгойн титэм дээр буух болтугай!” Иосефийг титэмлэсэн, шатаж буй бутанд оршиж байсан Бурханы таалал нь бидэнд зориулсан Библийн амлалт юм. Шатаж буй бутны Бурхан биднийг титэмлэхэд, тэр титэм нь бидэнд сүнслэг эрхэмсэг байдал, эрх мэдлийг авчирна. Бид хүч, баталгаагаар ярина. Учир нь бид Хэний эрх мэдлээр ярьж байгаагаа МЭДНЭ.

ТОЛГОЙ ДЭЭГҮҮР

Сайн мэдээ нь биднийг ядаж дэлхийн хамгийн дорой хүчин зүйлийн хэмжээнд авааччих юмсан гэсэндээ өгөгдөөгүй, харин биднийг цоо шинэ болгон бүтээж, бүгдэд маань Бурханы хөвгүүд гэсэн нэр алдрыг хайрлахын төлөө өгөгдсөн билээ. Нэгэнтээ ганхаж байсан хүмүүс эдүгээ Бурханы хөвгүүд хэмээн дуудуулж, Бурханы хөвгүүд шиг амьдарна. Халлелүяа! Үүн шиг Сайн мэдээг номлох шалтгаан үгүй! Үүнээс илүү баясмаар, адал явдалтай, үнэ цэнэтэй зүйл гэж байх уу?

ХРИСТЭД ИТГЭДЭГ ХҮМҮҮС ДЭЛХИЙ ДАЯАР Бурханы гэр бүлийн нэр алдрыг тээсэн, Тэнгэрийн ноёд, хатагтай нар шиг толгой дээгүүр, зовхи өөдөө алхалж чадна. “Мөхөс нэгэн нь Би хүчтэй хэмээг” (Иоел 3:10). Бид бол Аврагчийн үнэт, нандин бараа юм. Бурхан бидэнтэй хамт. Бид Аугаа хүчирхэг Бурханы хүчийг олсон, тэнгэр элч нараар хамгаалагдсан, хүчээр бэхэжсэн, хамгийн цэцэрхэг дуудлагаар хөтлөгдсөн, Бүтээгчийн мөнхийн эрэмбэ дараалалд багтсан, нигүүлслээр анхилсан хүмүүс. Сайн мэдээ Бурхан, биднийг мөнхөд нэгтгэсэн.

АМЬД ГАЛ

Бурхан хэнээр ч дамжуулан ажиллаж чаддаг нь гайхмаар. Бурхан тухайн газрын суутнууд, баатрууд, алдар гавьяатнуудыг бус, харин нэг их нэр алдаргүй, суу бүтээлгүй хүмүүсээр дамжуулан ажиллах нь олонтаа. Бурхан улс орны олон титэмтэй толгойнуудыг ашигладаггүй, харин галт титэмтэй хүмүүсийг сонгодог. Энэ нь Бурханы ажлын чанарын жишиг - итгэл, галын эрх мэдэл болой.

ТУХАЙН ҮЕД БОЛОМЖТОЙ ОЛОН ЦЕЗАРЬ, ЗАХИРАГЧ НАР БАЙВ:
Пилат, Кайфас, Тэргүүн тахилч зэрэг тухайн үеийн улс төр, шашны
дээдсүүд. Гэхдээ Есүс тэднийг тоолгүй, оронд нь боловсрол, соёлгүй
гэж хэлж болохоор загасчин, татвар хураагч, Галилын наймаачид
дээр очжээ. Тэдний зарим нь хуурч, нэг нь хулгайлсан. Гэхдээ тэд
бүгдээрээ Есүсийн үгэнд орж, захирагдаж байсан тул Есүс тэднийг
өөрчлөгч нар болгон өөрчилж чадсан юм. Есүс өнөөдөр ч энэ
ажлаа үргэлжлүүлэн хийсээр, бүх төрлийн эрчүүд, эмэгтэйчүүдийг
хэрэглэсээр байна. Есүс тэднийг цусаараа цэвэрлэж, Сүнсээрээ
хүчирхэгжүүлж, дэлхийг өөрчлөгч нар болгон өөрчилж байна. Та ч
тэдний нэгэн адил амьд гал болж чадна.

АЛДРЫН БӨГӨӨД ХҮЧИЙН ШИНЭ ХЭМЖИГДЭХҮҮН

“Петр, Иохан хоёр залбирлын есдүгээр цагт сүм рүү явж байв. Төрөлхийн суунги нэгэн хүнийг хүмүүс өдөр бүр авчран сүмийн Үзэсгэлэнт хэмээх дааман хаалганы дэргэд суулгаж, тэрээр сүмд ирэгсдээс гуйлга гуйдаг байжээ. Петр, Иохан нарыг сүмд очиход тэр тэднээс гуйлга гуйв. Петр, Иоханы хамт түүн дээр харцаа тогтоон —Наашаа хар гэв. Тэднийг юм өгөх нь гэж горьдон тэр тэднийг харав. Харин Петр түүнд —Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд —Назарын Есүс Христийн нэрээр [босоод] явагтун гэж хэлээд баруун гараас нь барьж өндийлгөсөнд түүний хөл, шагай тэр даруй хүч орж, үсрэн цэх зогсоод, алхаж эхлэв. Тэр тэдэнтэй сүмд орж, цовхчин, Бурханыг магтав. Бурханыг магтан алхаж буй түүнийг бүх хүн хараад, сүмийн Үзэсгэлэнт дааман хаалганы дэргэд гуйлга гуйхаар суудаг байсан нэгэн болохыг таньж, түүнд тохиолдсон явдалд гайхан алмайрцаав.”

Үйлс 3:1-10

ШИНЭ ХЭМЖИГДЭХҮҮН

Хэлээр ярьдаг, Сүнс доторх баптисм нь шинэ хувьсгал, засвар, гоёл чимэглэл биш юм. Энэ нь чөлөөлөлт бөгөөд Христэд сургаалд шинэ хэмжигдэхүүн авчирдаг. Сүнс доторх баптисм нь зүгээр л Ариун Сүнснийг Хэн болохыг харуулж, биднийг Түүний хүчээр “дүүрэхэд” хүргэдэг зүйл юм.

ХУУЧНЫ ЭШ ҮЗҮҮЛЭГЧ НАР СҮНС ДОТОР БАПТИСМ ХИЙЛГЭЭГҮЙ Ч Сүнс тэдэн дээр бууж ирэхэд, тэд хөдөлдөг байсан юм. Заримдаа бас гайхамшиг ч өрнөж байв. Эдгээр ер бусын үр нөлөө нь Бурханы амьсгалаар бууж иржээ. Амьсгал гэдэг үг нь Еврейгээр Сүнс гэдэгтэй ижил (руах) гэдэг үг юм. Бурхан Саул хаанд хүрэхийг нь хүн бүр харсан байдаг. Тэгээд Бурханы Сүнсний амьсгал нь Түүн дээр бууж ирсэн гэдэг. Хуучин гэрээнд Бурханы Сүнс хүмүүсийн дотор суурьшилгүй, зөвхөн онцгой үед л онцгой зорилгын төлөө хөдөлгөдөг байв. Шинэ гэрээн дор Ариун Сүнс итгэгч хүний дотор оршиж, түүнийг хүчирхэгжүүлж, Шинэ гэрээний үйл явдлыг Хуучин гэрээнээс хавьгүй илүү болгодог.

ГАЗРЫН САВ ДОТОРХ ЭРДЭНЭС

Ариун Сүнс бол эрдэнэс. Гэхдээ бид сүйрсэн усан онгоцноос далайн ёроолд үлдэж хоцорсон, дотроо бөөн, бөөн эрдэнэстэй зэвэрсэн, хүйтэн авдар биш. Бид бол цэвэр, халуун, шингэн алтыг тээдэг сав. Бидэнд хүрэхэд эсвэл ширтэхэд халуун мэдрэхгүй байна гэж байхгүй.

БУРХАНЫ АЛСЫН ХАРААГААР БАЯРЛАН БУЖИЖ БАЙГАА ХҮМҮҮС ИНЭЭДТЭЙ ЮУ эсвэл Наполеоныг их буугаар буудахад ч хөдлөөгүй

Сфинкс шиг гөлийсөн хүмүүс инээдтэй юү? Хүний махан бие, цус нь Сүнсийг хүлээн авсан атлаа ямар ч шинж үзүүлдэггүй гантиг биш юм. Хүчний давамгайлал нь биднийх биш, харин Бурханых гэдгийг харуулахын тулд бид энэхүү эрдэнэсийг шавар савнуудад тээдэг (2Коринт 4:7). Яг л Фест Паулд: “Паул, чи солиорчээ. Их эрдэм ном чинь чамайг галзуу болгожээ” (Үйлс 26:24) гэж хэлсэн шиг, Бурханаас хол хөндий хүмүүсийн ухаан санаанд хачин жигтэй санагдах зүйлс үзэгдэнэ. Өнөөдөр Христэд итгэх итгэлийн эх хувийг үзсэн хүмүүс өөрөөр яах ч билээ?

ЧАДАХААС Ч ИЛҮҮ

“Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ? Тэр Өөрийн Хүүг харамлалгүй, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ? ... Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? ...Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг. Учир нь үхэл ч, амь ч, тэнгэрэлч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэдэгт би бат итгэлтэй байна.”

Ром 8:31-32, 35, 37-39

ТЭГШ БУС ГАЗАРТ ЗОРИУЛАН УРЛАГДСАН

Христэд итгэх итгэл нь сул дорой биш юм - хахир хатуу бүтцүүдэд болоод бусдын харгислалд нэрвэгддэг хэврэг төрөл биш юм. Эстер шиг дээд зэргийн хүмүүжилтэй язгууртан биднийг эрх дархаар тоглоод дэмий (Естер 7:3-10). Ариун Сүнсний хүч биднийг арслан шиг зоригтой болгодог (Сургаалт үгс 28:1). Бид Иудагийн Арслан шиг архирдаг. Энэ тийм сонин байна гэж үү? Бид чинь Бурхан хөвгүүд, охид шүү дээ!

АРИУН СҮНС ИТГЭГЧ НАР ДЭЭР БУУЖ ИРЭХДЭЭ, тэдэнд зүгээр л нэг гайхамшиг, тэмдэг, дохио үйлдэх хүч өгөөгүй. Энэ нь тэднийг цаг хугацааны бэрхшээлд бэхжүүлж, ирэх хавчлагад хатуужуулсан. Ариун Сүнс ирснээр элч нар шинэ тэсвэр хатуужлыг олсон. Тэднийг сул дорой болох үед нь доторх шинэ хүч, тэнхээ нь ажиллаж, дараа нь тэднийг шүтээний үүр уурхай болсон, харгис цөвүүн дэлхий рүү шүтээнийх нь амийг тасалж, түүхийг өөрчлүүлэхээр илгээдэг. Энэ бол “Сүнсээр дүүрэн амьдралын” жинхэнэ тэмдэг.

МӨНХИЙН ХАВАР

Сүнсээр дүүрэн амьдрал нь хүлэмж доторх сараана цэцэг шиг онцгой нөхцөлд боловсордог үйл явдал биш юм. Христэд итгэдэг хүмүүс цэцэг биш. Ариун Сүнс итгэгч нарыг ямар ч нөхцлийг ажрахгүй давах чанга төрөл зүйл болгодог. Тэд сэтгэлдээ мөнхийн хаврыг тээн, өвөлдөө бэлтгэдэг.

ТА ТОДОРХОЙ НӨХЦӨЛД Л АМЬДАРДАГ, ӨӨРӨӨ АМЬДРАХ ЧАДВАРГҮЙ ХҮЛЭМЖИЙН УРГАМАЛ БИШ. Итгэгч хүн амьд усны булгаар таригддаг. Та мөнхийн хаврыг тээдэг: гадаах уур амьсгал, нөхцөл ямар ч байсан, таны навчис үхэхгүй. Нөхцөл байдлаас үл хамааран, та Бурханы төлөө үр жимс ургуулсаар байна (Дуулал 1).

ЗУУХ

*Зуухгүйгээр ямар ч сайхан байшин, хүйтэн өвөлд зутарна.
Та хүйтэн, харанхуй, муухай дэлхийд яг л зуух мэт ажиллан,
дулааныг авчрахаар урлагджээ. Бурханы Сүнсний салхи таныг
ноцоож, бүх итгэлгүй, найдваргүй байдлын тоос шороог үлээг.
Та Бурханы Үг дотор итгэлийн түлээг нэмэхэд, Ариун Сүнсний
галаар шатам халуун болно.*

БУРХАН ХҮНИЙ ЗҮРХИЙГ ЗУУХ БОЛГОХ ГЭЖ БҮТЭЭСЭН ЮМ.
Пентэкостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газар цугласан байлаа. Хүчит хуй салхи мэт чимээ тэнгэрээс гэнэт гарч, тэдний сууж байсан байр бүхэлдээ үүнд автжээ. Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв (Үйлс 2:1-4). Жинхэнэ гал дулааныг цацраана. Загас биеийнхээ дулаантай ижил хэмийн усанд сэлдэг. Тэгвэл зарим итгэгч нар яг тэгдэг. Тэд бурханлаг бус зугаа цэнгэлийн хэмийг тээх атлаа юу нь буруудаад байгааг гайхдаг. Бидний зуух галтай байхад, бид халуун байна. Бид эргэн тойрныхоо хэмийг өөрчилдөг.

ГАЛ АСУУДЛЫГ ШИЙДДЭГ

*Диавол хүмүүсийг сүнээр хөлдүү хүйтэн байхад дуртай.
Магадгүй бүр шашинлаг байсан ч түүнд тааламжтай. Ариун
Сүнсний галаар шат, тэгвэл дайсан халуунд зайлна.*

НЭГЭН ХАТАГТАЙ НАДАД: “МИНИЙ ТОЛГОЙ ДЭЭР ЧӨТГӨР СҮҮЖ БАЙНА” гэж хэлсэн юм. Тэгэхээр нь би: “Та Бурханы хүүхэд мөн үү?” гэж асуусанд, хатагтай толгой дохилоо. Би гайхав. Гэтэл гэнэт Ариун Сүнс надай ярьж, би хатагтайгаас: “Ялаа хүйтэн

зуухан дээр л удаан суудгийг мэдэх үү? Ариун Сүнсний гал, дулааныг амьдралдаа оруулбал, Дяволын асуудал нэг мөр шийдэгдэнэ” гэж хэлсэн юм. “Зуух” чинь халуун бол, ялаа дөхөж ирээд, халууныг мэдрэхдээ, хар эрчээрээ зайлна. Бид Ариун Сүнсний галаар буюу “галт ханаар” хамгаалагдсандаа Бурхандаа талархъя.

ХЭЗЭЭ Ч ГАНЦААРАА БИШ

“Харин Иаков аа, чамайг Бүтээгч ЭЗЭН, Израиль аа, чамайг бий болгогч ЭЗЭН Одоо ингэж айлдаж байна. “Би чамайг аварсан учир Бүү айгтун. Би чамайг нэрээр чинь дуудсан. Чи Минийх. Чамайг ус гатлахад Би чамтай хамт байна. Голоор туулахдаа чи живэхгүй. Гал дундуур явсан ч чи түлэгдэхгүй, Дөл нь ч чамайг шатаахгүй. Учир нь Би чиний Бурхан ЭЗЭН, Израилийн Ариун Нэгэн, чиний Аврагч мөн. Би Египетийг чиний төлөөсөнд, Куш ба Себаг чиний оронд өгөв.”

Исаиа 43:1-3

ТУУШТАЙ БАЙДАЛ БОЛ БАТАЛГАА

Бурхан оришихуйгаа бидний дунд өгөөгүй. Бурхан Ариун Сүнсний оришихуйн бэлэгээ танд, надад, бидэнд - хүн нэг бүрт хувьчлан зориулж, хувьчлан өгсөн билээ.

“БИ МОСЕТЭЙ ХАМТ БАЙСНЫХАА АДИЛ ЧАМТАЙ МӨН ХАМТ БАЙХ БОЛНО” (Иошуа 1:5). “Эзэн Иосефтай хамт байсан” (Эхлэл 39:2). Энэ хувийн баталгаа нь Израильд мөнхөд хамаатай. Тэднийг хөсөрдүүлэхгүй гэсэн Бурханы амлалт нь тухайн удирдагч нарт төдийгүй, үндэстэн даяар хамаатай үг байв. “Бидэнтэй хамт” хэмээн эрт дээр үед Бурханы өгсөн амлалтыг бид уянгын халил мэтээр ойлгож болохгүй. Энэ нь танд, надад - Библийн уншигч бүрт өгсөн хувийн баталгаа юм.

“АХИАД ЖААХАН” АРИУН СҮНС?

Танд тал Ариун Сүнснийг бус, харин бүтэн Ариун Сүнснийг хувьчлан өгсөн. Ариун Сүнс хэсэгчлэн юмуу хэсэг хэсгээр ирээгүй. Танд “ахиад жаахан” Ариун Сүнс хэрэггүй. Бурхан танд бүрэн бүтнээрээ байна. Зүгээр л Бурханд бууж өгөөд, Бурхан бүрэн эхээрээ таных гэдэгт итгэвэл, амьдралаасаа Ариун Сүнсний гайхамшигтай илрэлүүдийг үзнэ.

“АХИАД ЖААХАН” БУРХАН? ДАЛАЙН УСАНД ОРСОН ХҮН “АХИАД ЖААХАН” ИЛҮҮ НОРНО гэж байдаггүй юм. Бид хүүхдийн элсний хувинтай усан дуслaar бус, харин Ариун Сүнсний Номхон далай, Атлантын далайд норсон хүмүүс. Биднийг норгосон ус нь Бурханы хөлгүй их усан сангийн ус юм. Тэр усанд сэлж байгаа хүн нэг бүртэй бид Сүнс дотор нэг юм. Бодоод үз. Элч Паул “Учир нь иудейчүүд эсвэл грекүүд, боолууд эсвэл эрх чөлөөт хүмүүс ч

ялгаагүй бид бүгд нэг Сүнсээр нэг бие уруу баптисм хүртэж, нэг Сүнсийг уусан юм” (1Коринт 12:13) гэсэн. Сүнслэг тэмдэг нь галын тэмдэг билээ. Бодит тэмдэг нь хэлээр ярих билээ.

ДАВХАР ХАМГААЛАЛТ

Бидний аюулгүй байдлыг хангахын тулд Аав Хүүтэйгээ нэгддэг. “Учир нь та нарын амь Христтэй хамт Бурханд нууцлагдсан” (Колоссай 3:3). Би үүнийг маш бат бэх хамгаалалттай өрөөн доторх бат бэх цоожтой сэйф гэж боддог юм. Бид давхар хамгаалалттай. Биднийг юу ч салгахгүй.

БИ ЕСҮСИЙН ЦУСААР УГААГДСАН бөгөөд биднийг Түүний гараас хэн ч булаахгүй гэдэг баталгаатай амьдардаг (Иохан 10:28-30). Сатан миний сэтгэлийг хулгайлж чадахгүй. Энэ нь Бурханы дотор Христтэй хамт нууцлагдсан бөгөөд Христийн цусны тамгыг тээдэг (1Петр 1:18-19). “Эзэний дотор үргэлж баярла. Би дахин хэлнэ. Баярлагтун!” (Филиппой 4:4).

ЗАЛБИРЛАА ЗАС

Энэ үнэн сэтгэлд чинь аль болох гүн сууг. Амьдралаа тунгаа - хаашаа ч явсан, юу ч хийсэн тунгаа. Эзэн тантай хамт. Тэр таныг хаях ч үгүй, орхих ч үгүй (Еврей 13:5). Энэ бол карисматик онцгой хэлц, хэллэг биш. Энэ бол сүнслэг үнэн бөгөөд бодит байдал.

БИДЭНД ЗАЛБИРАХ ДАДАЛ ХЭВШИЛ БИЙ. Тухайлбал би залуу байхдаа “Эзэн минь, бидний дунд бууж ирээч” гэж их залбирдаг байлаа. Гэтэл нэг өдөр сэрээд өөртөө: “Намайг хэзээ ч орхихгүй

гэж амласан Бурханыг би ирээч гэж гуйх ямар утга байна?” гэж хэлсэн юм. Есүс үнэхээр ч биднийг хэзээ ч, хэзээ ч орхихгүй хэмээн амласан (Матай 28:20). Бид Есүс бидэнтэй цаг үргэлж хамт гэсэн бодит үнэн дотор амьдарч, хуучин залбирлаа өөрчлөх хэрэгтэй.

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 7:

ГАЛАН ОЙ - АРИУН СҮНС БА
ЧУУЛГАН

ШИНЭ ЭХЛЭЛ

“Ийнхүү түүний үгийг хүлээн авагсад баптисм хүртэцгээв. Тэр өдөр гурван мянга орчим хүн нэмэгджээ. Тэд, элч нарын сургаалд мөн нөхөрлөлд, талх хуваалт, залбиралд өөрсдийгөө зориулдаг байлаа. Хүн бүрд айдас байлаа. Учир нь элч нараар [Иерусалимд] олон гайхамшиг, тэмдэг үйлдэгдэж байв.”

Үйлс 2:41-43

ЁСТОЙ МУНДАГ БЭЛЭГ!

“Хүчит хуй салхи мэт чимээ тэнгэрээс гэнэт гарч, тэдний сууж байсан байр бүхэлдээ үүнд автжээ” (Үйлс 2:2). Ариун Сүнс аугаа хүчээр ирээд, хүчээ харуулсан. Чуулган хүчээр үйлчлэхдээ л ялдаг бөгөөд тэр цагт чуулганыг тамын үүд дийлэхгүй.

ТА АРИУН СҮНСНИЙ БАПТИСМЫГ ХҮЛЭЭН АВНА ГЭДЭГ ҮГИЙГ БҮРЭН утгаар нь барьж авахдаа, өөр хүн болно. Та Диаволын бат цайзуудыг бөмбөгдөж хаях Загалмайн Үгийн цөмлөлттэй нэгдэх цэргүүдтэй хамт жагсана. Энэ нь Бурханы жагсаж яваа, үл үзэгдэх цэргүүдийн бөмбөрийн нижигнээн дорх цахилгаан юм. Бурхан намайг Сүнсээрээ дүүргэж, хэлээр яриулахдаа, тэнгэр газар дээрх бүх хүч Есүст буй гэдгийг зарлан тунхаглах бүрээн дууг сонсох чихийг минь нээсэн юм. Ёстой мундаг бэлэг!

ХРИСТИЙН АНХНЫ ЧУУЛГАН

Христийн анхны чуулган чимээгүй юмуу сул цугларалт бус, чанга хүмүүс байсан юм. Тэнд эш үзүүлэл, номлол, аврал, баптисм байсан. Тэнд хүчирхэг замаар хөдөлж эхэлсэн Бурханы Сүнс түүнээс хойш нэг ч зогссонгүй.

АРИУН СҮНСНИЙ ТАЛААР ЯРИХЫН ТУЛД ЭХЛЭЭД БИД ТҮҮНИЙГ ПЕНТЕКОСТЫН ХҮЧ байсныг тодорхойлох ёстой. Тэрбээр Христийн чуулганыг эхлүүлсэн. Энэ явдал хэзээ, хаана болсныг бид тодорхойлох ёстой. Энэ явдал нь МЭ 29 онд Христийг цовдлуулснаас 50 хоногийн дараа Пентекост нэртэй Иүдөйчүүдийн баяр наадмын өдөр болсон юм. Тэр өглөө Бурханы Сүнс дэлхий дээр аядуу зөөлөн сийлгүй, харин хуй салхи, хүчит шуурга шиг л буусан (Үйлс 2:1-4). Тэрбээр айлчлан ирснээ 120 дагалдагчаа хэлээр яриулсан

гайхамшгаараа зарлан тунхагласан юм. Энэхүү нүсэр тэсэлгээ нь Христийн анхны чуулганы хүмүүсийг хуран цуглуулжээ.

ТУУШТАЙ БАЙДАЛ

Ариун Сүнснийг Чуулганаас салгана гэж байхгүй. Ариун Сүнс оридог бөгөөд оршихоор ч ирсэн юм. Энэ бол Түүний ажил - даалгавар! Тэр ертөнцийн хязгаарт ч бидэнтэй хамт байна (Үйлс 1:8). Тэр биднийг хүчирхэгжүүлэхээр, урамшуулахаар, хөтлөхөөр бидэнтэй хамт байна. Энэ нь бидний хүнсний дэлгүүр ордогтой адилгүй юм. Бид Ариун Сүнснээс жаахан хүртээд, тэр нь гялс дуусчихдаг учраас, бид дахиад л хомсдолд ороод байдаггүй. Ариун Сүнс цаг үргэлж дүүрэн байдаг.

ДАГАЛДАГЧ НАР АРИУН СҮНСЭЭР ДАХИН ДҮҮРЭХ ГЭЖ ДАХИЖ ДЭЭД ӨРӨӨ РҮҮ ГҮЙГЭЭГҮЙ ЮМ ШҮҮ. Есүс дагалдагч нартаа удахгүй явах боловч, хэзээ ч тэднийг орхихгүй Тайтгаруулагчийг илгээхээ амласан. Есүс явах ёстой байсан. Харин Ариун Сүнс хэзээ ч явахгүй. Тууштай байдал нь Сүнсний амин чанар юм. Сүнс бидний дотор ОРШИН СУУДАГ. 1Иохан 2:27 дээр тосолгоо “орших” талаар өгүүлдэг. “Орших” (Грекээр мено) гэдэг үг нь Иоханы хайртай үгсийн нэг юм. Шинэ гэрээ энэ үгийг 120 удаа хэрэглэсэн байдгийн 63 удаад нь Иохан Сайн мэдээнд хэрэглэж, 25 удаад нь тэрбээр Захидал номууддаа хэрэглэжээ. Иохан Бурханы ерөөл, хүч, тосолгоо одоо ч үргэлжилсээр буйг маш олон арга замаар илэрхийлсэн байдгийн нэг нь л энэ үг юм шүү. Иохан Бурханы үйл ажиллагаа, оролцоо дуусгавар болсон, өнгөрсөн гэх утга бүхий үгсээс аль болох зайлсхийж, харин Бурханы үйлс үргэлжилсээр буйг цаг ямагт илэрхийлдэг.

ТЭНЭМЭЛ

Христгүйгээр Ариун Сүнс тэнэмэл болно. Тэрбээр яг л Ноагийн үеийн хөвөгч авдраас өөр сууж амрах газаргүй тагтаа шиг байна. Бурханы Сүнсгүйгээр Чуулган зүгээр л бунхан болно. Харин Ариун Сүнс байвал, чуулган хүчирхэг цайз болно. Тэр цагт л бид эзлэгдэхгүй, харин эзэлдэг болно.

ЕСҮС “ҮНЭГЭНД НҮХ, ТЭНГЭРИЙН ШУВУУДАД ҮҮР БАЙДАГ Ч Хүний Хүүд толгой хоргодох газар ч үгүй” (Матай 8:20) хэмээн хариулсан байдаг. Есүс газар дээр байхдаа, үүрэг хүлээсэн хүн байсан учраас, гэр орон гэх газаргүй байв. Гэхдээ Есүс Ариун Сүнсээрээ дамжуулан бидэнтэй хамт амьдрахаар ирдэг (Иохан 14:23). Хүсэлтэй зүрх, оюун санаа нь Бурханд зорилгоо биелүүлэх тайзыг засч өгөхөөр барахгүй, газарт Ариун Сүнсийг орон гэрээр хангаж өгдөг. Бурхан таны амьдралд орон гэрээ байгуулахыг хүсдэг. Таны амьдрал ч Тэнгэрийн орон шиг байх учиртай (Матай 6:9-13). Бурхан таны амьдралыг тайвшрал, баяр, энх тайван, аз жаргалын газар байлгахыг хүсдэг.

ӨӨРЧЛӨГДӨШГҮЙ ӨӨРЧЛӨЛТ

“Эрдэм номгүй, юм сураагүй Петр, Иохан хоёрын зоригтой байгааг тэд хараад гайхацгаан, Есүстэй хамт байсныг нь мэдэв.”

Үйлс 4:13

ГАЛТАЙ ЭРЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮД

Абрахам, Мосе, Иошуа, Дебора, Елиа, Елиша - тэдний нэрс эмээлт, бишрэлийг төрүүлдэг ч, бид ч тэдэн шиг галтай хүмүүс (Иаков 5:17). Тэдний дээр байсан Сүнс бидний ч дотор бий. Бид хоёрдугаар зэргийн Сүнсийг юмуу үйл явдлыг хүлээж аваагүй бөгөөд хоёрдугаар зэргийн үр дүнг ч хүлээх ёсгүй.

СҮНС ДОТОРХ БАПТИСМ НЬ ИТГЭГЧ ХҮМҮҮСИЙГ ЭШ ҮЗҮҮЛЭГЧ НАРЫН Сүнсээр дүүргэдэг. Эш үзүүлэгч нар Бурханыг ер бусаар үзэхэд, үүнийг нь эш үзүүлэгч нарын Сүнс гэжээ. Эш үзүүлэгч нарын тэр Сүнс бүх махан бие дээр цутгахыг Иоел 2:28 дээр амласан. Энд тэнд ганц хоёр хүн эш үзүүлэх бус, харин янз бүрийн хүмүүс эш үзүүлэх болно. Үүнээс гадна энэ цутгал нь ганц удаагийн даалгаврын төлөө өгөгдөх бус, харин Христийн дотор хүн бүрт хандсан байнгын бэлэг болох юм. Үйлс номд дүрсэлснээр Пентекост өдөр “тэдний сууж байсан айлыг хүчтэй исгэрэх шуурга мэт дуу чимээ дүүргэж, тэнд байсан хүн нэг бүр дээр галан хэлүүд бууж ирсэн” гэдэг. Тэд бүгдээрээ “Бурханы гайхамшигт үйлсийн” талаар шинэ хэлээр ярьцгаав. Иоел хөгшин, залуугүй эш үзүүлнэ хэмээн зөгнөсөн бөгөөд Петр “Үүнийг эш үзүүлэгч Иоел зөгнөсөн юм шүү” хэмээн мэдэгджээ. Петр шинэ хэлийг эш үзүүлэл мөн гэжээ (Үйлс 2:15-17). Эш үзүүлэл нь Бурханы хүчээр үйлдэгддэг үг хэл бөгөөд эцсийн өдрүүдэд аж төрж буй бидэн үүний биеллийг үзэж, Хуучин гэрээний эш үзүүлэгч нарын Сүнсээр дүүрч байна.

ӨӨРЧЛӨГЧ ХҮЧ

Ариун Сүнсний өөрчлөгч хүч нь маргашгүй. Загасчид, харц ардууд аугаа элч нар болсон. Шийдэмгий бус, мөхөс хүмүүс нөлөө бүхий, хүчирхэг хүмүүс болсон. Тэд Бурханы хаанчлалын сэлэмний ир, жадны үзүүр болж, дэлхийн харанхуйг Сайн мэдээний галаар галдсан билээ.

ТА ҮҮНИЙГ “БИЕЛЭШГҮЙ” Ч БИШ, БҮР “БҮТЭШГҮЙ” ДААЛГАВАР ГЭЖ БОДОХ БАЙХ. Хэдэн загасчин дэлхийг өөрчлөх даалгавар хүлээн авчээ. Гэтэл гийгүүлэх юмгүй, бараг хэн ч биш тэдгээр хүмүүст нэгэн цоо шинэ нууц өгөгдөв. Бурхан Өөрөө гайхамшиг, тэмдгээр дамжуулан тэдэнтэй хамтран ажиллажээ. Түүгээр ч барахгүй, Бурхан тэдний болхи үгсийг ятгалгаар бэхжүүлж, тэдгээр үгсээр сонсогч нарын зүрхийг Голиатыг ниргэсэн Давидын чулуу мэт мэргэн бөгөөд хүчтэй онодог. Бурхан өөрийн гэсэн ямар ч карисмагүй тэднийг Ариун Сүнсний карисмагаар дүүргэв. Тэдний “нууц” нь маш энгийн зүйл буюу Ариун Сүнс байлаа.

ХАМГИЙН ШИЛДЭГТ Ч, ХАМГИЙН ДОРДОД Ч

Ариун Сүнс хэдийгээр хамгийн хүчтэй юмуу чадвартай хүмүүсийг тоолгүй өнгөрдөггүй ч, тэднийг сонгодоггүй. Бурханы гол зорилго бол сул дорой, дутуу гачуу хүмүүст хүч өгөх. Тэдний сул дорой байдал нь Бурханы хүч, бүхнийг хангах хангамж, амь хайрлагч эрч хүчийг татдаг. Бурхан Хүүгээрээ Амлалтаа илгээхдээ, хамгийн шилдэг хүний төлөө ч, хамгийн дорд хүний төлөө ч ирдэг. Элч Петрийн түүхийг л үз.

ЕСҮСИЙГ БАРИВЧЛАГДСАН ТЭР ШӨНӨ ПЕТР ГАЛЫН ДЭРГЭД ЕСҮСИЙГ ГУРВАНТАА НЯЦААСАН (Марк 14:66-72). Өөрийг нь хэн болох талаар шалгаасан асуулт Петрт сум шиг тусч, тэрбээр алингаа алдахдаа Эзэн Есүсийгээ таньж мэдэхгүй хэмээн гүрийжээ. Есүс түүн рүү чимээгүй харахад, Петрийн дотор гэмшил сад тавив. Гэтэл Пентекост өдөр түүнд юу тохиолдсоныг үз. Тэрбээр Хурганы Элч нарын төлөөлөгч болж, тэр өдөртөө 3,000 хүнийг Эзэн рүү хөтөлсөн билээ (Үйлс 2). Бурхан аргаа ядсан, хөөрхийлөлтэй хүмүүст ийм л хүчийг хайрладаг.

БЭЛЭГТЭЙ ЧУУЛГАН

“Бэлгүүд нь ялгаатай ч Сүнс нь ижил. Үйлчлэлүүд нь ялгаатай ч Эзэн нь адил. Үйлдлүүд нь ялгаатай ч бүгдийн дотор бүхнийг үйлдэгч нь мөнөөх л Бурхан юм. Нийтийн тусын тулд Сүнсний илрэлийг хүн тусбүрд өгсөн аж. Бие нь нэг атлаа олон эрхтэнтэй байдагчлан биеийн бүх эрхтэн хэдийгээр олон боловч нэг бие болдог. Христ ч мөн тийм билээ. Эдүгээ та нар Христийн бие бөгөөд тус тусдаа эрхтнүүд нь юм.”

1Коринт 12:4-7, 12, 27

ШАТАЖ БҮЙ БУТ

Шатаж буй бут нь эцэсгүй, хуурай цөлд ч хүчээр дүүрэн, гайхамшигтай үзэгдэл бөгөөд итгэл найдвар авчирдаг. Бурхан чуулгануудыг Өөрийнхөө дуу хоолойг өргөх, шатаж буй бут байлгахаар төлөвлөжээ. Шатаж буй бутыг харахдаа чуулганы хүмүүс Бурханы дуу хоолойг сонсож, чих тавина. Тэгвэл бидэнд шатаж буй бут сөөг биш, харин шатаж буй ой модод хэрэгтэй байна.

БИД БОЛ БУРХАНЫ АЛДРААР БӨГӨӨД АРИУН СҮНСНИЙ ГАЛААР ШАТДАГ БУТНУУД болохоос биш, шатаж чаддаггүй, өгөршсөн, өмхий, хүйтэн нойтон, шавар шавхайтай, хэнд ч хэрэггүй намаг биш ээ. Мөсө шатаж буй буттай таарахдаа, амьдрал нь орвонгоороо эргэсэн. Тэр зорилгогүй, найдваргүй, тэнэмэл хүн Бурханаас амьдрал, хувь тавиланг нь болоод ард түмнийг нь өөрчилсөн Тэнгэрлэг зорилго хүлээн авчээ. Хуулиас зугтаж явсан оргодол маань хоригдлуудыг чөлөөлөхийн төлөө зөвтгөлийн зэвсгийг бариад эргээд очих хүчтэй болжээ. Бурхан чуулгануудыг хаягдсан, найдваргүй, мартагдсан, гологдсон хүмүүст Өөрийнх нь дуу хоолойг хүргэж, тэдэнд зорилго, амьдрах шалтгаан хайрлах шатаж буй бут байлгахыг хүсдэг.

ЗАЛБИРЛЫН ХҮЧИТ ӨРГӨӨ

Нууц залбирал нь нууц хүч болой. Залбирлын өрөө нь Сүнсний хүчний бааз юм. Гэхдээ Бурхан үүнээс илүүг хүсдэг. Бурхан “Миний гэр бүх ард түмний залбирлын гэр” байлгах хүсэлтэй (Исаиа 56:7). Залбирал бүх үндэстэн рүү түрж, газарт эдгэрлийн ус халих болтугай.

ЕСҮС “ЧИ ЗАЛБИРАХДАА ӨРӨӨНДӨӨ ОРЖ, ҮҮДЭЭ ХААГААД, нууц оршигч Эцэгтээ залбир” (Матай 6:6) гэдэг. Залбирлын өрөөнийхөө

үүдийг хаа - тэгвэл тэнгэрийн үүд нээгдэнэ. Дагалдагч нарыг Дээд өрөөнд байхад, алдрын цонх нээгдэж, Ариун Сүнс тэдэн дээр бороо шиг цутгажээ (Үйлс 2). Залбирал Диаволыг зогсоодог учраас, Диавол таны залбирлыг зогсоох гэж үзнэ. Дэлхий даяар чуулганд, их дээд сургуулиудад, тэр бүх хэл албан өрөөнд залбирлын “Дээд өрөөнүүд” бий. Тэдгээр нь голдуу Сүнсээр дүүрэн, Сайн мэдээ, Христэд итгэдэг хүмүүсээр дүүрэн газрууд байдаг. Залбирлын өрөө нь хүч чадлын өргөө юм. Өнөөдөр “Зогсолтгүй залбир” (1Тесалоник 5:17).

ЧУУЛГАН ЮУ БИШ ВЭ?

Тэмдэг, гайхамшиг, хэлээр ярих юмуу эдгэрлийн бүх үзэгдлээс Бурханы Үгийг номлож, заах нь илүү чухал. Гайхамшиг нь үнэнийг дэмжих л систем юм.

ХҮНДЭТГЭЛИЙН ЦУГЛААНЫ ГОЛ ЗОРИЛГО НЬ Сайн мэдээг дэлгэрүүлэх явдал байх ёстой. Яагаад цуглаанууд гадны хүмүүст нээлттэй байж болдоггүй юм бэ? Ялангуяа Эзэний зоогийн талх, дарсны билэгдлийг хүртэхдээ? Энэ чинь нэн түрүүнд авралыг номлох завшаан шүү дээ. Тэр улаан дарс бүхий аяга тань нүгэлтнүүдэд нүглийг нь ятган ухааруулах, дэлхий дээрх хамгийн том номлогч шүү дээ. Энэ чинь аягатай Сайн мэдээ шүү дээ - алдагдсан нүгэлтнүүдийг Загалмайн тахилыг хүлээн авахад урих боломж. Зөвхөн цэвэр цэмцгэр хүмүүс л оргилуур руу ирэх ёстой юм уу?

СҮНСНИЙ БЭЛЭГ НЬ ГАГЦХҮҮ ТҮҮНИЙ ЗОРИЛГЫН ТӨЛӨӨ ОРШДОГ

Сүнсний бэлэг нь бидэнд эрх хүчээр наадахын төлөө өгөгддөггүй. Бурханы хүч нь биднийг бидний бус, Түүний зорилгын төлөө хэлбэршүүлдэг. “Таны хүслийн улмаас Тэдгээр нь тогтоогдсон

бөгөөд бүтээгдсэн юм” (Илчлэл 4:11). Бурханы мөнхийн Хаанчлалыг байгуулах үйлсэд туслахаар дуудагдах нь юутай хүндэтгэл, завшаан бэ! Бидний мөнх бус гар газар дээр Бурханы мөнхийн Хаанчлалыг байгуулж чадна! Үүнээс илүү юу ч үгүй.

ХААНЧЛАЛ ДОТОРХ БАЙР СУУРЬ, ХҮЧНИЙ ТӨЛӨӨХ ХҮСЭЛ НЬ ЧУУЛГАНЫ ЭХЛЭЛЭЭС Л ХАРАГДДАГ. 12 дагалдагчийн нэг - Иаков, Иохан хоёр Есүсээс: “Та сүр жавхландаа бидний нэгийг баруун гар талдаа, нөгөөг нь зүүн талдаа суухыг болгоогооч” (Марк 10:37) гэж гүйсан. Гэтэл Есүс: “Миний уух аяганаас та нар ууж, Миний хүртэж байгаа баптисмыг та нар хүртэх болно” (Марк 10:39-40) хэмээн аядуу хэр нь хатуу үгээр хариулжээ. Түүхийг үзбэл, эрх хүч, улс төрийн зөрчил, овог аймгуудын тэмцэл хэзээд л байсаар иржээ. Итгэгч нар ч дутаагүй - Чуулган дотор байр суурийн төлөө үзэлцэж, өөрийнхөө хаанчлал, өөрийнхөө санаархлыг биелүүлэхийн төлөө үлайрсаар ирсэн. Гэхдээ эцсийн эцэст Бурханы зорилго гэдэг ганц л зүйл орших болно. Тиймээс та бид хоёр Бурханы хаанчлалыг байгуулахын төлөө өөрийгөө, авьяас чадвараа, амиа хичээх байдлаа өргөж чадна гэдэгт гүнээ найднам. Эцсийн эцэст бид чинь “сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл” (Ефес 2:10) шүү дээ.

АРИУН СҮНС БОЛ ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ

Ариун Сүнс дотор яг адилхан ажилладаг хоёр хүн үгүй. Хоёр адилхан чуулган ч үгүй. Эв нэгдэл гэдэг нь ижил, нэг байна гэдэг нь адил гэсэн үг биш.

ЯЛГААТАЙ БАЙХ НЬ НҮГЭЛ БИШ. 1Коринт 12:7 дээрх “Нийтийн тусын тулд” гэдэг үг нь “симферон” гэдэг Грек үг бөгөөд үүнээс Англи хэлний “симфони” гэдэг үг үүсчээ. Ариун Сүнс хөгжмийн зохиолч бөгөөд Өөрийнхөө ажлыг удирдаж, олон янзын зэмсэг, сэдвээс аялгуу бүтээдэг. Тэрбээр бүгдийг яг адилхан өнгөөр тоглоосой гэж хүсдэггүй. “Бэлгүүд нь ялгаатай ч Сүнс нь ижил. Үйлчлэлүүд нь ялгаатай ч Эзэн нь адил. Үйлдлүүд нь ялгаатай ч бүгдийн дотор бүхнийг үйлдэгч нь мөнөөх л Бурхан юм” (1Коринт 12:4-6).

АРИУН СҮНСЭЭР ХҮЧИРХЭГЖСЭН

“Учир нь та нарын дунд би Есүс Христ буюу цовдлогдсон Түүнээс өөр юу ч мэдэхгүй байхаар шийдсэн юм. Мөхөсдөл, айдас, үлэмж чичрэл дор би та нартай хамт байсан. Үг минь ч, тунхаглал минь ч мэргэн ухааны ятгалгын үгээр бус, харин Сүнс ба хүчний илрэлээр байсан нь итгэл чинь хүмүүний мэргэн ухаанд бус, харин Бурханы хүчинд байхын тулд байлаа.”

1Коринт 2:2-5

ГАЛААР ДҮҮРЭН

Христэд итгэх итгэл нь хэзээ ч дэлхийтэй, махан биетэй, Диаволтай өөрийнхөө төрөлх эх үүсвэрээр юмуу мэдлэгээр дайтахаар дуудагдаагүй. Эхний зууныхан ч тэр, 21-ээр зууныхан ч тэр. Сайн мэдээ нь “Бурханы хүч” (Ром 1:16) болой. Ариун Сүнс бидэнд хэрэгтэй хүчийг маань өгдөг. Гэхдээ хэрэв бид Түүнийг ойшоохгүй бол, Тэр өгөхгүй.

ӨНӨӨДӨР ХИЧНЭЭН НОМЛОГЧ ЯГ Л ДӨНГӨЖ ДЭЭД ӨРӨӨНӨӨС БУУЖ ИРСЭН ХҮН ШИГ НОМЛОДОГ БИЛЭЭ? Хичнээн нь Сайн мэдээг яг л Бурханы хүчээр гэмээр номлодог билээ? Номлогч нар чуулгандаа ихэвчлэн эмч шиг нэг л тийм - галгүй номлодог бөгөөд Ариун Сүнсэнд хөдлөх ямар ч боломж олгодоггүй. Ариун Сүнсний тосолгоогүйгээр Христийн даалгаврыг биелүүлэхгүй. “Сүнсээр дүүр!” (Ефес 5:18) гэсэн зааврыг бидэнд өгөөгүй гэж үү? Зорилгоор жолоодуулах нь үүний нэг хэсэг боловч, Сүнсээр жолоодуулах нь чухам Шинэ гэрээний үлгэр загвар болой. Ариун Сүнс л хөдөлгүүр бөгөөд хөдөлгөдөг хүч мөн.

“ТЭД ҮРГЭЛЖЛҮҮЛСЭН”

Шинэ гэрээний нөхцлийг хүсч байвал, бид Шинэ гэрээний үлгэр загварыг мэдэх хэрэгтэй. Тэгж байж л юу хүсэн хүлээхээ мэднэ. Хэрэв бид элч нарын хийснийг л хийгээд байвал, элч нарын хүрсэнд л хүрнэ. Хэрэв бид анхны Сайн мэдээг номнобол, анхны үр дүнд л хүрнэ.

“ТЭД, ЭЛЧ НАРЫН СУРГААЛД МӨН НӨХӨРЛӨЛД, ТАЛХ ХУВААЛТ, ЗАЛБИРАЛД ӨӨРСДИЙГӨӨ ЗОРИУЛДАГ БАЙЛАА. Хүн бүрд айдас байлаа. Учир нь элч нараар [Иерусалимд] олон гайхамшиг, тэмдэг үйлдэгдэж байв. ...Бурханыг магтаж, хамаг ардын хайр хүндэтгэлийг олж байв. Эзэн, аврагдагсдыг тэдэн дээр өдрөөс

өдөрт нэмэгдүүлж байлаа (Үйлс 2:42, 43, 47). Хүмүүс: “Эзэн минь, дахиад хийгээч” гэж залбирдаг. Гэхдээ бид анхны Чуулганы Христэд итгэдэг хүмүүсийн хийж байсныг л үргэлжлүүлэн хийх ёстой юм: Тэд гэрчлэхээ зогсоогоогүй (Үйлс 5:42). Тэд яг л хамаг амь амьдрал тэднээс шалтгаалж байгаа юм шиг номлож, гэрчилж, ажилладаг байсан атлаа яг л хамаг амь амьдрал Бурханаас шалтгаалж байгаа юм шиг залбирдаг байв. Тэд Бурханд найдаж, Бурхан тэдэнд найдаж байсан. Тэгвэл тэр л Бурхан үүний үргэлжлэлийг та бид хоёрт даатгаж, номлохдоо, заахдаа, гэрчлэхдээ итгэмжтэй байгаарай хэмээн найдаж байна.

ХЯЗГААРГҮЙ ЕСҮС ХЯЗГААРГҮЙ ГАЙХАМШИГ

Баталгааны өмнө мэдэгдэл ордог. Хязгаартай Есүсийг номлоод байвал, Есүс Өөрөө Өөрөөрөө байж чадахгүй. Та Аврагчийг номлохгүй бол, Тэр яаж аврах билээ? Та Эдгээгчийг номлохгүй бол, Тэр яаж эдгээх билээ? Та Ерөөгчийг номлохгүй бол, Тэр яаж ерөөх билээ? Бурханы Үгийг Ариун Сүнс баталдаг (Марк 16:20). Тэр бидний хувийн зан чанар, аминч байдлыг батлахгүй.

АРИУН СҮНС ТАНЫ ЕСҮСИЙН ТАЛААР ХЭЛСЭН ЗҮЙЛИЙГ Л ЕРӨӨНӨ. Таны Есүсийн талаар хэлээгүй зүйлийг Сүнс ерөөж чадахгүй. Хэрэв одоо “тэр л Есүсийг - Паулын номлодог тэр л Есүсийг” номлобол, Бурханы Сүнс үүнийг бататгана (Үйлс 1:11, 19:13). Хичнээн хүн бидний нандин Эзэнийг нүцгэлсэн ялтай билээ? Нэгэнтээ хүмүүс Түүнийг цовдлох гэж нүцгэлсэн бол, үл итгэл Түүнийг хүчээс нь нүцгэлдэг. Олон чуулганы хувьд Тэрбээр одоо эдгээж, аврах хүчгүй болжээ. Паулын хэлснээр бид Түүнийг амьдралдаа хашихдаа, өөрсдөө хүйтэн, үл итгэл “...дотроо хашигдсан” (2Коринт 6:12) ажээ. Марк 16:20 дээр ч “Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн хамт ажиллаж, дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байлаа” (Марк 16:20) гэдэг. Тэд номлосон, харин Эзэн баталсан. Баталгааны өмнө мэдэгдэл ордог.

ТҮҮНИЙ ХАМТ БАЙГЧ ОРШИХУЙ

“Туштай бөгөөд зоригтой бай! Чамтай хамт явдаг
Нэгэн бол Бурхан ЭЗЭН чинь юм. Тэр чамайг орхихгүй
мөн чамайг хаяхгүй учраас тэднээс бүү айж эмээ, бүү
балмагдан цоч!”

Дэд хууль 31:6

“БИДЭНТЭЙ ХАМТ БАЙХ ИММАНУЕЛ БУРХАН”

Бурхан бидэнтэй нэг хамт байгаад л, нэг алга болоод л байдаггүй. Шинэ гэрээн дээр ийм үг үсэг байхгүй. Харин ч Бурханы хэзээ ч хөсөрдөшгүй оршихуйн талаар л байнга ярьдаг. Тэр бүү хэл Бурханы нэг нэр нь “Иавэ Шаммах” буюу Бурхан тэнд хамт байна (Езекиел 48:35) юм. Бурхан бидэнтэй хамт бөгөөд хэзээд хамт байсаар ирсэн.

ЕСҮСИЙН ТӨРӨЛТИЙГ ЭШ ҮЗҮҮЛЭХДЭЭ, БИБЛИ “Бидэнтэй хамт байх Иммануел Бурхан” (Матай 1:23) гэдэг. Тэнгэрлэг оршихуйн талаар Бичээс маш олон тодорхой баталгаа өгсөн. “Үхлийн харанхуйн хөндийг түүлсан ч Хор муугаас би үл айна. Та надтай хамт агаад” (Дуулал 23:4). “Учир нь ЭЗЭН аугаа нэрийнхээ төлөө Өөрийн ард түмнийг хөсөр хаяхгүй” (1Самуел 12:22). Эзэн Мосед “Би лавтай яа чамтай хамт байна” гэсэн бол, Иошуад “Би Мосетэй хамт байсан шигээ чамтай ч хамт байна” (Гэтлэл 3:12, Иошуа 1:5) гэсэн. Дуулал 146:6 дээр “Тэрбээр мөнхөд итгэмжтэй үлдэнэ” гэдэг. Эзэн бидэнд итгэмжтэй.

БУРХАНТАЙ НӨХӨРЛӨХ

Бид бол Бүтээгчтэйгээ бөгөөд тэнгэр, газрын бүтээгч Эзэнтэйгээ хувийн, дотно харилцаа тогтоох боломжоор хангагдсан, онцгой хүмүүс. Бид Ариун Сүнсээр дамжуулан Аавтай бөгөөд Түүний Хүү Есүс Христтэй нөхөрлөдөг. Энэ нь Христэд итгэх итгэлийн ерөөл юм. Өөр ямар ч бурхан шүтээн ийм ойр дотно харилцааг санал болгоогүй. Бид үнэхээр хайрлагджээ!

ЕСҮС БИДЭНТЭЙ ҮРГЭЛЖИД ХАМТ ГЭЖ АМЛАСАН! Тэр ямар гээчийн хүн бэ? Түүний оршихуй нь нөхөрлөл юм. Теологичид

“Тэнгэрлэг эрхшээл” гэдэг үгийг хэрэглэдэг. Гэхдээ Есүс үүнийг амлаагүй юм. “Эрхшээл” гэдэг нь Бурхан дэлхийг дүүргэх гэсэн утгатай. Уур амьсгал гаригийг дүүргэдэг. Тэгвэл Бурхан уур амьсгал биш. Библи Бурхантай нөхөрлөх талаар өгүүлдэг. Уур амьсгалтай нөхөрлөнө гэж юу байхав. Христэд итгэдэг хүмүүс Эзэний зоог барьдаг. Үүгээрээ тэд Бурханы амийн хуваалцагч нар болдог. Энэ бол Бүтээгч - бүтээл хоёрын хоорондын маш гайхамшигтай, хувийн дотносол юм. Энэ бол тэнгэр, газрын Эзэний онцгой чанар болой. Бурханаас өөр хэн ч ингэж чадахгүй, ингэх ч боломжгүй. Энэ бол гагцхүү Бурханы онцгой содон зүйл билээ. Тэр хүн бүрт ойрхон байна (Еврей 13:5).

“БИ ТЭНД БУЙ”

Бурхан хамт байна гэсэн нь ерөнхийдөө нийтийн дунд чинь “бөөндсөн” маягаар хамт байна гэсэн үг биш юм. Бурхан яг хүн бүртэй хувьчлан хамт байдаг. Түүнээс гадна Бурхан хүн бүрт зориулагдаж, хэдэн хэсэг болж хуваагддаггүй. Бид аль хэр чухал хүн, чухал бус хүнээс шалтгаалж Тэр бидэнтэй хамт байдаг юм биш. Тэр бидний хүн нэг бүртэй бүрэн хамт байдаг шигээ, нийт цуглаантай ч хамт байдаг. Бид эрийнхээ сайнд Түүний оршихуйг татаж, зохицуулдаг юм биш. Тэр хэдийнээ бидэнтэй хамт буй “БИ БАЙНА” билээ.

ХРИСТ “ХОЁР БУЮУ ГУРВУУЛАА МИНИЙ НЭРЭЭР ХААНА ЦУГЛАНА, ТЭНД БИ ТЭДНИЙ ДУНД БАЙНА” (Матай 18:20) хэмээн амласан. Тэр “Би ирнэ” гэж хэлээгүй, харин хэдийнээ “Би байна” гэжээ. Тэрбээр бидний цугларалтад хэрхэн хандаж байгаа нь бидний Бурханы нэгэн сүр жавхлантай нууцын хэлтэрхий гэлтэй. Бид хоорондоо уулзсанаараа Түүний оршихуйг урин залдаг юм биш. Бид тэнд байгаа учраас, Тэр ирдэг юм биш. Тэр угаасаа байгаа учраас, БИД ирдэг юм. “Түүний дотор хүмүүс цуглах болно” (Эхлэл 49:10). “Хоёр, гурав” гэдэг нь Түүний нэрээр уулзалдаж буй хоёр юмуу гурван итгэгч хүн юм. Энэ нь гэр бүлийн гишүүд ч байж болох - эхнэр, нөхөр хоёр ч байж болох. Эзэн маань гэр бүлд маш их

санаа тавьдаг. Гэр бүлийн зовнил - Түүний зовнил байдаг. Христ бидэнд ирэхдээ Мариа, Иосеф хоёрын гэр бүлд хүү нь болж ирсэн билээ.

БҮРЭН ТЭНД

Бурхан бидний дотор хэсэгчлэн бус, харин бүрэн эхээрээ байдаг. Бурханы Сүнс гарч явдаггүй, замаа буруулдаггүй, ууршидаггүй, сарнидаггүй, гоождоод дуусдаггүй. Тэр суурьшидаг (1Иохан 4:15). Бурхан бидэнтэй хааяа хамт байна гээгүй, харин ямагт хамт байна хэмээн гэрээ байгуулсан.

БУРХАНЫ СҮНС БҮТЭН САЙНД Л ГАНЦ ЦУГЛААНДАА ИРЖ, БАРААГАА ХАРУУЛДАГ ХҮМҮҮС ШИГ БИШ. Тэр биднийг Түүний айлчлалд зохистой дүү хөгжмөөр бэлтгэтэл, харзнаж хүлээдэггүй. Бид Бурханыг хүрээд ирээч гэж залбирах хэрэггүй. Учир нь Бурхан ЯМАГТ ТЭНД байж л байна! Бурхан авран сэргээх ажлаа нэг харахад газар байж байснаа, нэг мэдэхэд тэнгэрт оччихдог Эмпайр Стэйт Биилдингийн лифт шиг нэг дээшээ, нэг доошоо савалздаг бидний сэтгэл мэдрэмж дээр түшиглүүлдэггүй. Бурханы нар хэзээ ч жаргадаггүй. Тэрбээр ямагт үд дунд шиг хэзээд орой дээр мандаж байдаг.

ҮХМЭЛ БИШ, ХАРИН ИДЭВХИТЭЙ ОРШИХУЙ

Эзэний оршихуй ҮХМЭЛ биш, харин идэвхитэй. Тэрбээр бидний төлөө хуруугаа ч хөдөлгөх чадваргүй, сүүдэр шиг гөлийсөн, дүмбэгэр, үлбэгэр, орон гаран нэгэн биш. Бурхан бол яг Нар шиг. Түүний оршихуйгаас бид хаашаа ч зайлахгүй. Түүний хүч, цацраг нь бидний амьдралыг оршин тогтноулдаг билээ.

БҮРХАНЫ СҮНС ТАН ДЭЭР ИРЭХЭД, танаас алдраас алдарт хүрэн, зогсоо зайгүй өөрчлөгдөх амьдралын нотолгоо харагдана (2Коринт 3:18). Таны амьдрал бахь байдгаараа үлдэх боломжгүй. Энэ нь Бурханы мөн чанартай зөрчилдөнө. Салхины Эзэн шуургыг намжаана. Амар тайвны Ханхүү амьдралд тань амар тайвныг авчирна. Биеийг тань эдгээж, гарын тань үйлсийг бат тогтоож, хэвлийн тань үр жимсийг ерөөж, таныг амьд гэрч болгон өөрчилнө. Бурханы оршихуй танигддаг бөгөөд маш тодорхой нөлөөтэй байдаг. Эзэн “Би та нартай лавтайяа хамт байна” гэсэн бөгөөд Есүс ч “Үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байна” гэсэн (Эхлэл 3:12, Матай 28:20). Есүс амлалтаа биелүүлсэн. “Тэд явж, ГАЗАР САЙГҮЙ тунхаглажээ. Эзэн хамт ажиллаж, дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байлаа” (Марк 16:20).

ГАЛТ ЗАРЧИМ

ХЭСЭГ 8:

ГАЛЛАСАН - АРИУН
СҮНСНИЙ БЭРХШЭЭЛ

ЭНЭ БОЛ ТАНЫ ЦАГ

“Учир нь уг амлалт та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад байх бүгдийнх бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ гэв.”

Үйлс 2:39

ЭЦСИЙН ҮЕИЙН ЧУУЛГАНЫ ҮЙЛС

Ариун Сүнс Үйлс 28-аар бүлгээр унтарчихаагүй билээ. Пентекост өдрөөс хойш хэдийнээ 2,000 хол илүү жил өнгөрчээ. Элч нарын үйлсийг өнөөдөр бид залгамжлан авч явж байна. Үүнийг Анхны Чуулганыхан залгамжлан хүлээн авсан бөгөөд эдүгээ Эцсийн үеийн Чуулганы Үйлс ном өрнөж байна. Үйлс ном нь өчүүхэн юмсын талаар дүрслэн өгүүлэхдээ, үнэндээ өнөөгийн бидэнд зориулан суурь тавьжээ.

“ПЕНТЕКОСТ ӨДРҮҮД” ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА. Пентекост өдрөөс хойш Ариун Сүнс хүчит шуурга мэт дэлхий дээгүүр шинэ бөгөөд хүчирхэг замаар дэгдэн, газрын хамгийн харанхуй мухарт ч хүрч байна. Анхны Чуулган болоод элч нар хийх ёстойгоо хийснийг нь Үйлс ном бичиж тэмдэглэсэн. Гэхдээ тэдгээр нь Ариун Сүнсний хийсэн, хийж байгаа, хийх бүхнийг багтаагаагүй юм. Ариун Сүнсний Үйлс дээр эдүгээ энэ үеийн бид нэмэрлэх ёстой.

Сүнсний салхи исгэрч байхад, бид хамтдаа хөдлөх ёстой. Та хаа байсан ч, хичнээн харанхуй байсан ч, яг тэнд чинь Бурханы Сүнс үлээж байгаа гэдэгт итгэх ёстой бөгөөд Үгийг ярих юм бол, наана чинь гэрэл, аврал, чөлөөлөлт, эдгэрэл, гайхамшиг бий болохдоо л бий болно. Тиймээс явсан газар бүрийдээ Үгийг ярьсан шиг ярь. Тэгээд үр дүнг нь харна. Учир нь Сүнсний салхи хэдийнээ танаас түрүүлээд үлээж явна.

АМТАЛГАА

Бидний даган дууриах ёстой үлгэр жишээ нь Анхны итгэгч нар биш, харин Есүс юм! Үйлс ном нь Бурханы хүчийг бүрэн эхээр нь өгүүлдэг ном биш, харин Ариун Сүнсний хүчин чадлын амталгаа төдий л ном юм. Бурханд хязгааргүй итгэ! Түүнд хязгаар үгүй!

АРИУН СҮНСНИЙ ИРЭЛТ, АНХНЫ ЭЛЧ НАРЫН АМЬДРАЛЫН ТҮҮХ БОЛООД чуулганы цэцэглэлийн түүх нь Ариун Сүнсний үйлчлэх чадварын дээж төдий юм. Энэ талбар бидэнд нээлттэй байна. Христ “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно” (Иохан 14:12) гэсэн. Есүс бол бидний үлгэр жишээ. Паул “...зүрхний чинь мэлмийг гийгүүлээсэй! Ингэснээр та нар Түүний дуудлагын найдварыг мөн ариун хүмүүс дэх Түүний өвийн алдрын баялгийг бас итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын яндашгүй аугааг мэдэх болтугай. Энэ нь Түүний хүч чадлынх нь хүчний үйлдэл билээ. Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрлэг оршихуйд баруун гартаа зална” (Ефес 1:18-20) хэмээн залбирчээ.

ӨНӨӨДӨР

Өнөөдөр энэ дэлхийн хамгийн хүнд, хүнд газар хүмүүс бөөн бөөнөөрөө Христэд итгэж байна. Чуулган дотор эдгэрэл, гайхамшиг, тэмдэг өрнөж байна. Анхны Чуулганд Ариун Сүнсний хүчээр өрнөж байсан Бурханы Үгийн үнэнийг өнөөдөр хүмүүс харж байна.

ӨНӨӨДӨР ХҮМҮҮСТ ЭЕРЭГ ҮЙЛ ЯВДАЛ ӨРНӨЖ БАЙНА. Энэ нь “Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ Бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж, Залуус чинь үзэгдэл үзэн, Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно. Эр, эм гэлгүй боолуудынхаа дээр Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана. Тэд эш үзүүлэх болно” (Үйлс 2:17, 18) хэмээн Бичээс дээр Эзэний амласан Библийн тэмдэглэгээ бүрийг батлан харуулж байна. Бурхан хэлсэн Үгдээ хүрч, Есүс Ариун Сүнс дотор баптисм хийж байна. Энэ талаар маргах хэрэггүй. Энэ явдал болж байгаа бөгөөд танд ч тохиож болно.

АВААД Л ОДНО

Бурханы гол хүчтэй! Амьдрал маань Бурханы зорилготой холбогдох үед Бурхан биднийг өнө мөнхийн өнгөрснөөс өнө мөнхийн ирээдүй рүү урсгаад л одно. Үүнийг хийхийг Ариун Сүнсэнд зөвшөөр.

ЭЛЧ ПАУЛ ӨМНӨ НЬ ЗҮГЭЭР Л САУЛ БАЙВ. Тэрбээр тухайн үеийнхээ тэргүүн тахилч, шашны удирдагч нараас Чуулганыг хавчих эрх олгосон захидал хүлээн авчээ. Гэтэл Дамаск хүрэх замд нь Эзэн түүнд үзэгдэв. “Саул аа, Саул аа, юунд чи Намайг хавчина вэ? Хатгуурын өөдөөс өшиглөх нь чамд бэрх байх вий” (Үйлс 26:14). Саул хувь тавилангаа сөрж явжээ. Тэгээд Есүст бууж өгөхдөө, Ариун Сүнсний үрсгалд орж, тэрбум, тэрбум итгэгч хүмүүст нөлөөлсөн Бурханы аугаа элч болсон билээ. Амьдрал чинь нэг л үнэ цэнэгүй байвал, шинэ юм оролдоод үз - Ариун Сүнсний зохиосон амьдралаар амьдраад үз.

ЗУУХАН ДАХЬ ГАЛ

Та өмнө хэн ч байсан байж болох. Гэхдээ Бурхан таныг хүчирхэгээр хэрэглэж чадна. Галтай хүнийг Бурхан хэрэглэнэ. Зүгээр л Түүнд бууж өгөөд, Ариун Сүнсээр хүчирхэгжихийг зөвшөөрөн, залбирч, судлаж, магтаж, үндэстнүүдэд номлобол, та дагалдах тэмдэг, гайхамшигийг үзэхдээ л үзнэ (2Тимот 2:20, 21).

БУРХАН ЯАГААД ЗАРИМЫГ НЬ ХЭРЭГЛЭЭД, ЗАРИМЫГ НЬ ХЭРЭГЛЭДЭГҮЙ ВЭ? Маш энгийн. Танайд хоёр янзын цахилгаан зуух бий. Нэг нь асдаг, нөгөө нь асдаггүй. Аяга халуун кофе уух гэсэн хүн алийг нь хэрэглэх бол? Мэдээж халууныг нь. Одоо ойлгов уу? Яг энэ шалтгаанаар Бурхан заримыг нь хэрэглэдэг, заримыг нь

хэрэглэдэггүй байх нь. Олон хүн: “Эзэн минь, намайг хэрэглээрэй” л гэдэг. Гэхдээ энэ буруу залбирал. Оронд нь: “Эзэн минь, намайг хэрэгтэй байлгасч” гэж залбирвал, зөв болно. Түүний гал л биднийг хэрэгтэй хүн болгоно. Хэрэгтэй хүнийг Бурхан шууд л хэрэглэнэ! Халмелүяа.

ГИЧИЙН ҮР МЭТ ИТГЭЛ

“Та нарын итгэл өчүүхнийх. Үнэнээр Би та нарт хэлье, гичний үр төдийхөн итгэл та нарт байвал энэ ууланд “Эндээс тийшээ нүү” гэж хэлбэл тэр нүүнэ. Та нарт боломжгүй юм гэж үгүй болно.”

Матай 17:20

ИТГЭЛИЙН ЖИГҮҮР

Сүнсний үр жимсний голд хайр, эелдэг зан, өр зөөлөн зан гэх мэт хязгааргүй хүчтэй үр бий. Христэд итгэгч гэдэг нь номхорсон, бүрэг “үүлдэр” биш юм. Бид Бурханыхаа төлөө нөгөө хацраа тавьж өгөөд, хавчлагыг хүлцдэг байж болох ч, дотор маань Ариун Сүнсний үхлээс амилуулдаг, тамыг самардаг, өөрчлөлтийг авчирдаг хүч оршин буй гэдгийг мэдээрэй. Бидэнд уулсыг нүүлгэж, талыг босгох итгэл бий. Бурхантай байхад, боломжгүй зүйл гэж үгүй (Лук 1:37).

ИТГЭЛЭЭР ХЭМЖИЖ БУЙ НӨХЦӨЛД ТОМ, ЖИЖИГ ДААЛГАВАР ГЭЖ ҮГҮЙ. Жигүүртэн шувуунд ч тэр, итгэлийн жигүүртэй хүнд ч тэр - хашаа, байшин, толгод, уулс ямар ч ялгаагүй. Бурханы дуудлагыг гагцхүү итгэлээр л хийх боломжтой. Итгэл дотор алхаж (дүүлж) явахдаа, та Ариун Сүнс дотор цоо шинэ арга замаар амьдарч, алхална.

НОЙРМОГЛОХГҮЙ, ХАРИН ДҮҮЛНЭ

Итгэлээр “Тэд бүргэд мэт жигүүр дээрээ элин халина” (Исаиа 40:31) гэдэг. Нойрмоглохгүй, харин дүүлнэ. Саад мөргөхөөрөө ичээндээ ороод, хамаг амьдралаа нойрмоглоод барав. Харин ч тэдгээрийн дээгүүр итгэлийн далавчаа дэлгэн дүүлж, АРИУН СҮНС ДОТОР ХӨДЛӨӨРЭЙ.

БИД ХАРСНААРАА БУС, ИТГЭСНЭЭРЭЭ АМЬДАРДАГ (2Коринт 5:7). Амьдралын маань зарим юмс махан биеийн мэдэрхүйд аймшигтай санагдаж, мэдрэгдэж, харагдаж болох. Гэхдээ байз! Сөхрөх гэж бүү яар. Бидний итгэл Бурханы Үгд үндэслэдэг. “Надад хүчирхэгжүүлэгч Христээр би бүхнийг хийж чадна” (Филиппой 4:13).

ҮЛ ИТГЭЛИЙН ЦАРДАС ДУНДУУР ЦӨМЛӨЖ ГАРАХ

Та чинь Тэнгэрлэг галын идэвхитэй, амьд галт уул байх ёстой хүн шүү дээ. Та сүр ихтэй атлаа амьгүй, цэвдэг мөсөн уул биш. Галт уулынхаа оройг дэлбэ аваад, доторх Ариун Сүнснийхээ галыг бадраа (Еврей 12:29).

ГАЛТ УУЛ ШИГ ИТГЭЛ НЬ ЭРЭГ ДЭЭР ГАРАХ ЗАМЫГ ХАРСААР, ХАЙСААР БАЙДАГ. Үл итгэлийн цардсыг нэгэнт сэтлээ л бол, хүчирхэг дэлбэрэлт дагалдана. Бурхан үл итгэлийн чинь цардсыг цөмлөх бүрийд, Түүний гайхамшигт хүч үзэгдэж, бүх мэдрэмж, эргэлзээг бут ниргэдэг. Эргэлзээний маань цардас хэр зузаан байна? Бид Бурханд итгэхгүй гэж хэр зэрэг гүрэлзэж байна? Үл итгэлээ хаях юм бол, нууц сувгаар Бурханы Ариун Сүнсний гал биднийг чөлөөлөхөөр нэвтрэн орж ирнэ.

ГУЙЛГАЧИН БИШ, ИТГЭГЧ

Бурхан өгөөмөртөө бас бидэнд хайртайдаа төдийгүй бас бидэнд хэрэгцээтэй учраас л Өөрийнхөө Сүнсийг бидэнд өгдөг юм. Бурхан биднийг Өөрийнхөө ажилд зориулан хүчирхэгжүүлэхийн төлөө Сүнсээрээ дүүргэхийн хүслэн болдог. Бид Түүний ерөөлийг гуйж гувших шаардлагагүй. Бурхан хүсэх нь бүү хэл, бүр бэлэн байж байдаг. Тэр бол хэзээд бэлэн Бурхан! Зүгээр л итгэ - тэгвэл хүлээж авна.

ТЭГВЭЛ “ИЕРУСАЛИМД ҮЛД” (ЛУК 24:49) ГЭСЭН НЬ ЯМАР УЧИРТАЙ ВЭ? Есүс дагалдагч нартаа хүлээхийг захисан нь тухайн үед Есүсийг алдаршуулагдах хүртэл дэлхийд Ариун Сүнс өгөгдөхгүй учраас тэр байв (Иохан 7:39). Тэд Пентекост Өдөр гэдэг түүхэн эгшинг хүлээх ёстой байлаа. ХАРИН ОДОО АРИУН СҮНС ЭНД БАЙНА.

Пентекост нь бодитой явдал бөгөөд та үүнийг долоо хоногийнхоо аль ч өдөр эдэлж чадна. Танд гуйх цуглаан байхгүй, зөвхөн хүлээж авах цуглаан л бий. Есүс бидний амьдралд Үгээ биелүүлэх дуртай. Бид чинь итгэгч болохоос биш, гуйлгачид биш.

ХҮЧ ЧАДЛААР ЮМУУ МЭДРЭМЖЭЭР БУС

“Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Миний
Сүнсээр.”

Зехариа 4:6

ХҮЧ БА МЭДРЭМЖ

Сүнс доторх баптисм нь тогтмол хүчийг авчирдаг ч, тогтмол хүчтэй мэдрэмжийг авчрах албагүй. Золоор бид хүчийг мэдрэмжээр юмуу харж байгаагаараа хэмждэггүй. Сүнслэг хүч нь бидний сүнсэн дэхь далд хүч юм. Гэхдээ нөхцөл байдал биднийг хүчийг хэрэглэхийг шаардах үед сүнслэг хүч гарч ирээд, тэр дорoo шаардлагатай хэм хэмжээгээрээ хангагддаг. Мэдрэмждээ найдах найдлага чинь сүнслэг ялалтыг чинь тоночих вий.

110.000 ВОЛЬТЫГ АГУУЛСАН ТӨМӨР ТОР ГАДНААСАА ТОГТОЙ, ТОГГҮЙ НЬ МЭДЭГДДЭГГҮЙ. Үүнтэй адил бид өөрийнхөө булчингийн хүчийг МЭДРЭМЖЭЭРЭЭ бус, гагцхүү ТҮРШЛАГААРАА шүүнэ. Бяртай эрчүүд зүгээр байж байхдаа бяраа мэдрэхгүй. Тэд гэртээ амарч байхдаа бяр тэнхээдээ багтарч ядаад байдаггүй. Харин тэднийг хүндийн жин өргө гэвэл, тэд бяраа МЭДЭГГҮЙ учраас, зүгээр л өргөдөг. Үүнтэй адил бид амарч суухдаа, тэр их хүчийг мэдрэхгүй. Бид дотор маань орших Түүний аугаа хүчийг ухаарахгүй бөгөөд гайхуулах юмгүй, жирийн л хүн шиг санагддаг (2Коринт 10:1-6).

Эрх хүчний төлөө улайрсан хүмүүс ХҮЧНИЙ МЭДРЭМЖИЙГ МЭДРЭХИЙГ ХҮСДЭГ - хүчийг дагалддаг цохилт, лугшилтыг мэдрэхийг хүсдэг. Гэхдээ ингэснээрээ зорилгоо гээдэг. Хэрэглэгдсэн хүч чадал ил харагдана. Хүнд жин өргөх үед хүний бяр ил болдог. Зарим хүн хүч, чадал “мэдэрдэггүй” учраас, Бурханы төлөө юу ч хийдэггүй. Тэд өөрт нь байгаа зүйлийнхээ төлөө л залбираад байдаг. Хайран ч цаг, хайран ч хүчин зүтгэл! Хэрэгцээтэй үед Бурханы хүч оршдог. Мөнгөтэй хүмүүс биедээ сая сая долар бэлнээр авч явдаггүй. Зүгээр л шаардлагатай үедээ данснаасаа гүйлгээ хийгээд л авчихдаг. Бид өглөөнөөс орой хүртэл Тэнгэрлэг хүчийн жин дор бэмбэгнэх шаардлагагүй. Бид өөрсдөө хүчтэй учраас бус, харин ТЭР хүчтэй учраас л, ажилладаг юм. Энэ л чухал.

АРИУН СҮНС ХЭЗЭЭ Ч ЯВДАГГҮЙ

Бид мэдрэсэн, мэдрээгүй - Ариун Сүнс хэзээ ч явдаггүй. Ариун Сүнсний бэлэг, хүч нь бидний мэдрэмжээс огт шалтгаалахгүй. Хэрэв бид итгэлээр Түүний Үг дээр зогсвол, Тайвшруулагч ирээд хамт оршино (Иохан 14:16). Тэр ямар ч нөхцөл байдалд бидэнтэй үргэлж хамт бөгөөд биднийг хэзээ ч орхихгүй, хаяхгүй гэдгийг бид мэднэ (Еврей 13:5).

ТАЙЗАН ДЭЭР ГАРЧ НОМЛОХООС ТАТГАЛЗСАН НЭГЭН НОМЛОГЧИЙГ БИ МЭДНЭ. Тэрбээр тайзан дээр гарахын оронд “Би тосолгоо мэдрэхгүй байна” гэж хэлээд, Бурханы оршихуйг гуйн, тайзны ард уйлан залбирсан юм. Гэхдээ тэр буруу байв: Ариун Сүнс юм биш, харин Хувь нэгэн - Гурвалын Гуравдугаар Хувь нэгэн. Ямар ч хүн бүхлээрээ л оршино уу гэхээс, талаж юмуу хэсэгчилж оршино гэж байхгүй. Бид Ариун Сүнсийг анзаарахгүй юмуу эсвэл мэдрэхгүй байсан ч, Ариун Сүнс хэзээд бүрэн эхээрээ л оршдог. Заримдаа би хэдэн зуун мянган хүний өмнө номлож байхдаа, Түүний оршихуйг мэдрэдэггүй. Тэгээд би яадаг уу? Би Есүс нэгэнтээ Ариун Сүнс бидэнтэй мөнхөд хамт оршино гэж хэлснийг санадаг. Тэгээд тэр амлалтыг итгэлээр хэрэгжүүлдэг. Би Бурханы Сүнсний ямагт хүндэтгэж, бататгадаг Бурханы Үгийг номлодог. Бид хүчийг мэдрэхгүй байж болно оо. Гэхдээ Тэр хэзээд тэнд байх болно. Ариун Сүнс биднийг хэзээ ч орхидоггүй.

АРИУН СҮНСТЭЙ ТҮНШЛЭХ ЦАГ ИРЖЭЭ

Бурханы сэдээгүй үйл ажиллагаа зуурдын настай. Харин Есүс - Ариун Сүнс хоёрын түншлэл бүх үйл ажиллагааг хол хаяна. Энэ бол Бурханы бүтээлдээ тогтоож өгсөн эрэмбэ дараалал бөгөөд бидэнтэй, бидэнгүй цаашаа явсаар л байна. Бид бүтэлгүйтэж ч чадна, итгэлийн баатар ч болж чадна - хүссэнээрээ л болно.

БУРХАНЫ ХИЙСЭН ЗҮЙЛ МӨНХӨД ТОГТОНО (НОМЛОГЧИЙН ҮГС 3:14). Энэ үг Бурханы бүтээлд үнэн байдаг шигээ, бидний амьдрал, үйлчлэлд ч үнэн юм. Бид амьдралынхаа хэсэг бүр дээр Бурханыг ажиллуулж, Түүнийг шийдлийнхээ төв байлгаж болно эсвэл Бурханыг тэр чигээр нь үл хэрэгсэж болно. Харин би таныг Бурханыг зүгээр нэг тэгшитгэлдээ багтаах бус, харин тэгшитгэлийг бодохын тулд Бурхантай хамтарч ажиллаасай гэж хүснэ. Түүний тусламжийг амьдрал, эрүүл мэнд, гэр бүл, үйлчлэлдээ хүлээн ав. Бурхан таны зовнил бүрт тусалж, шийдлийн чинь нэг хэсэг болж чадна.

ЕР БУСААР АЖИЛЛАДАГ ХҮЧ

“Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх,
ажиллахын аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь
Бурхан Өөрөө юм.”

Филиппой 2:13

ӨРГӨГЧ МАШИНД АЧААГАА ӨЛГӨХ

Мянган тонн төмрийг кранаар өргөх гэж байгаа нөхцөлд таны нэмэр байх уу? Магадгүй та аль нэг өнцгөөс нь зуураад, доошоо татах гэж оролдох уу? Таны нэмэр байх болов уу? Ямар ч нэмэргүй л болов уу.

ТЭГВЭЛ ДЭЛХИЙГ ӨРГӨХ ТУХАЙД? Энэ нь Бурханы зовлонт үхэл, амиллын хүчээр дамжих Бурханы л даалгавар юм. Та Геркулесийн солилцоорхуу юм хийж, Бурханы мөрөн дээрх ачааг хөнгөлнө гэж бодож байна уу? Аугаа хүчирхэг Бурханд бидний өчүүхэн тус хэрэгтэй гэж үү дээ? Өөрт нь БҮХ хүч байгааг Есүс хэлсэн. Энэ чинь хангалттай! Та Бурханы хүчинд найдаж болно. “Ачаагаа ЭЗЭНД даатга, Тэр чамайг түшин тэтгэнэ” (Дуулал 55:22).

Энэ нь бид гараа хумхиад суух ёстой гэсэн үг үү? Үгүй юм аа! Харин ч эсрэгээрээ - таны хувьд гар бие оролцох том завшаан юм. Яаж тэр үү? Өргөгч операторууд юу хийдэг билээ? Тэд хүнд жинг нүцгэн гараараа өргөдөггүй ч бас гараа хармаандаа хийгээд суудаггүй. Тэдний оролцоогүйгээр ачаа өргөгдөхгүй бөгөөд тэд ч юу хийхээ мэднэ. Тэд ачааг өргөгч машинд холбодог! Энэ бол бидний ажил. Хүмүүсийн ачааг өөрөө өргөх гэж бүү оролд. Үүнийг Бурхан л хийнэ. Бидний хувьд зүгээр л хүмүүсийг Түүн дээр авчрах хэрэгтэй. Сайн мэдээ нь даян дэлхийг өргөх Бурханы хүч юм (Ром 1:16). Сайн мэдээнд хүч бий - хангалттай хүч бий. Есүс ч үүнийг хэлсэн (Матай 28:8).

ЮУ Ч ХИЙДЭГГҮЙ ХҮНД ХҮЧ ХЭРЭГГҮЙ

Бид Бурханд итгэж, итгэл дээрээ үйлдсэн нөхцөлд л тив дэлхийг аврах боломжтой. Юу ч хийхгүй бол, юу ч л болохгүй. Бурхан бидний хийж чадах зүйлст бус, харин хийж чадахгүй зүйлст хандаж, онгод бүхий алсын хараа өгдөг билээ. Энгийн байх тухайд - бид байхын дээдээр энгийн байж чадна. Есүс биднийг

*ер бусын байлгах гэж л сонгосон. Алсын харааг барьж ав!
Хүмүүс “Би алсыг хардаг хүн биш” гэж хэлдэг. Гэхдээ “зүүдлэгч”
Иосеф Амлагдсан газрын талаар зүүдлээгүй. Тэрбээр зүгээр л
Бурханы Абрахам, Исак, Иаковт өгсөн Үгд итгэн, “Израилийн
хөвгүүдийн гэтлэлийн тухай дурьдаж, өөрийнх нь ясыг хаана
тавихыг зааварлажээ” (Еврей 11:22).*

ЗАРИМ ХҮМҮҮС ХҮЧИЙН ТӨЛӨӨ ЗАЛБИРДАГ Ч ЮУ Ч ХИЙДЭГГҮЙ. Гэхдээ юу ч хийдэггүй хүнд ямар ч хүч хэрэггүй. Бурханы Сүнсэнд сүнсээ нээж өгвөл алсын хараа, хүч нь аугаа хүчирхэг мөрөн шиг л үерлэнэ. Есүс суудаг хүмүүстэй сууж, унтдаг хүмүүстэй унталгүй, харин ажилладаг хүмүүстэй ажиллаж, тэднийг Ариун Сүнсний хүчээр дүүргэдэг. Тэрбээр хөөрхий туулайнуудыг зодоонд сурган, хэн ч биш амьтдыг бүхнийг чадагч Өөртэйгээ мөр зэрэгцэн ажиллах, үлэмж биетнүүд болгодог. Есүс үүрнээсээ гардаггүй бидний амьдралын хэв маягийг өөрчилж, Ариун Сүнсээрээ дүүргэн, боломжгүйг боломжтой болгодог.

ЕРТӨНЦ ХҮЛЭЭЖ БАЙНА

“Есүс тэдэнд —Бүх ертөнцөөр явж, сайнмэдээг хамаг бүтээлд тунхаглагтун. Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй нь яллагдах болно.

Итгэгчдэд дагалдах тэмдгүүд нь: Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярих болно. Тэд могойг барина. Бас үхүүлэх ямар ч юм тэд уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтөнд тэд гар тавивал эдгэнэ гэж айлдлаа.

Марк 16:15-18

ОНГОЦ (ВАННА) ХАНГАЛТТАЙ ТОМ БАЙЖ ЧАДАХГҮЙ

Бид Чуулган дотор Сайн мэдээ номлохыг дахин сурахаас гадна мөн аль зам дээр төөрсөн хүмүүс байгааг дахин олж мэдэх хэрэгтэй. Есүсийн дээд захирамж нь бидний амьд ахуй цаг хугацаанд зориулагдсан билээ.

ТА АМИЙГ АВРАЛД ХҮРГЭХ ГЭЖ БАЙГАА БОЛ, ЗАГАСНЫХАА ТОРЫГ ОНГОЦОНД (ваннад) бүү хая. Тэнд загас байхгүй. Торонд чинь саван л орж магадгүй. Хэрэв та хүмүүсийг авралд хүргэх сэтгэлтэй бол, тороо гол, далай юмуу ядаж нууранд хая. Та Бурханы илгээсэн газар руу, загастай газар руу явах хэрэгтэй. Нуур хаа байдаг юм бол гэж гайхаж байгаа бол, зүгээр л сүмээсээ, чуулганаасаа гудамжинд гар. Ургац тэндээс л эхэлнэ. Дэргэдүүр чинь зөрж өнгөрөх хүн бүрт Есүс хэрэгтэй. Бид тасалгаандаа дэндүү тухалжээ. Гэтэл бид хурдны замууд, мэдэхгүй замуудыг яаралтай судлах хэрэгтэй болоод байна.

ТҮРЛЭГ АЙСУЙ

Ариун Сүнс хуй салхи мэт ирэх бөгөөд Сайн мэдээг номлох үед үлэмж баяр хөөрийн түрлэгийг авчирдаг (Лук 1:10). Энэ Сайн мэдээ нь яг л түрлэг шиг давалгаалан орж ирэхдээ, замдаа таарсан бүхнийг хамна. Энэ нь гацсан дуудлагыг тайлж, тэдгээрийг аугаа чанарын урсгалд хөвүүлнэ.

БИ ГЕРМАНЫ ЭЛЬБА ГОЛЫН АМАН ДЭЭР ӨССӨН ЮМ. Голын түрлэг татарсан үеэр хөвгүүд бид голын шаварт зоогдсон усан завиуд дээр гарч тоглодог байв. Тэднийг байрнаас нь хөдөлгөнө гэж ярилтгүй - ямар ч боломжгүй. Тэгтэл түрлэг орж ирж, завиуд хөвж эхэлнэ. Би тэр завиудыг ганц хөлөөрөө л зогсоолоос нь хөдөлгөнө.

Бид Сайн мэдээг номлоход, түрлэг орж ирэн, хөдлөшгүйг хөдөлгөж, эдгэшгүйг эдгээж, боломжгүйг боломжтой болгодог. Бурханд найдацгаая!

ЁРООЛГҮЙ НАЙДВАР

Түрлэг орж ирэхдээ, ганц хоёр усан завийг өргөлгүй, харин ёроол байхгүй усан онгоцоос бусад бүх завийг өргөнө. Гэхдээ Ариун Сүнс тэдгээр эвдэрхий онгоцуудыг ч засна гэсэн найдвар бий. Шинэчлэгдэн, сэргээгдсэн тэдгээр онгоцнууд цоо шинэ үйлчлэлд гарна.

АРИУН СҮНСНИЙ ХҮЧ НЬ ХУВИЙН ХЭРЭГЦЭЭГ ДАВАН, ГЭР БҮЛ, НИЙГЭМ, ХОТУУД РУУ СУНАНА. Ариун Сүнсний хүчийг бүү хязгаарла. Ариун Сүнс ямагт нэг хүн, нэг гэр бүл, нэг нийгмээс давж сэтгэдэг. Ариун Сүнс хөдлөхдөө, нэгээс олон амь амьдралд хүрдэг. Петрийг Корнелийн гэрт үйлчлэхээр очиход, Ариун Сүнс ганцхан Корнел дээр буулгүй, харин гэр бүлийнхэн дээр нь буусан (Үйлс 10). Филиппийг Этиопийн тайганд үйлчилсний дараа нөлөө нь тэр үндэстэн даяар хүрсэн (Үйлс 8:26-40).

ИТГЭЛИЙГ СОНГО!

“Нутгийг тандсан хүмүүс дотроос Нуны хүү Иошуа болон Иефуннегийн хүү Калев нар хувцсаа урж, Израилийн хөвгүүдийн даяар хотол түмэнд ярин — Бидний тандахаар туулан өнгөрсөн нутаг бол дэндүү сайхан нутаг билээ. Хэрэв ЭЗЭН, биднийг таалбал Тэр биднийг тэр нутагт аваачиж, тэрхүү сүү зөгийн бал урссан нутгийг бидэнд өгөх болно. Зөвхөн ЭЗЭНий эсрэг л бүү тэрсэл. Тэр нутгийн ард олноос бүү ай. Тэд бидний хоол болно. Хамгаалалт нь тэднээс зайлуулагдсан бөгөөд ЭЗЭН бидэнтэй хамт байна. Тэднээс бүү айгтун гэлээ.”

Тооллого 14:6-9

ХООСОН БУЛШ БҮЮУ ДЭЭД ӨРӨӨ

Моисе “Би өнөөдөр тэнгэр газрыг дуудаж та нарт гэрч болгон чиний өмнө амь ба үхэл, ерөөл ба хараалыг тавья. Чи бас чиний үр удам амьдрахын тулд амийг сонгож...” (Дэд хууль 30:19) гэжээ. Эргэлзээ, цөхрөл, үхэлд хүргэх асуулт дээр төвлөрөх үү эсвэл амь, найдвар, ерөөл рүү хөтлөх асуулт дээр төвлөрөх үү гэдэг сонголт нь таных. Ариун Сүнс танд хариулж, бүрэн дүүрэн амьдралын төлөөх хариултыг өгнө.

ЕСҮСИЙГ ҮХЛЭЭС СҮР ЖАВХЛАНТАЙГААР АМИЛУУЛАГДАХ ҮЕД ПЕТР, ИОХАН ХОЁР ХАМГИЙН ТҮРҮҮНД БУЛШИНД НЬ ОРЖ ҮЗСЭН БАЙДАГ. Тэд яг л талийгаачийн өлгий дээрх ДНХ-г нь судлаж шинжилдэг эрдэмтэд шиг тэндээ баахан суусан байх. Тэр эрчээрээ явсан бол, тэд хойч үедээ зориулж ямар нэгэн шинжлэх ухааны ном бичиж үлдээх байсан байх. Гэхдээ тэд булшнаас гарч яваад, Дээд өрөөнд очсонд Бурхандаа талархъя. Учир нь тэнд гал бууж ирсэн билээ.

ХҮНИЙГ ХҮНДЭТГЭХ ГЭЖ БАЙНА УУ, БУРХАНЫГ ХҮНДЭТГЭХ ГЭЖ БАЙНА УУ?

Хүнд бус, Бурханд таалагдахыг эрмэлзье. Хүний магтаалд дархлаатай хүмүүс хүний шүүмжлэлд ч бас дархлаатай байдаг. Эзэн л таны алдар бөгөөд тэргүүнийг чинь өргөдөг Нэгэн байг.

АЙДАС НЬ ДИАВОЛЫН ГАРЫН НААДГАЙ ЮМ. Тэр үнэндээ жинхэнээсээ хор хохирол учруулж чадахгүйгээр, зүгээр л чадах юм шиг биднийг сүрдүүлэн айлгадаг. Дявол бол мэхлэгч юм. Балаам Израилийг ерөөхөд хүрсэн (Тооллого 22-24). Тэрбээр Бурханы

хүмүүсийг өөрийн эрхгүй ерөөхдөө, Бурханы хүмүүсийг харааж болдоггүй юмаа гэдгийг бидэнд харуулжээ. Бид дархлагдсан. Бид аврагдан сэргээгдсэн. Бурханы авран сэргээсэн хүмүүс дээр хэрэгжиж байсан тэр үнэн өнөөдөр ч хэрэгжинэ. Айдас нь Голиатын дууг сонсдог бол, итгэл нь хаадын Хааны уухайг сонсдог.

ДАРХЛАА

Итгэгч хүн итгэлийн бамбайгаараа Диаволын довтолгооноос хамгаалагдана. Энэ бамбай нь сум нэвтэрдэггүй бамбай юм. Бид Диаволын хяналтаас хамгаалагдах дархлаа, аврал, ялалт, эрх чөлөөг эдэлдэг. Бид Христийн аврагч цус, Ариун Сүнсэнд итгэх итгэлээр зоригтой бөгөөд ганхашгүй байж чадна.

НЭГ УДАА МЭДЭЭГЭЭР НАМАЙГ БОЛООД МИНИЙ АЖЛЫГ ШҮҮМЖИЛЖ БИЛЭЭ. Мөр зэрэгцэн үйлчилж яваа нөхөд маань над руу утасдаад: “Рейнхард, чи өөрийгөө өмгөөлөх ёстой” гэсэн юм. Харин би сөгдөөд: “Эзэн минь, би яах ёстой вэ?” гэтэл, Ариун Сүнс: “Чи бол Миний ургацын талбай дээр Надтай хамтран ургац хурааж буй ажилчин. Тиймээс ганц хулганатай хөөцөлдөж, ажлаа бүү зогсоо!” хэмээн айлдаж билээ. Тиймээс одоо би өөрийгөө өмгөөлөхийн оронд зүгээр л удахгүй болох Сайн мэдээнийхээ аяны талаар ярьдаг. Үүгээрээ би өөрийгөө баярлуулж, харин чөтгөрийг уурлуулдаг. Эзэн л намайг өмгөөлнө. Хожмын өдөр би “Сайн байна, миний итгэмжтэй бөгөөд сайн зарц!” (Матай 25:21) гэдэг үгийг сонсмоор байна.

ТҮҮНИЙ АЛДРЫГ ТУСГАСАН

Тэргүүн тахилч нарын цээжсивч дээрх эрдэнийн чулуудаас Эзэний алдар гийдэг байв (Гэтлэл 28:15-21). Призматик өнгөнүүдийн

цацраг нь хөшигт хануудыг нэвтлэн гагцхүү Эзэний алдрыг л тусгадаг байв. Энэ бол төгс зураглал. Бидэнд эрдэнэс мэт гэрэлтэх авъяас чадвар л гэж байхаас, алдар гэж байхгүй. Гэрэл нь гагцхүү Есүс Христээс л ирдэг. Харин бид нүүрээ Түүн рүү эргүүлж, Есүсийн тусгал болохдоо, тэр гэрлийг гэрчилдэг (Иохан 1:8). Бид тэр гэрлийг өөрийнхөө амьдралд тогтоохоос нааш үүнийг хэн ч харахгүй. Сүнсний бэлэгүүд нь бидний өөрийн маань авъяас чадвар, нигүүлсэл бус, харин Түүний бэлэг юм.

ЕСҮС ХРИСТЭЭР ДАМЖИН ЧУУЛГАНД АЛДАР ОРШИХЫН ТУЛД бидний төрөлх чадвараар байна уу, ер бусын чадвараар байна уу, бидний хийж чадах, байж чадах, хийх ёстой зүйлсийг Бурханы Сүнс шатааж, үүгээр нэвт гэрэлтэх ёстой. “Хаанчлал, хүч чадал, алдар суу мөнхөд Таных, Амен” (Матай 6:13).

ЭНЭ БОЛ ЯВАХ ЦАГ

“Филип Самарийн хотод ирж, тэдэнд Христийг тунхаглав. Хурсан олон Филиппийн үйлдэж байсан тэмдгүүдийг харж, сонсож, санал нэгтгэйгээр яриаг нь анхаарч байлаа. Учир нь бузар сүнстэй олноос тэдгээр нь чанга дуугаар хашхиран зайлж байсан юм. Саа өвчтэй болон эрэмдэг олон эдгэрч байв. Тэр хот үлэмж баяр баясалтай байв.”

Үйлс 8:5-8

ЭНЭ СИМУЛЯТОР БИШ

Та энэ номыг уншаад, “Бурханы пуужин” болоод байгаа байх. Бүх мотор, системүүд нь сайхан халж, хөөрөхөд бэлэн болоо байх. Гэхдээ бас нэг бүтэц дутуу байна аа. Тэр бүтэц нь Та юм. За алив ээ! Бүхээгтээ ороод, Бурханы дээд зорилгын төлөө Ариун Сүнсээр аль нэг орбит руу харвуул.

САНСРЫН НИСГЭГЧ НАР ДААЛГАВРЫНХ НЬ АМЖИЛТ ШИЙДЭГДЭХ ТЕХНИКИЙН БӨГӨӨД АМЬДРАЛЫН ҮР ЧАДВАРАА ДАДЛАГАЖУУЛАН, СИМУЛЯТОР ДОТОР ХЭДЭН ЗУУН ЦАГ БЭЛТГЭЛ ХИЙДЭГ. Гэхдээ симулятор нь бас л бодит амьдрал биш, зүгээр л дууриамал эд шүү дээ. Сансрын нисгэгч маань эцсийн эцэст даалгавраа биелүүлэхээр тав тух, аюулгүй байдлаа ардаа орхиж, хөлөгтөө суух ёстой. Яг үүнтэй адил Ариун Сүнс таныг хувь тавилан руу чинь хөөргөхөөр хүлээж байна. Энэ бол Ариун Сүнс тэй хамт пуужингийнхаа хамарт сууж, гайхал, боломжоор баян гайхамшгийн амьдралд гарах цаг.

АРИУН СҮНСНИЙ ОН ТООЛЛЫН БИЧИГ

ХЭСЭГ 9:

ГАЛТ АМЬДРАЛД ОРОХ
- АРИУН СҮНС ДОТОРХ
БАПТИСМЫГ ХЭРХЭН
ХҮЛЭЭЖ АВАХ ТУХАЙ

“Апoлыг Коринтод байх үед Паул дээд нутгуудаар явсаар Ефест ирээд хэсэг дагалдагчдыг олж уулзав. Тэгээд тэдэнд —Та нар итгэхдээ Ариун Сүнсийг хүлээн авсан уу? гэхэд тэд түүнд —Үгүй. Ариун Сүнс байдгийг бид ер сонсоогүй юм байна гэв. Тэр —Тэгвэл та нар ямар баптисм хүртсэн юм бэ? гэхэд тэд —Иоханы баптисмыг гэжээ. Паул —“Миний араас ирж буй Нэгэн болох Есүст итгэгтүн” гэж хэлэн, Иохан гэмшлийн баптисм хүртээж байсан шүү дээ гэв. Үүнийг сонсоод тэд Эзэн Есүсийн нэрээр баптисм хүртэцгээв. Ийнхүү Паул тэдэн дээр гараа тавихад Ариун Сүнс тэдэн дээр ирж, тэд хэлээр ярьж, эш үзүүлжээ.”

Үйлс 19:1-6

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: АРИУН СҮНС ДОТОРХ БАПТИСМ ГЭЖ ЮУ БОЛОХ

Ариун Сүнс доторх баптисм нь итгэгч хүний амьдралд амин чухал юм. Танд Ариун Сүнсний баптисмын талаар Библийн ул суурьтай ойлголт өгөхийн тулд би Пенекост руу болоод түүнээс цааш хөвөрсөн үйл явдлыг он цагийн дарааллаар нь гаргасан бөгөөд үүнийгээ Ариун Сүнсний он тооллын бичиг гэж нэрлэлээ.

ЗАХИРАМЖ

Иерусалимын Сүмийн хашаанд цугласан олны чихнээ тун удахгүй урьд хожид дуулдаагүй хамгийн сонголонтой чимээ хадах гэж байв. Үндэсний их баяр наадмын төгсгөлийн зан үйл үйлдэгдэж, нүд бүр усаар бөгөөд дарсаар дүүргэсэн алтан савыг алдалгүй ширтэж байв. Юу юугүй Эзэнд ундаан тахилыг өргөх болжээ.

Тахилч гялтганах савыг нарны цацраг өөд өргөсөн чигээрээ зог тусахад, хүмүүс тахилын ширээн дээрх хүрэл савд ариун ус цалгин буухыг сонсохоор амьсгаа даран, чих тавин хүлээнэ. Тэгтэл гэнэт Тэнгэр оролцож, мянган жил дуулдаагүй, шар үс босгомоор дуу хадав. Энэ нь Есүс Христийн дуу хоолой байлаа. Тэр бол эхэнд айлдаж, тэнгэр, газрыг бий болгосон Үг байв. Гэтэл одоо Тэрбээр Иерусалимд зогсоод, Тэнгэрлэг язгуурын захирамжийг айлтгахдаа, Бурханы эрин үеийг өөрчлөв:

“Цангасан хүн байвал Над уруу ирж, уугтун. Бичвэр хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно (Иохан 7:37-38).

ЦӨЛ ДЭХЬ УРСГАЛ

“Амьд усны голууд!” Шил ус биш, харин цэнгэг, амьд, тунгалаг, цэлэлзсэн, дуусахгүй, арвин голууд. Зарим хүн шил усны төлөө л амьдардаг. Дэлхийн дэлгүүрүүдэд яг шинэ бүтээгдэхүүн тун ховор. Удаан хадгалалт нь том бизнес болжээ. Үүнд урьдаас савлаж бэлтгэсэн хөгжим, кино, номууд ч орно. Зурагтынхан ч бусад хүмүүс яаж амьдардгийг гайхуулсан “жүжгээрээ” сая сая үзэгчийн нүдийг хуурна. Тэр үзэгчдийн дунд тоглож наадна гэж юу байдгийг мартсан бяцхан жаалууд ч орно.

ОДОО АМЬДАРИ

Хүмүүс өөрчлөгдсөнийхөө дараа, ажлаа тараад, мөнгөтэй болохоороо, гэрлэсэн хойноо, тэтгэвэрт гарсан хойноо амралтанд явахаараа “амьдарна” гэдэг. Гэтэл Есүс бидэнд яг ОДОО амьдрах амьдрал өгөхөөр ирсэн. Тиймээс ХҮЛЭЭЛГҮЙ, харин байгаа газартаа юу ч хийж байсан амьдар. Тэрбээр амийг амьдруулдаг.

ТҮҮХЭН САМБАР

Бурхан Израилийг 40 жил цөлд байхад нь самбар дээр тэдэнд хандсан төлөвлөгөө гаргажээ. Израильчууд цоргоноос гоожих, цэвэршүүлсэн ус уух хэрэггүй байв. Эзэн хаднаас булаг оргилуулжээ (Гэтлэл 17:1-7). Сүмийн ундаан тахил нь чухам цөлийн энэ усыг дурсан тэмдэглэдэг баяр байв (Тооллого 20:1-3). Гэтэл Есүс үүнд цоо шинэ сүр жавхлантай утга хайрлажээ - Ариун Сүнсний цутгалангийн билэгдлийг.

ГАГЦХҮҮ ЕСҮС

ЕСҮСЭЭС өөр хэн ч ийм гайхамшигтай мэдэгдэл хийж, үүнийгээ биелүүлж чадахгүй! Тэрбээр Бүтээл эхэлсэн алдар руугаа

өргөгдөөд, юмсын дэс дарааллыг өөрчлөх ажээ. Өмнө мэдэгдээгүй байсан зүйл тэнгэрээс газарт бууж ирэх нь. Тэрбээр үүнийгээ “Аавын амлалт” (Үйлс 1:4) хэмээв. НӨГӨӨ амлалт. Энэ амлалт нь Бурханы Үг доторх 8,000 гаруй амлалт дундаас “НӨГӨӨ амлалт” гэдэг утгаараа онцгойрдог. Христ үүнийг Өөрийнхөө амлалт болгосон. Түүнд өгсөн Аавын бэлэг нь Түүний бидэнд зориулсан бэлэг бөгөөд энэ тухайд Иохан баптист:

Би Түүнийг таниагүй. Харин усаар баптисм хүртээлгэхээр намайг илгээсэн Тэр “Хэний дээр Сүнс тагтаа мэт буун ирж тогтохыг чи харна, Тэр бол Сүнсээр баптисм хүртээгч мөн” гэж надад айлдсан юм. Би харсан. Энэ бол Бурханы Хүү мөн гэдгийг гэрчилж байна гэв (Иохан 1:33-34) гэсэн билээ.

ҮГ МӨХӨСДӨХ ҮЕД

Иохан янз бүрийн илэрхийлэл хэрэглэсэн бөгөөд Бичээс “амьд усны голууд” гэдэг үгийн оронд олон янзын нэр томьёо хэрэглэсэн байдаг. Тухайлбал: ариун гал дотор баптисм хийлгэх (Матай 3:11, Лук 3:16), “хүчийг өмстлөө” (Лук 24:49), Бурханы тосоор тослогдсон, Сүнс дотор булхах, “Сүнсээр дүүрэх” (Ефес 5:18), Сүнс дотор алхаж, залбирч, амьдрах (Галат 5:25, Ром 8:26), бидний бие Ариун Сүнсний сүм байх (1Коринт 6:19), Христээс Өөрөөс нь гадна “өөр Тайтгаруулагчтай” байх (Иохан 14:16) гэх мэт.

УРАН ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

Эдгээр нь хар зураг төдий юм. Харин өнгө будаг нэмээд, нарийн ширийнийг нь тодруулаад өгвөл бүр янзтай. Библи нь уран зургийн үзэсгэлэн мэт - ажлаа хийж буй Ариун Сүнсний тэмдэг, гайхал, гайхамшгийг дүрслэн өгүүлдэг. Энэ нь “Есүстэй хамт байсан” хүмүүс яваад, дэлхийг орвонгоор нь эргүүлэхэд, хүмүүс “Эзэнийг мэдэхээр ирээд”, шинэ үйл явдлыг эдэлж буй үйл явдлыг

зураглан өгүүлдэг. Тэд бол зүгээр нэг шашны солиотнууд юмуу сүмд явдаг хүмүүс бус, харин амьд итгэлтэй, шинэ “угсаа” байв. Паул “алдаа зөрчил дотроо үхсэн биднийг Христтэй хамт амьд болгосон юм” (Ефес 2:5) гээд, “Түүний цог жавхлантай эрх мэдлийн дагуу бүх хүчээр хүчирхэгжсэн” (Колоссай 1:11) гэсэн юм. Эзэн Есүс Өөрөө:

Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олно... (Үйлс 1:8) хэмээн амласан.

Дахин төрсөн итгэгч хүнийхээ хувьд бид онцгой, ариун хүмүүс бөгөөд Сүнс доторх баптисм нь бидэнд зориулсан дараагийн том үйл явдал юм. Есүс үхэж, амилж, Аавынхаа баруун гарт залрахдаа, ганцаараа энэ бүхнийг боломжтой болгосон юм. Гайхамшигтай бэлэг!

АРИУН СҮНС ГЭЖ ХЭН БЭ?

Эзэн Өөрийгөө хэн болохыг бидэнд хэлэхийн тулд тэнгэрийн шуудангаар суртчилгаа хийдэггүй. Түүний Ариун Сүнсээрээ хийдэг ажил нь газарт харагддаг. Ариун Сүнс бол Хувь нэгэн бөгөөд ажиллаж буй Бурхан юм. “Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байхад” (Эхлэл 1:2) бүтээл төржээ. Тэгтэл Бурхан зарц нараа сонгоход, Ариун Сүнсний хүч тэдэн дээр буув:

Тэгээд Мосе, Израилийн хөвгүүдэд —Үзэгтүн, Иуда овгийн Хурын ач, Урийн хүү Безалелыг ЭЗЭН нэрээр нь дуудав. Тэр түүнийг мэргэн ухаан, ойлголт, мэдлэг болон бүх талын ур чадварт Бурханы Сүнсээр дүүргэсэн нь... Тэрээр заах чадварыг түүнд болон Дан овгийн Ахисамахын хүү Охолиабын зүрхэнд ч бас өгчээ (Гэтлэл 35:30, 31, 34).

ЭЗЭНий Сүнс түүн дээр ирж, тэрээр Израилийг шүүв (Шүүгчид 3:10).

Харин ЭЗЭНий Сүнс Гидеоныг бүрхсэнээр (Шүүгчид 6:34), Гидеон Израилийг хамгаалав (Шүүгчид 6:11, 8:35). Сүнс Самсонаар ер бусын хүч гаргуулахаар хөдөлгөв (Шүүгчид 13:1, 16:31). Эзэний Сүнс Иефта дээр бууж, Израилийн дайснуудыг түүний гарт тушаав (Шүүгчид 11:1, 12:7).

Үүний дараа Самсон амьд ахуйдаа улс үндэстнийг бүхлээр нь удирдсан. Хэрхэн? “Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ” (2Петр 1:21). Эш үзүүлэгч Мика “би...ЭЗЭНий Сүнсээр, шүүлт, эр зоригоор дүүрэн байна” (Мика 3:8) хэмээн гэрчилсэн.

Эдгээр нь Ариун Сүнсний хөрөг билээ. Энэ бол Христийн амласан Сүнс: цэц ухаан, мэдлэг, бүтээл, хүч, эдгэрэл, тэнхээ, итгэлтэй байдал, сайн үйлсийн Сүнс.

Бурханы хүч нь төрөлхийн гялалзсан зан чанартай, эрч хүчтэй хүмүүст зориулагдсан ер бусын цэнэг бус, харин Бурханы хүчээр дутдаг, хэний ч мэдэхгүй, сул дорой хүмүүст зориулагдсан зүйл билээ. “Тэр эцэж ядарсанд тэнхээ өгч, Чадал барагдсанд нь хүч нэмдэг” (Исаиа 40:29).

ДӨРВӨН МУНДАГ ЗУРАГ

Библийн уран зургийн үзэсгэлэнгээс дөрвөн зургийг сайтар судлах хэрэгтэй.

ЭШ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХҮСЛЭН

Эхний зураг нь: Мосе Майхны хурлаар 70 ахлах дээр гар тавихад, тэдэн дээр Бурханы Сүнс буужээ. Яг тэр эгшинд хуаранд мөн Сүнсээр дүүрсэн Элдад, Медад хоёр эш үзүүлсэн. Нэг залуу энэ тухай Мосе дуулгахаар гүйжээ. Иошуа Мосег ганцаараа л эш үзүүлэх эрхээ хадгалах ёстой гэж үзэхдээ: “Мосе, тэднийг

болиулаач!” гэж ятгасан. Гэтэл Мосе эсэргүүцэх нь бүү хэл “Чи миний өмнөөс хардаж байна уу? ЭЗЭНий бүх ард түмэн эш үзүүлэгчид болж, ЭЗЭН тэдний дээр Өөрийн сүнсийг тавьж соёрхох болтугай” (Тооллого 11:24, 29) гэж хэлжээ.

Нэгэн зэрэг далан хүн шүү! Энэ чинь 1,200-гаад жилийн тэртээ болсон явдал. Тэр үед ийм явдал ховор бөгөөд голдуу хувь хүн дээр хааяа нэг, хэсэгхэн хугацаанд л өрнөдөг байв. Гэтэл Мосегийн хүсэл хожмын зуунуудад аж төрсөн олон, олон хүний зүрхэнд байжээ.

ЦЭЛМЭГ ТЭНГЭР

Хоёр дахь зураг нь: Соломоны Сүмийн бүтээн байгуулалт маш далайцтай өрнөж байсан боловч, нүглээс болж улс үндэстэн нь доройтжээ. Эш үзүүлэгч Иерусалимд зогсоод, анхааруулга, шүүхийг дуудав. Иоел эш үзүүллийн дурангаараа тэртээ тэнгэрийн хаяанд дайны хар үүл хуралдан бужигнаж, гамшиг, сүйрэл айсууг харсан боловч, үүнийг нь Израиль юмын чинээ бодолгүй өнгөрөөснөөс болж энэ зөгнөл нь хожим нэгт нэгэнгүй биелэхдээ, Иоел жинхэнэ эш үзүүлэгч байсныг бидэнд батлан харуулсан билээ. Гэхдээ Иоелийн Израильд хандсан үг нь үүгээр дуусаагүй юм. Тэрбээр хуралдан буй хар салхины цаадах цэлмэг тэнгэрийг харсан нь зүгээр нэг шуурганы дараа тэнгэр онгойх үйл явдал бус, харин гайхамшигтай цоо Шинэ Зүйл байв.

Дараа нь Би Сүнсээ бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж Хөгшчүүл чинь зүүд зүүдэлж, Залуус чинь үзэгдэл үзнэ. Боол шивэгчингүүд дээр ч Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана. Би тэнгэр ба газарт совин ёр үзүүлнэ. Тэр нь цус, гал, утаан багананууд болой (Иоел 2:28-30).

БҮГДЭД НЬ СОЁРХСОН

Тэр үед зарц охид нь эзэгтэй нарынхаа гар дээр ус гоожуулан, угаал үйлдүүлдэг байв. Гэтэл Бурхан тэдгээр зарц нар дээр ч

Сүнсээ цутгаахаа амласан байх юм. Үнэндээ энэ нь АРИУН СҮНС ДАЯН ДЭЛХИЙН БҮХ ТӨРЛИЙН ХҮМҮҮС ДЭЭР ЦУТГАНА гэсэн утгатай зөгнөл байв.

Энэ бол гайхмаар явдал. Нэгэнтээ Өөрийнхөө сонгосон, итгэмжтэй зарц нарт л соёрхдог байсан зүйлээ Бурхан Өөрийнх нь хэмээн дуудуулах хүн бүрт зөвшөөрөх нь байна. Энэ нь олон хүний хувьд төсөөлж, итгэхэд бэрх зүйл байв. Гэхдээ Бурхан ингэж хэлсэн бөгөөд Түүний Үг мөнхөд тогтоно.

АРЬСАН ДЭЭЛТЭЙ ЭШ ҮЗҮҮЛЭГЧ

Гурав дахь зураг нь: Иордан голын эрэг дээр зогсох, арьсан дээлтэй Иохан Баптист. Тэрбээр 400 жилийн дараа морилсон Бурханы анхны эш үзүүлэгч байв. Хүмүүс түүнийг сонсохоор бөөн бөөнөөрөө шавж, баптисм хийлгэж байлаа. Түүний аянган үг Израилийг гэмшиж, он удаан жил хүсэн хүлээсэн Нэгэн нь айсуу тул бэлэн байхад дуудав.

Би та нарт гэмшлийн чинь төлөө усаар баптисм хүртээдэг. Харин Надаас илүү хүчирхэг Нэгэн миний араас ирж байна. Би Түүний шаахайг авч явах ч үнэ хүндгүй. Тэр та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ (Матай 3:11).

ЖИРИЙН БАПТИСТ БИШ

Хорин дөрвөн цагийн дараа баптисм хийлгэхээр ирсэн хүмүүсийн дундаас Иохан ус гатлан ирж яваа нэгэн залуу эрийг хараад цочирдов: “ЭНЭ ЧИНЬ ЕСҮС - ТА БАЙНА ШҮҮ ДЭЭ! Би Танд баптисм хийх эрхгүй. Та л надад баптисм хийвэл таарна!” Есүс бол нөгөө амлагдсан “айсуу Нэгэн” гэдгийг Бурхан Иоханд харуулжээ (Матай 11:3, Лук 7:19, 20). Тэрбээр Иоханы Иордан голд үйлдсэнтэй зүйрлэшгүй аугаа үйлийг хийх болно. Есүс Баптист ус мэтийн бодит юмсыг хэрэглэлгүй, харин ер бусын бүтэц болох

тэнгэрийн галыг хэрэглэнэ. Иохан Иордан голын хүйтэн усан дотор зогсож байсан бол, Есүс шингэн галын голд зогссон. Иохан хэдэн өдөр л баптисм хийсэн бол, Есүс зөвхөн Пентекост өдөр нэг хэсэг хүмүүст бус, харин эрин зуунуудын турш “бүх махан биед” баптисмаа цуггасаар байна. Тэрбээр эдүгээ 700,000 өдрийн дараа ч үүнийгээ хийсээр байна!

АМЛАЛТАА САХИГЧ НАР

Дөрөв дэхь зураг нь: Есүсийг цаазалсан эрх баригчдаас айсан 120 дагалдагч сэм цуглаж, нам хүлээж байв. Есүс “Харагтун, Би Эцэгийнхээ амласныг та нарт илгээнэ. Харин та нар дээрээс ирэх хүчийг өмстлөө энэ хотдоо үлд” (Лук 24:49) гэсэн. Тиймээс тэднийг хүлээгээд сууж байх хойгуур дэлхий ч тэднийг таг мартжээ. Тэгтэл ямар ч гайхамшиг тохиосонгүй, юу ч болсонгүй, бүх зүйл нам тайван байв.

ПЕНТЕКОСТ ӨДРҮҮД

Арав дахь өдөр нь Бүтэн сайн өдөр буюу Долоо хоногуудын баяр - Пентекост өдөр байв. Өглөөний есэн цагт Сүмийн тахилч Эзэний өмнө анхны үр жимсийн талхыг өргөн даллав. Гэтэл энэ нь яг л дээш өргөгдсөн Христэд өгсөн дохио болсон мэт Иерусалимын тэнгэрт Тэнгэрлэг шуурга босов.

Есүс Өөрөө ялгууснаар дээш өргөгдөхдөө тэнгэрүүдийг сэт татжээ. Тийнхүү өдгөө онгорхой тэнгэрээс Ариун Сүнс бууж ирэв. Ариун Сүнс бууж ирэхдээ, тэнгэрт хүрэх зам нээгдсэнийг харуулжээ. Тэгээд тэр цагаас хойш хэзээ ч хаагдаагүйд нь Бурхандаа талархъя! Есүсийг үхэх үед цуулагдсан Сүмийн хөшгийг тахилч нар нийлүүлж оёх гэж оролдсон л байх. Хэн ч - тэр дундаа Диавол болоод түүний хамсаатнууд ч тэнгэрт энэ уранхайг оёж нийлүүлж чадахгүй. Энэ нь мөнхөд онгорхой байх, шинэ амьд зам юм.

ГАЛАН ДӨЛҮҮД

Моше Бурханыг бутан дундах галаар харсан. Тэгвэл өнөөдөр хүний хааж чадахгүй энэ алдрын хаалгаар мөнөөх л гал болох Ариун Сүнс иржээ. Галан дөлүүд нь хүлээж буй дагалдагч нэг бүрийн толгой дээр бадамлах гоо үзэсгэлэн болон тогтжээ. Тэнгэрийг тэр аяар нь дүүргэсэн алдар нь одоо тэнд байсан хүмүүсийн цээжинд хуржээ. Ариун Сүнс тэдний дотор бөгөөд тэдний дээр байв. Хүн урьд нь ийм зүйл огт үзээгүй. Үүнийг үгээр дүрслэхийн аргагүй байв. Тэгтэл Бурхан тэдэнд “Бурханы гайхамшигт ажлыг” онгод орсон шүлэгч мэтээр ярих үг, шинэ хэл, яриа өгчээ (Үйлс 2:11).

ТАЙТГАРСАН

Үүний тайлбар нь тун амархан юм. Дагалдагч нар Христийнх байв. Тэр Өөрөө тэгж хэлсэн бөгөөд Түүнийг дэлхий дээр дагалдагч нартайгаа хамт байхад, дагалдагч нар нь гайхамшигт үйлс бүтээж чадаж байв. Тэгж байтал Христ Бурхан руугаа явж, дагалдагч нар нь айж, ганцаарджээ. Гэхдээ Эзэн Өөр нэгэн Туслагчийг буюу Ариун Сүнсийг илгээхээ амласан байв (Иохан 14:16).

“Тайтгаруулагч” (параклет) гэдэг үг нь “зэрэгцэж алхдаг хүн” гэсэн утгатай. Есүс гурван жил хагасын хугацаанд дагалдагч нартайгаа өдөр шөнөгүй хамт байж, тэднийгээ сургаж, энэ насны бөгөөд өнө мөнхийн найдвар хайрлаж байлаа. Тэдгээр харчуул Эзэнтэнээсээ - Христээс Өөрөөс нь сайхан мэдээ сонсдог байв. Гэтэл Эзэнийгээ явсны дараа тэдэнд Тайтгаруулагчийнх нь үүргийг гүйцэтгэх өөр нэгэн хэрэгтэй байсан нь Гурвалын Нэг болох Ариун Сүнс Бурхан байжээ.

ТУСЛАГЧ ЭНД БАЙНА!

“Туслагч” гэдэг үг нь хэрэгцээтэй үед дуртайяа туслалцаа заавар өгдөг, хэзээд бэлэн хүнийг хэлнэ. Есүс тэдний дэргэд гурван жил

хагас хамт байсан бөгөөд дагалдагч нарынхаа нэгдүгээр хамгийн том Туслагч, Хамтрагч, Тайтгаруулагч нь байв. Тэгтэл Пентекост өдөр өөр Нэгэн болох, өөр Туслагч болох Ариун Сүнс ирсэн юм. Яг л Есүс дахиад л дэргэд нь ирчихсэн юм шиг болсон бөгөөд тэд урьд өмнө дахин төрсөн хүний нэгэн завшаан болох гэрчлэх ажлаа хэсэгхэн зуур гүйцэтгэсэн шигээ дахин Сайн мэдээг номлож, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөх Аугаа захирамжийг биелүүлэх хүчтэй болов (Матай 28:19, 20; Марк 16:15-18).

ХАМТРАН ӨВЛӨГЧ

Бид ч яг ийм нөхцөлд байна. Тэд яг энэ амлалтын хамтран өвлөгч нар билээ. Нэгдүгээрт - бид Христ дээр ирж, өөрийгөө Түүнд өгөх ёстой. Тэр цагт бид баптисмын хүчийг хүлээн авна. Амьдрал маань Түүний амиллын гэрч байх ёстой. Энэ нь зүгээр нэг ярих явдал биш, харин Сүнсний бүрэн дүүрэн байдлыг харуулах явдал юм.

ГАЛД ДҮРЭГДСЭН

“Баптисм” гэдэг үг нь анхандаа ямар ч шашинлаг утга агуулгагүй байжээ. Энэ нь даавуу будах үйлдвэрлэлээс гаралтай үг юм. Англи дээр “дүрэх” гэвэл таарна. Даавууг ямар нэгэн будганд дүрэхээр, даавуу нь будгаа дагасан өнгөтэй болно. Христ бидэнд Сүнс дотор баптисм хийхэд, бид Сүнсний мөн чанар юмуу “өнгийг” шингээж, тэнгэрлэг мөн чанарыг нь хуваалцана (2Петр 1:4). Сүнс бидний дотор, бид Сүнсний дотор байна. Бид Ариун Сүнсний хүмүүс. Галд дүрэгдсэн хүмүүс!

БАПТИСМ БОЛООД БУСАД АЖИЛЛАГАА

АВРАЛЫН ДАРАА

Бид Ариун Сүнсээр авралыг хүлээн авч, дахин төрдөг. Гэхдээ үүгээр Ариун Сүнсний ажил дуусахгүй. Тэрбээр маш олон ажилтай. Тэр биднийг гэрчлэх хүчтэй болгодог. Сүнс доторх баптисм нь нигүүлслээр аврагдаж, дахин төрсөн хүмүүс шинэ үйл явдлаар туулж, Христийн төлөө Сүнсээр эрчлэгдсэн гэрч нар болж чадна гэсэн үг юм.

СОНГОЛТ БИШ

Ариун Сүнсний баптисм хэр зэрэг чухал вэ? Энэ нь өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөсөн дагалдагч нарт ч хүртэл зайлшгүй хэрэгтэй байв. Христ тэдний дэргэд байгаа нөхцөлд л тэд үүнийг хийх боломжтой байжээ. Эзэн Есүс тэднийг үйлчлэлийн талбарт гарч ажиллахаасаа өмнө Сүнсээр дүүрэх хүртлээ хүлээхийг айлдсан. Христийн ээж Мариа бол үүний нэг жишээ. Тэрбээр өөрт нь Есүсийг заяасан Ариун Сүнсний талаар гарцаагүй мэддэг байсан ч, мөн л “Аавын амлалтыг” буюу Ариун Сүнсний цааш цаашдын үйлсийг Иерусалимд хүлээсэн байдаг. Мариа тэгсэн бол, бид ч тэгэх ёстой (Үйлс 1:4).

ХҮЧЭЭР ДҮҮРСЭН

Дагалдагч нарыг хожмын аугаа хүмүүс болгосон нууц нь Есүсийг харж, Түүний дуу хоолойг нь сонссонд оршоогүй юм. Учир нь Түүнийг харж, сонссон хүмүүсийн “зарим нь итгэж, зарим нь эргэлзсэн (Матай 28:17, Марк 16:13-14, Лук 24:14). Энэ нууц нь Ариун Сүнсний баптисм билээ. Есүсээс хойш дагалдагч нар Иүдейчүүдээс айгаад, бүгдээрээ нэг газраа бүгээд, хаалгаа түгжсэн (Иохан 20:19). Юун тэр гудамжинд “Есүс амьд!” гэж хашхирах манатай. Тэд бүр Галилд нууцаар уулзаад, сүүлдээ бүр загасчилсан

(Иохан 21). Гэтэл энэ бүхэн нь Пентекост өдөр өөрчлөгдсөн юм. Тэд хурсан Иудейчүүдээс айх нь байтугай, Иудейчүүд дагалдагч нараас айж бэмбэгнээд: “Ахан дүүс минь, бид одоо яах ёстой вэ?” гэж хашхирсан юм. Яг л Есүсийн хэлснээр:

“Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно” (Үйлс 1:8).

ЭНЭ БҮХЭН АНХ ЯАЖ ӨРНӨСӨН БЭ?

ТЭНГЭРИЙН ДУУ

Одоо дөрөв дэхь зургийг харъя:

“Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газар цугласан байлаа. Хүчит хуй салхи мэт чимээ тэнгэрээс гэнэт гарч, тэдний сууж байсан байр бүхэлдээ үүнд автжээ. Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:1-4).

ХООСОН АМЛАЛТ БИШ

Юутай Тэнгэрлэг хүч, алдар вэ! Үйлс номын хоёрдугаар бүлэг нь нилээд үйл явдлаар дүүрэн, шуугиантай бүлэг шүү. Тэнгэрийн Аав маань биднийг горьдоож тохуурхахаар, хоосон амлалтаар хуураагүй. Христ “даян дэлхий рүү яв” гэсэн (Марк 16:15). Тэрхүү “галан хэлүүд” нь дагалдагч нарын толгойд шүргэхдээ, тэдний дотор “яв” гэдэг үйлдлийг суулгасан юм. Бурхан үйлдсэн, дараа нь дагалдагч нар үйлдсэн. Тэнгэрлэг үйлдэл нь хүний хариу үйлдлийг төрүүлсэн бөгөөд иймээс л энэ номыг Элч нарын үйлс гэдэг.

ХАЛИЛ

Дотогш тэнгэрийн цутгал буусан учраас, гадаад халил гэж байх ёстой. “Зүрх рүү нь голууд цутгахаас” гадна “зүрхнээс нь голууд урсана” (Иохан 7:38). Энэ үйл явдал нь сэтгэл мэдрэмжид зориулагдсан үйл явдал байсангүй. Дагалдагч нар “Ийм хүчээр дүүрэхийн тулд залбирлын цуглаан хийж байя” гэж хэлээгүй. Тэд ийм хүчний төлөө дахиж хэзээ ч асуугаагүй. Учир нь тэд хэдийнээ хүчтэй болсноо мэдсэн. Элч Петр Үзэсгэлэнт хаалганы дэргэд суунги хүнд “Би чамд өөрт байгаагаа л өгье” (Үйлс 3:6) гэжээ.

ГАЛТ САЙН МЭДЭЭ

Тэд мөн тайван суугаад, зөвлөхүүдийг томилж, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэж эхлээгүй. Тэд тайван суух аргагүй болчихоод байв! Тэд босоод, яваад, үйлдэхээс өөр аргагүй байсан. Петр яг л цахилгаан гүйдэлтэй мэт зогсож байсан. Тэгээд Христийнхэний эрин үе эхэлж, дэлхий анх Сайн мэдээний номлолыг сонссон. Энэ нь мэдээж Галт Сайн мэдээ байв.

ҮР ЖИМСТЭЙ САЙН МЭДЭЭ ДЭЛГЭРҮҮЛЭЛ

Тэгээд ямар үр дүн гарсан? Гурван мянган хүн аврал авсан. Пентекостын учир энэ байв. Үнэндээ Бурхан Өөрөө аврал, Сайн мэдээний төлөвлөгөөг гаргаж, гүйцэтгэсэн юм. Аав нь дээш өргөгдсөн Эзэнтэй маань нийлээд, алдагдсан дэлхийг аврахаар Сүнсээ илгээжээ (Исаиа 48:16). Сүнс доторх баптисмын гол зорилго нь энэ болой. Бурхан үүнийг л хийж байна - хүмүүсийг аварч байна. Тэгвэл бид юу хийж байна? Энэ баптисм нь биднийг баярлуулахын төлөө бус, харин биднийг Эзэнтэй гар нийлэн ажиллахад маань туслахын төлөө оршдог юм шүү. Есүс, Ариун Сүнс хоёр яагаад ирснийг бид мэднэ. Тэгвэл БИД яах гэж энд байна?

АРИУН СҮНСНИЙ ЯЛГАА

Пентекост өдөр! Урссан “голууд” нь эцэстээ Ромын эзэнт гүрнийг үерт автуулсан. Хүмүүс буцаад Анхны чуулганы үе шигээ байсан ч болоосой хэмээн санааширсан. Гэхдээ тэр үеийг цаг үе юмуу хүн онцгой болгоогүй, харин Ариун Сүнсний баптисм л онцгой болгосон билээ. Ариун Сүнсний баптисм байгаагүй бол, дагалдагч нар буцаад Галилдаа загасаа барьсаар өтөлж, залуу байхдаа үзсэн хачин жигтэй үйл явдлуудаа дурсан суух байсан биз ээ. Гэтэл тэд дэлхийг өөрчилдөг хүмүүс болсон юм. Энэ баптисмыг өнөөдөр бид бүгдээрээ хүлээн авч чадна.

ӨНӨӨДӨР Ч БОЛОМЖТОЙ

Зарим хүмүүс тэмдэг дагуулдаг Сүнс доторх баптисм нь “Чуулган байгуулагдах хүртэл” анхны итгэгч нарт л зориулагдсан зүйл байсан учраас, бид тэр гайхамшигт бэлэггүйгээр амьдарч сурах хэрэгтэй хэмээн итгэгч нарыг төөрөлдүүлдэг. Тэгвэл анхны итгэгч нар чинь элитүүд, харин бид чинь тэдний зиндаанд хүрэшгүй борчууд болох байх. Гэхдээ Библи дээр ийм санаа байхгүй. Энэ бол үл итгэлийн олж санаачилсан онол юм. Үнэндээ Паулыг Чуулган мэндэлснээс хойш 20 жилийн дараа Ефест очих үед 12 хүн Сүнс доторх баптисмыг хүлээн авсан байдаг (Үйлс 19:6, 7).

БҮХ ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАГДСАН ПЕНТЕКОСТ

Бүх үеийнхэнд Пентекост хэрэгтэй. МЭ 30 онд дэлхийн хүн ам нэг зуун сая байжээ. Гэтэл өнөөдөр долоон тэрбум давсан бөгөөд одоо ч хурдтай өссөөр байна. Нэгдүгээр зууны хүмүүсээс арав дахин их хүн Есүсийн тухай мэдэхгүй явж байна. Чуулган тарих хэрэгцээ их байна. Бурханд үл итгэх, Түүнийг үл тоох явдал хаа сайгүй байна. Тиймд бид ч Ариун Сүнсний хүчээр ангаж цангаж байна.

Тиймээс би танд тэр л баптисм өнөөдөр бидэнд боломжтой гэдгийг Библиэс Өөрөөс нь гаргацтай тайлбарлаж өгье. Пентекост өдөр хурсан олонд Сүнсний тосолгоогоор хэлсэн Петрийн номлолыг уншаад, тэрбээр Ариун Сүнс дотор хэн баптисм хийлгэж болно гэж хэлсэн байгааг үзнэ үү.

“Учир нь уг амлалт та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад байх бүгдийнх бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ” (Үйлс 2:39).

ТА НАРТ

Нэгдүгээрт - Петр “та нарт” гэж хэлсэн нь дөнгөж өмнө нь “тогтоосон шийдвэр ба урьдаас Бурханы мэдсэний дагуу тушаагдсан Түүнийг та нар хуульгүйчүүдийн гараар хадаж алсан” (Үйлс 2:23) хэмээн ялласан хүмүүсээ хэлж байгаа болно. Тийм боловч, Петр тэдэнд: “Гэмшигтүн, хүн бүр Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Ингэснээр та нарын нүгэл уучлагдаж бас та нар Ариун Сүнсний бэлгийг авах болно” (Үйлс 2:38) хэмээн мэдэгджээ. Тэд бол Есүсийн “Энэ үеийнхэн бол ёрын муу үеийнхэн” (Лук 11:29), “Итгэлгүй завхарсан үеийнхэн” (Матай 17:17, Лук 9:41) хэмээн дуудсан тэр хүмүүс билээ.

ТА НАРЫН ХҮҮХДҮҮДИЙНХ

Хоёрдугаарт - Петр “та нарын хүүхдүүдийнх” гэсэн буюу залгамжлах үеийнхэнийг нь нэрлэжээ. Зарим хүмүүс нилээд хожуу аав, ээж болно. Бүр Пентекост өдрөөс 100 жилийн дараа ч хүмүүс энэ ерөөлийг хүлээн авч, хэлээр ярина. Лук 2:36 дээр 84 жил бэлбэсэн явсан эмэгтэй гардаг. Гэтэл “хүүхдүүд” гэдэг үг нь зөвхөн тэдний гэр бүлийг нэрлэсэн үг бус мөн тэдний үр удмыг буюу Израилийн хүүхдүүдийг нэрлэсэн үг ажээ.

АЛСАД БАЙХ БҮГДИЙН ТӨЛӨӨ

Гуравдугаарт - Петр “алсад байх бүгдийн төлөө” гэж хэлэхдээ, Чуулганд Сайн мэдээг хүргээрэй хэмээн захирамжилсан дэлхийн хязгаар, газрын мухрыг заажээ (Матай 28:19, 20. Марк 16:15, 16). Энэ ажил нь элч нарын үеэс хойш маш олон жилийг авах болно. Жишээлбэл, Шинэ Зеланд бөмбөрцгийн аль нэг мухар нь байлаа гэж бодоход, тэнд дөнгөж 1814 онд л анхны илгээлтийн эзэд хөл тавьсан гэдэг. Үнэхээр өнөөдөр ч энэ даалгавар дуусаагүй байгаа тул бидэнд тэр хүч хэрэгтэй хэвээрээ л байна.

БИДНИЙ БУРХАН ЭЗЭНИЙ ДУУДСАН ХҮН БҮРИЙН ТӨЛӨӨ

Дөрөвдүгээрт - Петр “Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ” хэмээн базаж хэлжээ. “Бурханаар дуудагдсан” хүмүүс нь Христ рүү ирсэн хүмүүс юм. “Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг татахгүй л бол хэн ч Над уруу ирж чадахгүй” (Иохан 6:44). Бүх итгэгч нар дуудагдсан бөгөөд бүгдэд нь Петр тэргүүтэй 119 хүний хүлээн авсан Ариун Сүнсний тэр л бэлэг амлагджээ. Дагалдагч нарын хийснийг хий - тэгвэл дагалдагч нарын авсныг авна. Бурханы амлалт бидэнд бүгдэд маань өгөгдсөн гэдэгт итгэ. “Дарсанд бүү согтуур. Эс бөгөөс хэт самуурал буй. Харин Сүнсээр дүүр” (Ефес 5:18).

ШУУД ЕСҮСЭЭС

Зөвхөн Баптисм хийгч Есүсээс өөр хэн ч биш. Хоёрдагч үйл явдлыг бүү эрэн хай. Өөрийнхөө Пентекостыг ав. Карисматик уулзалт дээр хэн нэг хүний туршлагыг худалдаж авах гэж бүү оролд. Ариун Сүнсний гал нь хүмүүсийг гоё, гоё конференц шиг нэг дор бөөгнүүлж байгаад, нийтэд нь нэг том галаар юулж, дулаацуулаагүй, харин ч “хүн нэг бүр дээр” бяцхан дөлүүд шиг “хэлээр” бууж ирсэн байдаг. Энэ маш чухал шүү. Тэдгээр галан хэлүүд нь хүмүүсийг хаашаа ч явсан хамт хөдөлдөг, маш хүчирхэг цахилгаан станцууд билээ.

СҮНСТЭЙ ХАМТ ДҮРЭЛЗЭХ

Бид сүнсээр харанхуй, хүйтэн дэлхийд аж төрж байна. Хөлдөхгүй байх хамгийн зөв арга нь Ариун Сүнстэй хамт дүрэлзэх юм. Бурхан тахилын ширээн дээр таны зүрхний галыг асааж, тийнхүү та асаагуур болох юм. Хүмүүс таныг дулаацуулна гэж харалгүй, бусдыг дулаацуул!

ХОЁРДУГААР ХЭСЭГ: АРИУН СҮНС ДОТОРХ БАПТИСМ - ХЭРХЭН ХҮЛЭЭЖ АВАХ ВЭ?

Ариун Сүнсний ийм нандин бэлэгийг хүлээж авах их л хэцүү байх гэж бодогдож байгаа байх. Тэгвэл харин ч эсрэгээрээ - маш амархан билээ. Та яг одоо байгаа газартаа Ариун Сүнс дотох баптисмыг хүлээн авч чадна. Энэ хичээлээр би танд Ариун Сүнснийг хэрхэн хүлээж авахыг маш энгийнээр зааж өгье.

ӨГЛӨГИЙН ЭЗЭНД ИТГЭХ

Мянга мянган үл итгэгч хүмүүс манай кампанит цуглаанд хүрэлцэн ирдэг. Зарим нь Бурханаас дэндүү хол хүмүүс: ёрын муу, завхарсан, донтой, нууц шүтлэгт боолчлогдсон эсвэл өөрт нь ямар ч ашиггүй шашны төлөө махаа идэн зүтгэдэг хүмүүс. Тэд хамгийн түрүүнд аврал авах ёстой. Паул тухайн үеийнхээ итгэсэн хүмүүст “Та нар угаагдсан” (1Коринт 6:11) гэж хэлсэн. Магадгүй өмнө нь тэдний биеийг цэвэр бус сүнс эзэлж байсан байх. Гэтэл яг ийм зуу зуун, мянга мянган хүн Ариун Сүнсний сүм болохыг бид хардаг. Яаж? Хоёрхон нөхцөл л бий: Нэгдүгээрт - гэмших. Хоёрдугаарт - Эзэн Есүс Христэд итгэх.

Гэмшигтүн, хүн бүр Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Ингэснээр та нарын нүгэл уучлагдаж бас та нар Ариун Сүнсний бэлгийг авах болно (Үйлс 2:38).

ГЭМШИЛ

Есүс “Би Эцэгээс гуйхад Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. ...ертөнц Түүнийг хүлээн авч чадахгүй” (Иохан 14:16, 17) гэсэн. Петр “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ. Тэгвэл сэргээх цаг Эзэний оршихуйгаас ирэх бөгөөд... Ингэснээр та нарын нүгэл уучлагдаж бас та нар Ариун Сүнсний бэлгийг авах болно” (Үйлс 3:19, 2:38) гэсэн.

АРИУН БЭЛЭГ

Ариун Сүнс бол ариун Нэгэн. Библи Ариун Сүнсийг тагтаагаар дүрсэлдэг. Тагтаа нь овоолсон баасан дээр үүрээ барьдаггүй, цэвэр шувуу. Ариун Сүнс нүгэлтэй амьдралд суурьшихгүй. Тэр маш мэдрэг. Тэнгэрлэг ус нь бохир сувгаар урсахгүй - бохир бодлоор ч, бохир амаар ч.

ЦУСААР УГААГДСАН

Ариун Сүнс нь гагцхүү Бурханы цусаар угаагдсан хөвгүүд, охидод л зориулагдсан билээ. Голготын оргилуурт цэвэрлэгдэхээс нааш хэн ч хангалттай сайн байж чадахгүй. Цус галын өмнө орно. Өөр ямар ч цэвэрлэгээ шаардлагагүй бас боломжгүй. Бид Есүсийн цус биднийг болгож өгснөөс илүү ариун юмуу зохистой болж чадахгүй. Ариун Сүнс бол бэлэг бөгөөд Түүнийг буян гавьяагаар олохгүй.

ИТГЭЛ

“Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурханд ойртон буй нь Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” (Еврей 11:6).

“Есүст итгэгсдийн хүлээн авах Сүнсний тухай Тэр

үүнийг хэлжээ. Есүс хараахан алдаршуулагдаагүй тул Сүнс тэнд өгөгдөөгүй байлаа” (Иохан 7:39).

“Мунхаг галатчууд аа, хэн та нарыг ховсдов? Та нар Сүнсийг хэрхэн хүлээн авсан юм бэ? Хуулийн үйлсээр үү? Эсвэл сонссондоо итгэснээр үү? Зөвхөн үүнийг л та нараас мэдэхийг би хүсэж байна” (Галат 3:1-2).

ЗОРИГТОЙ ОЧ

Есүс дээр гуйж, гувшиж очих нь ямар ч итгэл байхгүйн шинж. ИТГЭЛД АВАХ ҮЙЛ БАГТАНА. Та Есүсийг жаахан элэгсэг байж, танд Ариун гал дотроо баптисм хийгээч хэмээн ятгах шаардлагагүй. Тэр хэдийнээ амласан. Түүний танд өгөх гэж байгаа зүйлийг зүгээр л зоригтой очоод ав. Энэ чинь бэлэг. Тиймээс Өглөгийн эзэний өгч байгаа зүйлийг авахын өмнө эхлээд Түүнд итгэх ёстой.

ЦААШИД СААТАХГҮЙ

“Иерусалимд хүлээх” тухайд яах уу? Есүс дагаладагч нартаа хүлээ гэж хэлсэн нь “Есүс хараахан алдаршуулагдаагүй тул Сүнс тэнд өгөгдөөгүй байжээ” (Иохан 7:39). Тэд түүхэн цаг хугацааг хүлээх хэрэгтэй байв. ГЭХДЭЭ ТЭР ОДОО ЭНД БАЙНА. Пентекост нь бодит баримт бөгөөд та үүнийг хувьчлан эдэлж чадна. Бидэнд гуйх цуглаан биш, гагцхүү хүлээн авах цуглаан л хэрэгтэй. Есүс Үгээ бидний амьдралд биелүүлэх дуртай. Бид чинь гуйлгачин биш, итгэгчид шүү дээ.

АРИУН ХЭЛ

Бид Сүнс доторх анхдагч баптисмыг хүлээн авах үед анхдагч тэмдгүүд нь дагалдана.

“Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:4).

Яаж тэр үү? 120 дагалдагч Эзэнийг магтаж байтал, “исгэрэх хуй салхи” (Үйлс 2:2), галан хэлүүд бууж, тэдний зүрх баяр хөөрөөр тэсэрсэн. Тэд амаа нээгээд ярих гэтэл, Ариун Сүнс тэдний мэдэхгүй хэлийг өгчээ. Тэгээд л боллоо.

АДИЛХАН ҮР НӨЛӨӨ

Бид адилхан баптисмыг хүлээн авбал, адилхан үр нөлөө л дагуулах ёстой. Баптисм хийгч Есүс ч өөрчлөгдөөгүй, Түүний арга барил ч өөрчлөгдөөгүй. Бурханы хаанчлал дотор бид хуулбараас авсан хуулбар бус, харин Анхдагч - ЕСҮС ХРИСТЭЭС гарсан анхдагч юм. Бид Ариун Сүнс доторх баптисмыг шавхруунаас нь бус, харин эхээс нь хүлээн авна.

ХЭЛҮҮД

Хэлээр ярих чадварын талаар Үйлс ном тэр чигээрээ өгүүлдэг.

Харийнхан дээр бас Ариун Сүнсний бэлэг асгарахыг хозлуулсан итгэгчид болох, Петртэй хамт ирсэн бүх хүн хараад гайхацгаажээ. Учир нь тэд хэл ярихуйгаар ярьж, Бурханыг дээдлэн байгаа нь сонсдов (Үйлс 10:45-46).

Элч нар хэлээр ярихыг Сүнс доторх баптисмын нотолгоо хэмээн үзжээ. Илбэчин Симон Сүнсний энэ ер бусын илрэлийг харсан (Үйлс 8:17-19). Паул баптисмыг хүлээн аваад (Үйлс 9:17), өөрийгөө хэлээр ярьсан гэсэн (Үйлс 11:17, 13:52, 19:6).

Пентекост өдөр Петр болж буй бүхнийг Иоелийн үгийг эшлэн байж тайлбарласан (Үйлс 2:17-19). Хүмүүс эш үзүүлэх талаар Иоел зөгнөсөн байдаг. Хүмүүс хэлээр ярихад, Петр “Энэ нь эш үзүүлэгч Иоелээр дамжуулан” (Үйлс 2:16) хэлсэн зүйл болохыг хэлжээ. Хэлээр ярихыг хөрвүүлэх нь эш үзүүлэл юм.

МЭДРЭГДЭХҮЙЦ ТЭМДЭГ

Биднийг яваад, Сайн мэдээг номлох үед Ариун Сүнс бидний дотор бөгөөд дээр оршин байгааг батлах, үүнээс илүү Бурханы баталгаа - тэмдэг байх уу? Биднийг Паул шиг л мөхөсдөж, айж, дарамтад орох үед (1Коринт 2:3) хэлний гайхамшиг өөрийгөө харуулдаг. Гадаад илрэл байхгүй бол, бид хэзээ ч бат итгэлтэй байж чадахгүй, мөнхөд залбирсаар үлдэх байсан.

АРИУН СҮНСНИЙ НУУЦ КОД

Энэ бол гайхалтай зүйл! Паул хэлээр ярихыг Бурханд нууцыг ярих явдал гэсэн (1Коринт 14:2). Хэл нь Диаволын ойлгож чадахгүй цорын ганц хэл юм. Эргэлзүүлэгч нарын тэргүүн - Дьявол нь Ариун Сүнсний цагаан толгойг мэдэхгүй учраас, юу ч үгүй самуурч гүйцдэг. Сатан тэнгэрийн сэнтийтэй холбоотой Ариун Сүнсний нууц кодыг тайлж чадахгүй.

ЗАЛБИРАХАД ЗОРИУЛАГДСАН

Бидний бие “Ариун Сүнсний сүм” (1Коринт 6:19) болой. Есүс сүмийг залбирлын гэр гэсэн (Матай 21:13, Марк 11:17). Хэрэв бидний бие Ариун Сүнсний оршдог сүм - залбирлын өргөө юм бол, Тэрбээр биднээр дамжуулан Бурханы сэнтийд хүрэх хүчирхэг, цэвэр залбирлыг хэлэх болно. Сүнс залбирах дуртай учраас Сүнсээр дүүрэн хүмүүс залбирахыг хүсдэг. Энэ нь гашуун үүрэг биш, харин жавхланта таалал завшаан билээ. Есүс “Харин үнэний Сүнс ирэхдээ... Намайг алдаршуулна” гэжээ.

ПЕНТЕКОСТЫН ТЭМДЭГ

Соломон Сүмийг даатгах үед Бурханы ил алдрын “шекина” гэрэл Ариунаас ариун газрын Өршөөлийн алтан суудал дээр туссан

байдаг. Соломоныг залбирсны дараа танхимын гаднах Ариун газар алдраар битүү дүүрч, тахилч нар орж ч чадахгүй, шалан дээр хүндэтгэн, талархаж хэвтсэн (2Шастир 7:1-3).

БҮРЭН ЭХЭЭР НЬ

Биднийг аврагдахад, Христийн гэрэл бидний дотоод зүрхний ариун газарт суурьшдаг ч, Ариун Сүнс бууж ирэхдээ бидний бүхэл оршихуй болох сүнс, сэтгэл, оюун, биеийг нэвтэлдэг. Тэр үерлэн орж ирээд, биднийг бүрэн эхээр маань булхан, баптисм хийдэг.

АСУУ, ХАЙ, ТОГШ

Эцэст нь гуй - тэгээд л боллоо. Бид Есүсийн аврагч цусаар цэвэрлүүлэхдээ, Бурханы хүүхдүүд болдог. Ариун Сүнсний баптисм нь бидний ууган хүүгийн эрх болдог. Есүс чухам энэ бэлэгийн тал дээр биднийг онцгой ятгадаг. “Би та нарт хэлье. Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. Гуйдаг бүр авна, эрж хайдаг нь олно, тогшдогт нээгдэнэ” (Лук 1:6). “Ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг” (Иаков 1:6).

ХУЛХИ ЮМ БАЙХГҮЙ

Бидний хүлээн авах зүйл нь гагцхүү Бурханаас л байх болно. Есүсийн нэрээр залбирсан залбиралд Диавол хэзээ ч хариулж чадахгүй. Биднийг тэнгэрийн Ааваасаа Ариун Сүнсийг гуйж байхад, Диавол бидний шууд холбоонд хөндлөнгөөс оролцох ямар ч боломжгүй. Ямар ч чөтгөр Ариун Сүнсний дүрээр ирээд, Ариун Сүнсийг дууриаж чадахгүй. Лук 11:11-13-ыг уншина уу:

Хүүгээ загас гуйхад оронд нь могой өгдөг хүн та нарын дунд байна уу? Эсвэл өндөг гуйхад нь хилэнцэт хорхой

өгнө гэж үү? Та нар ёрын муу атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг бол тэр тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйгсдад Ариун Сүнсийг өгөх нь лавтай бус уу?

Энэ бол эцсийн хариулт. Үүнээс илүү баталгаа үгүй.

ТА ОДОО ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?


Та одоо номоо уншиж дуусгасан учраас, Эзэн таны амьдралд юу хийхийг хүсч байгааг мэдлэг боллоо: Ариун Сүнсээрээ баптисм хийхийг хүсч байна. ЕСҮС - ЕСҮС ганцаараа л баптисм хийдгийг санаарай (Иохан 1:33). Тэр яг одоо тантай хамт байна.

Хэрэв та Есүсийг Эзэнээ бөгөөд Аврагчаа болгосон бол, нүгэл чинь өршөөгджээ. Та Түүний сүр жавхлантай бэлэгийг хүлээж авах эрхтэй болохын тулд Бурханы Хурганы цусаар угаагдаж, бүх нүглээсээ цэвэршсэн байна. Танд онцгой цуглаан ч хэрэггүй. Есүс яг одоо тантай хамт байна. Түүний нэрийг магтаж эхэл. Эзэнийг хүндэтгэж, нэрийг нь магт. Тэгээд Есүс Христ танд Ариун Сүнсээрээ бөгөөд галаар баптисм хийнэ.

Анхны Христэд итгэдэг хүмүүст байсан тэр зүйл танд ч, бүгдэд ч боломжтой. Учир нь Есүс та бүхэнд хайртай. Есүс биднээр гуйлгаж, гувшуулж байж үүнийг хийдэггүй гэдгийг санаарай. Ятгасан ятгаагүй, Есүс танд угаас хайртай. Тиймдээ ч Ариун Сүнсээрээ одоо... **ЯГ ОДОО ТАНД БАПТИСМ ХИЙНЭ!**

ЯГ ОДОО!

Тэгэхээр, Эзэн Есүс минь ээ, 120 дагалдагч Ариун Сүнсээр дүүрэхэд бий болсон тэр зүйлийг над дээр бий болгооч. “Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн хамт ажиллаж, дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байлаа” гэж Марк 16:20 дээр хэлдэг. Би хүлээлгүй, харин зүгээр л Таны хүч, заавар, засварыг хүлээн авч байна. Таны тосолгоонд баярлалаа. Аав алдаршихын төлөө мөнх бус уруулаар маань Таны мөнхийн Сайн мэдээ гарч, мөнх бус гараар маань Таны мөнхийн Хаанчлал байгуулагдах болтугай. Даян дэлхий аврагдах болтугай! Есүсийн нэрээр. Амень.





САЙН МЭДЭЭ ДЭЛГЭРҮҮЛЭГЧ РЕЙНХАРД БОННКЕГИЙН

“REINHARD BONNKE” НЭРТЭЙ АЛБАН ЁСНЫ ФЭЙСБУУК

ХУУДСААР ЗОЧИЛЖ, *өдөр бүр Бурханы*
СЭНТИЙГЭЭС ҮГ ХҮЛЭЭЖ АВААРАЙ!



Сайн мэдээ

дэлгэрүүлэх ажил нь галт дөрвөн дээрээс

дүрэлзэх Сайн мэдээний номлогчийг суулгасан,

шатаж буй хөтчөөр залуулсан галт хөсөг тэрэг мөн!

ӨНӨӨДӨР АЙЛЧЛААРАЙ!

САЙН МЭДЭЭ ДЭЛГЭРҮҮЛЭХ АЖИЛ НЬ ГАЛТ ДӨРӨӨН ДЭЭРЭЭС ДҮРЭЛЗЭХ САЙН МЭДЭЭНИЙ НОМЛОГЧИЙГ СУУЛГАСАН, ШАТАЖ БУЙ ХӨТЧӨӨР ЗАЛУУЛСАН ГАЛТ ХӨСӨГ ТЭРЭГ МӨН!

РЕЙНХАРД БОННКЕ

Та шатамхай байна уу эсвэл галт тэсвэртэй байна уу? Энэ бол Ариун Сүнсний тухай өгүүлэл. Сайн мэдээ дэлгэрүүлэгч Рейнхард Боннкегийн амжилтын нууц нь чухам Ариун Сүнс болохыг тэрбээр тангтай хуваалцжээ. Боннке 50 илүү жилийнхээ үйлчлэлийн тулгуур чулуу болсоор ирсэн Ариун Сүнсний талаарх няцаашгүй, аугаа үнэнээс дэлгэж байна. Илгээлтийн талбар дээрх хамгийн эгзэгтэй цаг үе, улиралдаа сурсан эдгээр үнэн буюу “Ариун Сүнсний галт зарчим” нь Ариун Сүнсний ер бусын хүч, бэлэг дотор л ажиллаж амьдрахыг хүсдэг итгэгч, үйлчлэгч нарын хувьд Ариун Сүнсний талаарх маргашгүй, гүн сургамжийг тээнэ.

Энэхүү номд та Рейнхард Боннкегийн Ариун Сүнсний талаарх теологи, итгэлтэй тулгарна. Сэргээм, бадрангүй эдгээр үзэл нь Бурханы Ариун Сүнсний талаарх таны үзэл бодлыг дахин сэгсэрч сэрээх байх. Та үр жимстэй, амьд үйлчлэлтэй юмуу итгэлийн амьдралтай байхыг хүсвэл энэ ном таны унших ёстой номын л нэг. Ариун Сүнсний баптисм нь Сайн мэдээний галаар бөмбөрцгийг гэрэлтүүлэх нууц “түлхүүр” байсаар л байна. Харин аль зэрэг өөрчлөлт гарах нь Ариун Сүнсний талаарх бидний мэдлэг, Ариун Сүнсэнд хандах бидний хариу үйлдэл, Ариун Сүнсэнд итгэх бидний итгэлээс шалтгаалж, Ариун Сүнсийг аль зэрэг урьж, Түүний хүчийг аль зэрэг ажиллуулахаас л хамаарна.



Сайн мэдээ дэлгэрүүлэгч Рейнхард Боннке нь Африк тивээр бөгөөд дэлхий даяар Сайн мэдээний том том аян зохион байгуулдаг “Christ for all Nations” үйлчлэлийн үндэслэн байгуулагч бөгөөд эдүгээ тус үйлчлэлийг нь Сайн мэдээ дэлгэрүүлэгч Даниел Коленда залгамжлан авч явж байгаа болно. Боннке нь аврал, эдгэрлийн хүчирхэг тосолгоо дор үйлчилдэг, Сайн мэдээний төлөө зүрх сэтгэлтэй хүн юм. Үүнээс гадна тэрбээр *Evangelism by Fire, Holy Spirit Revelation and Revolution* зэрэг дэлхийн олон хэл дээр орчуулагдаж, хэдэн сая хувиар хэвлэгдсэн маш олон алдартай номын зохиогч билээ. Боннке нь гэргий

Эннитэйгээ гурван хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд өдгөө тэд найман ач зээтэй өнөр бүл болжээ.

Та бүхэн ReihardBonnke.com хаягаар заавал зочлоорой.

CfAN CHRIST
FOR ALL NATIONS
CfaN.org



Рейнхард
Боннкег
дагаарай

Энэхүү ном нь зохиогчийн бэлэг бөгөөд
худалдан борлуулахыг хориглоно.